



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 9



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 9

Улаанбаатар, 2023

ННА 67.3
ДАА 340.009
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 9

СУДЛААЧИД:

1. Б.Амарсанаа, С.Батбаяр, Г.Цагаанбаяр
2. Г.Давааням, Г.Уянга

Дугаар хариуцсан редактор Д.Золжаргал

© Нээлттэй Нийгэм Форум, 2023.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9926-7-5

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 9



1

ЦАХИМ ХЭЛЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН
ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН
ДҮН ШИНЖИЛГЭЭ

9

2

ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧ, ТӨЛӨӨЛӨГЧ,
КОМИССЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

87

ӨМНӨХ ҮГ

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын ес дэх дугаарт иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй холбоотой хоёр тайланг танилцуулж байна.

Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор Б.Амарсанаа ахлагчтай судалгааны баг шүүх цахим хэлцэлтэй холбоотой маргаан шийдвэрлэсэн байдлыг судаллаа. Цахимд эрчимтэй шилжиж байгаа энэ цаг үед шүүхийн практикт цахим хэлцэл, гэрээний талаарх хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэглэх, нухацтай судлан шинжлэх явдал тулгамдаж байна. Хойшид улам бүр нэмэгдэх төлөвтэй энэхүү маргааны төрлийг судалгааны баг судлан, манай улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал төдийгүй шинэ тутам үүсэж болзошгүй асуудлыг тодорхойлжээ.

МУ-ын Иргэний хуулийн 413-419 дүгээр зүйлд худалдааны төлөөлөгч, зуучлагч, комиссын харилцааны талаар зохицуулсан бөгөөд шүүхэд эдгээр зохицуулалтыг хэрхэн хэрэглэж байгааг “Сайн туршлага” ТББ-ын судлаач, МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Г.Давааням, хуульч Г.Уянга нар судалсан болно. Шүүхийн практикт худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комисс гэрээг өөр хооронд нь болон бусад төсөөтэй гэрээнээс тэр бүр ялгаж чадахгүй байгааг онцолж, цаашид холбогдох хуулийн зохицуулалтыг оновчтой хэрэглэх талаар тодорхой зөвлөмж санал болгожээ.

Хэдийгээр шүүхийн практикт түгээмэл тохиолдох маргаан биш хэдий ч худалдаа, арилжааны харилцаанд түгээмэл хэрэглэх болсны хэрээр энэ төрлийн маргаан нэмэгдэх төлөвтэй байгааг анзаарч, уг асуудлыг сонгон авч судалсан судлаачдадаа болон эдгээр судалгааны тайланд шүүмж өгөн, хянан тохиолдуулсан редактор Д.Золжаргалд гүн талархал илэрхийлье.

ННФ-ын хэвлэн нийтэлсэн судалгаа, шинжилгээний тайлан, мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас авч танилцах болон бусдад түгээх боломжтой.

ННФ-ын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

РЕДАКЦЫН ЗУРВАС

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал өдрөөс өдөрт өөрчлөгдөж, улмаар иргэд хоорондын арилжаа, гүйлгээний төрөл, агуулга 2002 онд батлагдсан Иргэний хуулийн хүрээнээс халих боллоо. Тухайлбал, арилжааны эрх зүйн асуудлын хэт ерөнхийлсөн зохицуулалт нь энэ цаг үед хэрэглээний шаардлагыг хангахгүй болжээ. Энэ нь арилжааны эрх зүйн орчныг сайжруулах, цаашлаад уг харилцаанд оролцогчдын хүлээлт хийгээд хариуцлага зэргийг эргэн харж, нийтэд илүү ойлгомжтой тодорхойлох бодит шаардлага бий болж байна.

Энэхүү байдлыг соргоогоор анзааран харж, мэдлэг, оюун, цаг заваа зарцуулан судалгаа хийж буй судлаач-хуульчдын хувь нэмрийг үнэлж баршгүй.

“Нээлттэй Нийгэм Форум” ТББ-ын Монгол Улсын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд судлаачдын Иргэний эрх зүйн чиглэлээр шүүхээс гарсан шийдвэрт 2021 онд хийсэн хоёр дүн шинжилгээний тайланг энэ цувралд багтаав.

Судлаач Б.Амарсанаа, С.Батбаяр, Г.Цагаанбаяр нар цахим хэлцэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн зарим шийдвэрийг шинжлэн дүгнэжээ. Дэлхий нийтийн жишгээр Монгол улс цахимд эрчимтэй шилжиж буй энэ үед цахим гэрээ, хэлцлээс үүдсэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг шинжилж дүгнэсэн судалгаа нь үнэхээр цаг үеэ олсон байна. Тэр тусмаа Монгол Улсын Иргэний хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг,

зээлийн үйл ажиллагааны тухай хуульд зарим цахим хэлцлийн зохицуулалтыг тусгаж өгсөн нь манай улс энэ төрлийн хэлцлийг хүлээн зөвшөөрч, улмаар иргэний харилцаанд хэрэглэж болох эрх зүйн үндэслэлийн суурийг тавиад буй энэ цаг үед ихээхэн ач холбогдолтой судалгаа болсон байна.

Цахим хэлцэл нь Иргэний хуульд заасан аман болон бичгийн хэлцлийн алинд хамаарах, эсвэл бие даасан хэлцлийн төрөл үү, цахим хэлцэл тусгайлан ямар шаардлага хангах тохиолдолд хүчин төгөлдөрт тооцогдох вэ? гэдгээс үүдсэн нотолгооны талаарх асуудал зэргийг эрх зүйн онол, хууль эрх зүйн зохицуулалтын талаас нь шүүхийн шийдвэрийг шинжлэн дүгнэж, цаашлаад 2011, 2021 онд Иргэний хуульд орсон цахим хэлцлийн талаарх зохицуулалт хангалтгүй, амьдралд хэрэгжих, нэг мөр хэрэглэхэд учир дутагдалтай байгаа талаар судлаачид байр сууриа илэрхийлжээ. Ингэхдээ цахим хэлцлийн хүрээнд хэрэглэгчдийн эрхийг хэрхэн хамгаалах талаарх Япон Улсын туршлагыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулж, манай улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал ба цаашид шинэ тутам үүсэж болзошгүй асуудлыг тодорхойлохыг зорьсныг та бүхэн хүлээн авна уу.

Судлаач Г.Давааням, Г.Уянга нар Иргэний хуулийн 413-419 дүгээр зүйл дэх худалдааны зуучлагч, төлөөлөгч, комиссын гэрээний эрх зүйн зохицуулалт, түүний хэрэглээний талаар судалжээ. Судалгааг Ром-Германы эрх зүйн тогтолцоон дахь худалдааны зуучлагч, төлөөлөгч, комиссын гэрээний онол, эрх зүйн зохицуулалтыг Монгол, Япон ХБНГУ-ын холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд харьцуулахын зэрэгцээ Монгол Улсын шүүхийн зарим шийдвэрийг шинжлэн, дүгнэх байдлаар хийсэн байна.

Бусдын өмнөөс тодорхой үйлдэл хийх хэлцлийн ерөнхий агуулгын хүрээнд хоорондоо төстэй боловч илт ялгаатай үр дагавар бүхий гэрээний төрлүүд атал шүүхээс худалдааны зуучлагч, төлөөлөгч, комиссын гэрээтэй холбоотой маргааныг

шийдвэрлэхдээ зохигчдын дунд чухам аль гэрээний харилцаа үүссэн гэдгийг анхлан тогтоож, тодорхойлдоггүйгээс гэрээнд оролцогч тус бүрийн эрх, үүрэг, эрсдэлийн шилжилт, хүлээлт, хариуцлагыг хооронд нь холих, солих улмаар буруу шийдвэр гаргах явдал олонтоо тохиолдож буйг судлаачид гарган тавьсан байна.

Иймд ямар тохиолдолд аль гэрээний агуулгад хамааруулан зохих зохицуулалтыг хэрэглэх талаар онол, хуулийн харьцуулсан судалгаанд үндэслэн практик ач холбогдол бүхий санал дэвшүүлсэнтэй танилцана уу.

Нийт судлаачдадаа цаашдын эрдмийн ажилд нь амжилт ерөөн, судлаачдын үзэл бодол, судалгааны эрх чөлөөг хүндэтгэхийг нийт уншигчдаасаа хүсье.

Хүндэтгэсэн
Д.Золжаргал

1

ЦАХИМ ХЭЛЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



БАТБОЛДЫН АМАРСАНАА

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, профессор

Профессор Б.Амарсанаа нь 1999 оноос хойш МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, дэд профессор, Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан бөгөөд 2021 оноос тус сургуулийн захирлаар тус тус ажиллаж байна. Тэрээр хувийн эрх зүйн салбар, тэр дундаа арилжааны эрх зүй, компанийн эрх зүй, компанийн засаглалын чиглэлээр мэргэшин судалж, сүүлийн жилүүдэд Монгол Улсад арилжааны эрх зүйг хөгжүүлэхэд голлон анхаарч ажиллаж байна.



САРАНГЭРЭЛИЙН БАТБАЯР

МУИС-Хууль зүйн сургууль, Хувийн эрх зүйн тэнхимийн багш, Япон Улсын Кюүшүгийн их сургуулийн судлаач, докторант

С.Батбаяр нь 2012-2015 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнд бодлогын судлаач, 2016 оноос МУИС-Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багшаар ажиллахын зэрэгцээ Япон улсын Кюүшүгийн их сургуулийн докторантурт суралцаж, Япон улсын Шинжлэх ухааны хөгжлийг дэмжих нийгэмлэг (Japan Society for the Promotion of Science)-ийн судлаачаар ажиллаж байна. Тэрээр арилжааны эрх зүй, компанийн эрх зүй, үнэт цаасны эрх зүйн чиглэлээр мэргэшин судалж байгаа бөгөөд бие дааж болон хамтран эрдэм шинжилгээний 30 гаруй судалгаа, 20 гаруй илтгэл, өгүүллийг дотоодын болон гадаадын сэтгүүлд хэвлүүлжээ.

Судлаачид:

Б.Амарсанаа (LL.D)

С.Батбаяр (LL.M)

Г.Цагаанбаяр

(LL.M)



ГАНПҮРЭВИЙН ЦАГААНБАЯР

“Баяр энд Ока Партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал,
өмгөөлөгч

Г.Цагаанбаяр нь МУИС-ийн ХЗС-ийг эрх зүйч мэргэжлээр төгссөн бөгөөд МУИС-ийн ХЗС болон Японы Фүкүокагийн их сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалжээ. Хууль зүйн үндэсний хүрээлэнд бодлогын судлаач, өмгөөллийн “Де Юре Партнерс” ХХН-ийн гишүүн өмгөөлөгчөөр ажиллаж байв. 2021 оноос “Баяр энд Ока Партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгчөөр ажиллахын зэрэгцээ арилжааны болон шүүхийн эрх зүйн чиглэлээр тогтмол судалгаа хийж байна.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	15
УДИРТГАЛ	16
Судалгааны хүрээ, арга зүй.....	18
 НЭГ. ЦАХИМ ХЭЛЦЭЛ БА МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	20
1.1. Хэлцэл ба цахим хэлцийн тухай.....	20
1.2. Цахим хэлцлийн онцлог ба ач холбогдол	23
1.3. Монгол Улс дахь цахим хэлцлийн эрх зүйн зохицуулалт	25
А. Иргэний хуулийн өөрчлөлт.....	26
Б. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль.....	28
В. Цахим гарын үсгийн тухай хууль.....	31
Г. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенцыг соёрхон батлах тухай хууль	33
1.4. Цахим хэлцлийн талаарх онцлог зохицуулалт	36
А. Цахим хэлцэл дэх хэрэглэгчийн эрхийн хамгаалалт ба аж ахуй эрхлэгчийн хүлээх үүрэг.....	38
Б. Цахимаар гэрээ байгуулах хугацаа	42

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	47
2.1. Цахим гэрээг байгуулахаас өмнө бичгээр өөр гэрээ байгуулсан байх урьдчилсан нөхцөлийг шүүх үнэлж, дүгнэсэн байдал.....	47
2.2. Цахим гэрээний хэлбэр, түүний хүчин төгөлдөр байдлыг шүүх үнэлж дүгнэсэн байдал.....	55
2.3. Шүүхээс цахим хэлцлийг нотлох баримтад тооцох, үнэлэлт дүгнэлт өгөх байдал.....	59
2.4. ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийг ялгаатай хэрэглэж буй байдал.....	61
2.5. Ерөнхий хууль ба нарийвчилсан хуулийн хэрэглээний асуудал.....	65
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	69
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	77

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БЭБЭМХТТЗҮАтХ	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль ¹
ИХ	Монгол Улсын Иргэний хууль (2002)
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль (2002)
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УДШ	Улсын Дээд Шүүх
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
B2B	Business to Business (Бизнес эрхлэгч ба бизнес эрхлэгч хоорондын харилцаа)
B2C	Business to Consumer (Бизнес эрхлэгч ба хэрэглэгч хоорондын харилцаа)
C2C	Consumer to Consumer (Хэрэглэгч ба хэрэглэгчийн хоорондын харилцаа)

¹ Тус хууль нь 2021.5.21-ний өдрийн "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль"-аар хүчингүй болж 2021.5.21-ний өдөр "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийг шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль" /шинэчилсэн найруулга/ нэртэйгээр шинэчлэн батлагдсан.

УДИРТГАЛ²

Орчин үеийн техник, технологийн үсрэнгүй хөгжлийг дагалдан бидний уламжлалт буюу нэгэнт хэвшсэн амьдралын хэв маяг хийгээд бизнесийн орчин, нөхцөл богино хугацаанд хурдацтай хувьсан өөрчлөгдөж байна. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд *digital transformation* буюу цахим шилжилт хурцаар яригдах боллоо. Энэхүү цахим шилжилтийн үр дагавар нь хууль зүйн салбарыг ч тойрон гарахгүй бөгөөд өдөр тутамдаа цахим арга хэрэгслийг ашиглан эрх зүйн харилцаанд оролцох нь бидний амьдралын салшгүй нэг хэсэг болжээ.

Иргэний эрх зүйн уламжлалт ойлголтоор гэрээ, хэлцлийг аман болон бичгийн буюу цаасан хэлбэрээр байгуулж, тухайн гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх замаар эдийн засгийн үйл ажиллагаанд (*economic activity*) оролцдог байсан бол хэдийнээ цахим хэлцэл буюу тодорхой техникийн арга хэрэгслээр дамжуулан гэрээний санал гаргах, нөгөө тал нь тус саналыг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулах боломжтой болж, цахимаар гэрээ хэлцэл хийх нь нэн түгээмэл болжээ. Гэтэл хууль зүйн үүднээс зөвхөн нэг удаагийн бараа бүтээгдэхүүн худалдан авах захиалгыг цахимаар хийхэд хэд хэдэн төрлийн гэрээний харилцаа үүсэх нарийн төвөгтэй шат дамжлагатай байдаг.

² Энэхүү судалгааг Нээлттэй нийгэм форум ТББ-ын шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийх судалгааны төслийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд Судалгааны багийн зүгээс Нээлттэй нийгэм форум ТББ-ын хамт олонд талархал илэрхийлье.

Тиймээс 2011 онд Монгол Улсын Иргэний хууль (цаашид “ИХ” гэх)-д орсон нэмэлт өөрчлөлтөөр хэлцлийг аман болон цаасан суурьтай бичгийн хэлбэрээс гадна цахимаар хийх боломжтой болсон. Гэвч ИХ-ын 42^{1.2}-т зааснаар тус цахим хэлцэл нь тоон гарын үсгээр баталгаажсаны үндсэн дээр хүчинтэй болох бөгөөд 2011 онд батлагдсан Цахим гарын үсгийн тухай хуулиар “цахим гарын үсэг” болон “тоон гарын үсэг” хоёр нь ялгаатай ойлголт болохыг хуульчилж, тоон гарын үсгийг зөвхөн тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөлтэй этгээдээс олгохоор хуульчилжээ. Гэтэл хууль практикт хэрэгжиж эхэлснээс хойш 10 жил болоход тоон гарын үсэг нь төдийлөн хэрэглээнд нэвтрээгүй ба 2020 оны 8 дугаар сарын байдлаар 28,853 иргэн буюу хүн амын 2% хүрэхгүй хэсэг нь тоон гарын үсэг эзэмшиж байгаа³ бөгөөд цахим хэлцлийг зөвхөн тоон гарын үсгээр баталгаажуулж байж хүчинтэй байхаар зохицуулсан нь цахимаар хэлцэл байгуулах цар хүрээг хумьж байв.

Улмаар 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр ИХ-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр цахим хэлцлийг зөвхөн тоон гарын үсгээр бус бусад төрлийн цахим гарын үсгээр баталгаажуулах эрх зүйн боломж бүрдсэн. Гэвч тус өөрчлөлтөөр гагцхүү цахим хэлцлийн эрх зүйн зохицуулалтыг дүгнэх боломжгүй бөгөөд АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй улсуудын жишгээс харвал цахим хэлцлийн талаар бие даасан хууль баталж, ердийн хэлцлээс тусгай журам үйлчлэхээр зохицуулжээ.

Манай улсын хувьд техник, технологийн шийдэл ашиглах буюу интернэтээр дамжуулсан худалдаа, үйлчилгээний хувьд дээрх улсуудаас хол хоцроогүй боловч эрх зүйн зохицуулалт нь нийгмийн хөгжилтэй хэрхэн уялдаж байгаа эсэхийг харьцуулан

³ З.Гантоогоо, Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх нь нийтлэл (2020.8.18). <https://ikon.mn/opinion/1yp1> Жич: Тус судалгаа нь Цахим гарын үсгийн тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдахаас өмнө гүйцэтгэсэн бөгөөд тухайн шинэчилсэн найруулгын агуулгыг тус судалгаанд хамруулаагүй болохыг анхаарна уу.

судалж, энэ талаарх шүүхийн шийдвэрт дүгнэлт өгөхөд судалгааны зорилго оршино.

Иймд судалгааны багийн зүгээс тус судалгааны объектыг зөвхөн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээгээр хязгаарлахгүй, манай улсын цахим хэлцлийн талаарх эрх зүйн зохицуулалт ямар түвшинд байгаа, цаашид шинэ төрлийн ямар асуудлууд үүсэж болох талаар зарим нэг улсын эрх зүйн зохицуулалттай товч харьцуулан судлахыг зорьсон болно.

СУДАЛГААНЫ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Цахим хэлцэлтэй холбоотой шүүхийн шийдвэр болон эрх зүйн зохицуулалт, онолын үндэслэлийг хоёр хэсэгт ангилан судлахаар зорилоо. Үүнд:

1. Гэрээний талууд буюу үйлчилгээ үзүүлэгч (үйлчлэгч) тал болон үйлчилгээ авагч (үйлчлүүлэгч) тал цахимаар гэрээ шууд байгуулах боломжтой гэрээний төрлүүдийг судлах. Тухайлбал, зээл олгох эрх бүхий этгээдээс тусгайлан бэлтгэсэн аппликэйшн болох цахим платформыг ашиглаж, зээлдэгч цахимаар гэрээний саналыг шууд хүлээн зөвшөөрч гэрээ байгуулах буюу уламжлалт зээлийн гэрээнээс ялгаатай хэлбэрээр хийгддэг гэрээнээс үүдэлтэй маргаан. Ийнхүү уламжлалт цаасан суурьтай зээлийн гэрээнээс ялгаатайгаар байгуулах гэрээг авч үзэх нь тухайн гэрээний талуудын харилцааг тодорхойлоход харьцангуй төвөг саад багатай буюу зайнаас гэрээ байгуулахтай зарим талаараа ижил процедуртай байдагтай холбоотой. Гэвч бодит байдалд цахимаар хийсэн зээлийн гэрээнд хүү тооцсоныг бичгээр гэрээ хийсэнтэй адилтган үзэж хүү шаардах эрхтэй байх эсэх нь тус судалгаагаар хөндөх нэг асуудал юм.

2. Цахимаар бараа, бүтээгдэхүүн худалдан авах, нийлүүлэх зэрэг олон талт субъектүүд оролцдог цахим хэлцлийн онцлогийг судлах. Тодруулбал, олон талт субъектүүд оролцдог хэлцлийг цахимаар байгуулахад одоогийн манай ИХ дахь зохицуулалт хангалттай эсэхийг шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга замаар тодруулах бөгөөд мөн Япон Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан дүгнэнэ.

Энэхүү судалгааны хүрээнд шүүхийн шийдвэрийн албан ёсны нээлттэй цахим сан болох www.shuukh.mn сайтын 2017 оноос 2021 оны 8 дугаар сарын 20 хүртэлх бүх Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээс “цахим” гэсэн түлхүүр үгээр, худалдах, худалдан авах гэрээ болон арилжааны гэрээ, барьцаалан зээлдүүлэх байгууллагын зээл, банкны зээл, даатгал, тээвэрлэлт, зуучлал, түрээс, олон улсын гэрээ, зохиогчийн эрхийн зөрчил гэсэн маргааны төрлөөр шүүж хайхад нийт 212 шүүхийн шийдвэр илэрснийг нэг бүрчлэн шалгаж, цахим хэлцэлтэй холбогдох 6 шүүхийн шийдвэрийг сонгон авч дүн шинжилгээ хийсэн бөгөөд арбитрын шийдвэрийг судлан үзээгүй болохыг тэмдэглэе.

Энэ ташрамд манай улсад банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлийн харилцаа болон цахим худалдаанд дийлэнхдээ цахимаар гэрээ байгуулж байгаа боловч эдгээр зээлийн болон худалдааны харилцаа нь харьцангуй хэрэглээний шинжтэй буюу бага үнийн дүнтэй байдаг. Тиймээс хэлцлийн үнийн дүн бага байх тохиолдолд маргаан гарах нь цөөн, эсвэл маргаан гарсан ч шүүхийн шат хүртэл үргэлжлэх нь харьцангуй цөөн байх тул шүүхийн шийдвэрийн тоо тэр хэмжээгээр хязгаарлагдмал байсныг дурдах нь зүйтэй.

НЭГ. ЦАХИМ ХЭЛЦЭЛ БА МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. ХЭЛЦЭЛ БА ЦАХИМ ХЭЛЦИЙН ТУХАЙ

ИХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Хэлцэл” гэж “иргэний эрх, цэргийг цусгах, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, ИХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д зааснаар “хуульд заасан болон заагаагүй боловч агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл” нь иргэний эрх зүйн харилцаа үүсгэх нэг үндэслэл болох бөгөөд иргэний эрх зүйн харилцааны дийлэнх хэсэг нь харилцан тэгш эрх бүхий субъектүүдийн хооронд хүсэл зоригоо илэрхийлэн хийсэн хэлцлийн үр дүнд үүсэж байдаг. Үүнийг бид гэрээ гэж нэрлэх бөгөөд харин нэг тал дангаар хүсэл зоригоо илэрхийлсэн илэрхийллийг нэг талт хэлцэл байхаар ИХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заажээ.

“Хүсэл зоригийн илэрхийлэл” болоод “хэлцэл” гэх мэт ухагдахуун нь өндөр хийсвэрлэлийн үр дүнд бүтсэн эрх зүйн ойлголтууд бөгөөд тэдгээрийн бүрэлдэхүүнийг шинжлэх ухааны тайлбар хийх замаар тодорхойлно. Хэлцэл нь холбогдох этгээдийн хүссэн үр дагаврыг бий болгох үндэслэл болдог бүхий л үйл хөдлөлийг хамрах бөгөөд үүний гол цөмийг хүсэл зоригийн илэрхийлэл бүрдүүлнэ. Тиймээс хэлцэл гэдгийг дор хаяж нэг этгээдийн хүсэл зоригийн илэрхийллээс бүрдэж байдаг, эрх

зүйн үр дагавар нь энэхүү илэрхийллийн агуулгаас шууд хамааралтай үйлдэл, эс үйлдэхүй хэмээн тодорхойлдог.⁴

Түүнчлэн ИХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасан буюу бидний уламжлалт ойлголтоор “*Хэлцлийг хуульд заасан хэлбэрээр, хуульд заагаагүй бол талууд хэлэлцэн тохиролцож амаар буюу бичгээр хийх*”-ээр заасан бөгөөд бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болохоор заажээ.

Харин ХХI зуунд дэлхий дахиныг үндсээр нь өөрчилж буй цахим буюу интернэт хөгжлийн эрин үед улс бүр, цаашлаад хүн бүр хоорондоо интернэт орчноор дамжин маш амар хялбар аргаар харилцах боломжтой болсон. Үүний нэг тусгал нь өнөөгийн бидний өдөр тутмын амьдралдаа өргөн ашигладаг интернэт орчныг ашиглан худалдаа, арилжаа эрхлэх, таних танихгүйгээс үл хамаарч харилцаа холбоо тогтоох боломжтой нийгмийн сүлжээ (*social network*) юм.

Энэ бүхний үр дүнд дээр дурдсан уламжлалт аман болон бичгээр үйлдсэн хэлцлээс цахим системийг ашиглан гэрээ, хэлцэл хийх боломжтой шинэ төрөл хэдийнээ бий болж, түүнд хамаарах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор улс орнууд зорьж байна.

Тухайлбал, манай улсын хувьд 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ИХ-ийн 42 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж, 42¹ заалтыг шинээр хуульчилснаар цахимаар хийх хэлцлийн тухай зохицуулалтыг анх удаа хуульд тусгажээ. Ийнхүү ИХ-д цахим хэлцлийн талаарх зохицуулалт орсны дагуу 2011 онд Улсын Их Хурлаас (цаашид “УИХ” гэх) Цахим гарын үсгийн тухай хуулийг баталжээ.⁵

⁴ Б.Буянхшиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2 дахь хэвлэл, УБ 2014 он, 76 дэх тал

⁵ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 01 дүгээр сарын 06 өдрийн №01

Тэгвэл цахим хэлцэл гэж юу болох, тус цахим хэлцэл нь аман болон бичгээр үйлдсэн гэрээ, хэлцлээс ямар онцлог, ялгаатай болох талаар тодруулан авч үзье. ИХ-ийн 42^{1.2}-т “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно” гэж зааснаас үзвэл “хэлцэл хийгч талууд нь цахим баримт бичиг үйлдэж, цахим гарын үсгээр баталгаажуулсан хэлцлийг цахим хэлцэл” гэж ойлгож болно.

Тодруулбал, “цахим хэлцэл (цаашид “цахим гэрээ, эсхүл цахим хэлцэл” гэх)-ийг цахим гарын үсэг ашиглан, цахим баримт бичиг үйлдэн, интернэт сүлжээ ашиглан харилцан солилцож, тухайн гэрээг цахим хэлбэрээр буюу серверт хадгалах баримт бичгийг цахим гэрээ” гэж нийтлэг байдлаар тодорхойлдог.⁶

Өөрөөр хэлбэл, “цахим гэрээ нь гэрээ байгуулах 2 буюу түүнээс дээш талууд цахим арга хэрэгслийг ашиглан харилцан хүсэл зоригоо илэрхийлж, талуудын хүсэл зориг нэгдсэн тохиолдолд түүнийг баталгаажуулах цахим баримт бичиг үйлдэж, цахим гарын үсгээр баталгаажуулсан хэлцлийн нэг хэлбэр” гэж тодорхойлж болно.⁷

Өргөн утгаараа цахим хэлцэл нь интернэтийн сүлжээ ашиглан цахим баримт бичиг солилцох замаар бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, худалдан авах, тээвэрлэх зэрэг эдийн

⁶ <https://www.cloudsign.jp/media/20170125-basics-of-e-contract-01/> (Cloud sign нь GMO Globalsign компанийн хөгжүүлсэн Японы цахим гарын үсэг болонгэрээний үйлчилгээ юм.) (Хамгийн сүүлд 2022.5.15-ны өдөр хандав.)

⁷ <https://www.nolo.com/legal-encyclopedia/electronic-signatures-online-contracts-29495.html> (Хамгийн сүүлд 2022.05.15-ны өдөр хандав.)

засгийн болон бусад зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын үйлдлийг хэлнэ.⁸

Харин явцуу утгаар нь авч үзвэл “бараа бүтээгдэхүүний солилцоонд тулгуурласан цахим харилцааг хэлэх бөгөөд үүнээс дүгнэн үзвэл цахим хэлцэл нь бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, зуучлах, тээвэрлэх болон сүлжээ ашиглан гүйлгээ үзүүлэхтэй холбогдсон харилцаа” гэж үзэж болох⁹ боловч судалгааны баг орчин үеийн цахим хэлцэл гэх ойлголтыг дээр дурдсан өргөн утгаар авч үзэх нь зохимжтой гэж үзэж байна.

Учир нь цахим хэлцлийг зөвхөн интернэт, цахим шуудангаар хязгаарлагдахгүй, орчин үед интернэтэд суурилсан ухаалаг утас (*smart phone*), таблет (*tablet*), киоск сүлжээ бүхий төхөөрөмж (тухайлбал, өөртөө үйлчлэх дэлгүүрт байрлах төлбөр төлөх, шилжүүлэх боломжтой киоск машин), интернэт чат гэх мэт олон төрлийн хэрэгслийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлэх, нөгөө тал түүнийг хүлээн зөвшөөрсөн хариу илгээх замаар хэлцэл байгуулах боломжтой болсонтой холбоотой.

1.2. ЦАХИМ ХЭЛЦЛИЙН ОНЦЛОГ БА АЧ ХОЛБОГДОЛ

Цахим гэрээний хувьд бусад төрлийн гэрээнээс дараах үндсэн шинжээр ялгардаг онцлогтой. Үүнд:

Нэг. Цахим гэрээ нь цахим сүлжээг ашиглан байгуулагддаг буюу цахим хэлбэртэй байдаг. Тухайлбал, бичгийн гэрээ нь бичмэл хэлбэрээр буюу цаасаар байдаг бол цахим гэрээ нь дата буюу өгөгдөл байдлаар интернэт сүлжээнд байршдаг;

Хоёр. Бичгийн гэрээг талууд гарын үсэг, тэмдгээр батал-

⁸ “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. 2007 он, №2, 64 дэх тал.

⁹ Хууль зүйн үндэсний хүрээлэн “Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт”, 2011 он, 51 дэх тал

гаажуулдаг бол цахим гэрээг тоон гарын үсэг, бусад төрлийн цахим гарын үсгээр баталгааждаг;

Гурав. Бичгийн гэрээг талууд шууд харилцан солилцох, эсхүл шуудангаар хүргүүлдэг бол цахим гэрээг цахим сүлжээ ашиглан харилцан солилцоно;

Дөрөв. Бичгийн гэрээг цаасаар хадгалах бол цахим гэрээг тодорхой нэг цахим сүлжээний серверт хадгалдаг;

Тав. Хуулийн этгээдийн хувьд бичгийн гэрээг тэмдэг дарж баталгаажуулдаг бол цахим гэрээнд заавал тэмдэг дарсан байхыг шаардахгүй.¹⁰

Түүнчлэн цахимаар хэлцэл буюу гэрээ хийх нь орчин үеийн цаг завгүй амьдрал, бизнесийн орчинд олон талын ач холбогдолтой байна. Цахим хэлцлийн онцлох гурван давуу талыг танилцуулъя. Үүнд:

Нэг. *Аж ахуйн нэгж, байгууллагын хувьд үйл ажиллагааны үр дүнг сайжруулдаг.* Цаасаар буюу бичгээр гэрээ байгуулах тохиолдолд гэрээний эхийг бэлтгэж, хэвлэх, эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд гэрээлэгч нөгөө талд илгээнэ. Ийнхүү илгээсний дараа нөгөө тал гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан хариу илгээх хүртэл хэдэн өдрөөс хэдэн долоо хоног шаардана.

Харин цахим хэлцлийн хувьд дээр дурдсан хэвлэх, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулах, илгээх зэрэг ажиллагааг хялбарчлах тул гэрээ байгуулах явцыг түргэсгэдэг. Гэрээг баталгаат тоон гарын үсгээр баталгаажуулах тул хуурамчаар үйлдэх эрсдэлийг багасгана.

Хоёр. Дээр дурдсан үйл ажиллагааг үр дүнтэй болгохоос

¹⁰ <https://www.gmosign.com/media/electronic-contract/post-0025/> (GMO Globalsign компанийн хөгжүүлсэн Японы цахим гарын үсэг болон гэрээний үйлчилгээ юм.) (Хамгийн сүүлд 2022.05.15-ны өдөр хандав.)

гадна гэрээ байгуулахтай холбогдон гарах зардлыг хэмнэдэг. Тодруулбал, гэрээг шуудангаар илгээх зардал, түүнийг хадгалах зардал зэргийг хэмнэх боломжтой. Энэ бүгд бодит зардлаас гадна цаг хугацаа хэмнэх тул түүнээс үүдэн гарах хүний нөөцийн зардал болон бусад урсгал зардлыг бууруулах ач холбогдолтой. Япон улсад хийсэн судалгаагаар бүх төрлийн цаасан гэрээг цахимжуулснаар гэрээ байгуулах зардлыг 80 хувиар бууруулсан тооцоо гарсан байна.¹¹

Гурав. Бизнесийн байгууллагын хувьд цахим гэрээг ашигласнаар байгууллагын дотоод комплайнсыг үр дүнтэй зохион байгуулах боломжтой болдог. Тухайлбал, хэдийнээ цахим гэрээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд бий болж, гэрээний хэлэлцээр эхлэхээс дуусах хүртэл буюу гэрээ байгуулах хүртэлх бүх үе, баримт бичгийн хадгалалт, үйл явцыг хянах боломжтой. Ингэснээр хэлэлцээрийн явцад бичиг баримт дутах, алдагдах, орхигдуулах зэргээс сэргийлэх бөгөөд энэ нь орчин үеийн бизнесийн байгууллагуудад тавигддаг комплайнсыг төгөлдөржүүлэх нэг арга юм.¹²

1.3. МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ ХЭЛЦЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Манай улсын хувьд цахим хэлцийн талаарх нийтлэг зохицуулалтыг ИХ-д тусгаж, банк болон эрх бүхий этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаанд цахим хэлцлийг хэрэглэх талаар тусгайлсан хуульд заасан байна. Мөн цахим хэлцийг баталгаажуулах харилцааг Цахим гарын үсгийн тухай хуулиар зохицуулдаг. Түүнчлэн манай улс олон улсын гэрээнд цахим

¹¹ Мөн тэнд.

¹² <https://www.gmosign.com/media/electronic-contract/post-0023/> (Хамгийн сүүлд 2022.05.15-ны өдөр хандав.)

хэлцлийг ашиглах талаарх олон улсын конвенцод нэгдэн орсон билээ. Тэдгээрийг товч танилцуулъя.

А. Иргэний хуулийн өөрчлөлт

2021 оны 5 дугаар сарын 21-нд ИХ-ийн хуулийн 42¹ дүгээр зүйлийн 42^{1.2}-т “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно” гэсэн өөрчлөлтийг оруулсан. Тодруулбал, тус өөрчлөлтөөр цахим хэлцэл нь зөвхөн Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс авсан тоон гарын үсгээр баталгаажуулж хүчинтэй болох бус техник хэрэгсэл, программ хангамж ашиглан хүсэл зоригоо илэрхийлж тоон гарын үсгээс бусад хэлбэрээр цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох боломжтой болсон.

Гэвч ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4-т “цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурсан” бол хэлцэл хийсэн гэж үзэх тухай зохицуулалтыг өөрчлөөгүй хэвээр үлдээжээ. Өөрөөр хэлбэл, талууд цахим хэлцэл хийсэн эсэх талаар маргаан гарч, хэлцэл хийсэн эсэхийг тогтооход ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4-т заасны дагуу мөн адил тоон гарын үсгээр баталгаажуулах шаардлага тавигдах хэвээр байна.

Харин ИХ-ийн 196 дугаар зүйлийн 196.1.8-д “цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ

хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлснийг харилцан хүлээн зөвшөөрч цахим гарын үсэг зурснаар гэрээ байгуулсанд тооцно” гэж өөрчлөлт оруулсан нь 42^{1.2}-т заасан цахим хэлцэл нь зөвхөн тоон гарын үсгээр бус бусад төрлийн цахим гарын үсгээр баталгаажуулж болох заалттай нийцэж байна.

Үүнд анхаарал татахуйц зүйл нь цахим хэлцэл нь бие даасан хэлцлийн төрөл үү, эсвэл бичгийн хэлцлийг цахим хэлбэрт оруулсан хувилбар уу? гэдэг асуудал юм. Өөрөөр хэлбэл, цахим хэлцэл нь аман болон бичгийн хэлцэлтэй адил хэлцлийн бие даасан төрөл үү эсвэл бичгээр байгуулах хэлцлийн цахим хувилбар уу? гэдэг дээр судлаачид нэгдсэн байр сууринд хүрээгүй байна. Манай улсын хувьд ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2 буюу ерөнхий зохицуулалт нь хэлцлийг бичгээр хийсэнд тооцох тухай зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, 43 дугаар зүйлийн 43.2.4 нь ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2-т хамаарах тул цахимаар хийх хэлцэлд тоон гарын үсэг зурснаар бичгээр хэлцэл хийсэнд тооцно гэсэн учир зүйн дүгнэлт гарна.

Цахим хэлцлийг бичгийн хэлцлийн нэг төрөл болгон хуульчилсан хууль зүйн техник боловч цахим хэлцэл нь аман болон бичгийн хэлцлээс ялгаатай нь интернэт болон бусад цахим харилцааны сүлжээ ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, түүнийг хүлээн зөвшөөрснөө баталгаажуулж цахим гарын үсэг зурснаар гэрээ байгуулдаг бие даасан хэлцлийн төрөл гэж үзвэл ИХ-ийн тус заалт нь зөрчилдөөнтэй мэт ойлголт төрүүлж байна.

Одоогоор тус асуудлыг тодорхойлсон шүүхийн маргаан гараагүй байгаа ч жишээлбэл, талууд цахимаар хэлцэл хийж тоон гарын үсэг бус бусад цахим арга хэрэгслээр цахим гарын үсэг зурж баталгаажуулсан гэрээг ИХ-ийн 42^{1.2}, 196 дугаар зүйлийн 196.1.8-д заасны дагуу цахим гэрээ байгуулагдсан гэж үзэх үү?, эсвэл ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4-т заасны дагуу тоон гарын үсгээр баталгаажуулж тул хэлцэл хийгдээгүй

гэж үзэх үү? гэх асуудал үүсэж болзошгүй. Гэхдээ судалгааны багийн хувьд энэ асуудлын тухайд ИХ-ийн 43.2.4-т заасны дагуу тоон гарын үсгээр баталгаажаагүй нь бичгээр хэлцэл хийгээгүй гэж үзэх үндэслэл болох боловч цахимаар хэлцэл хийснийг үгүйсгэхгүй бөгөөд ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4 дэх заалт нь ИХ-ийн 43.2 буюу бичгээр хэлцэл гэсэн малгай зохицуулалтад хамаарах тул цахим хэлцэл нь бичгээр үйлдэх хэлцлийн онцгой төрөл гэж үзэж байгаа болно. Учир нь бичгээр үйлдэх хэлцлийн утга нь зөвхөн цаасан суурьтай гэж ойлгох нь хэт явцуурсан дүгнэлт болох бөгөөд цахим аргыг ашиглан хэлцэл хийх тохиолдолд ч цахим файл буюу хэлцэл хийснийг нотлох бодитой баримт үлдэх учир бичгийн хэлцлийн онцлог төрөлд хамааруулж авч үзэх нь илүү ойлгомжтой бөгөөд манай улсын ИХ-ийн үндсэн үзэл баримтлалтай нийцнэ.

Харин бичгээр хэлцэл хийсэн гэж үзэх нөхцөлийн тухайд зөвхөн тоон гарын үсгээр хязгаарлах уу?, эсвэл илүү өргөн хүрээтэй цахим гарын үсэг гэдэг ойлголтыг тодорхойлж, тоон гарын үсгээс бусад хэлбэрийн цахим гарын үсгээр баталгаажуулсныг хүчинтэйд тооцох уу? гэдгийг хууль зүйн хувьд зайлшгүй шийдвэрлэх ёстой.

Б. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

1995 онд батлагдсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (цаашид “БЭБЭМХТТЗҮАтХ” гэх)-д 2011 онд нэмэлт өөрчлөлт орж, улмаар банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд иргэн, харилцагчийн хүсэлтийг үндэслэн цахимаар данс нээх, хаах үйлчилгээг үзүүлэх боломжтой болжээ.

Үүнийг даган хэрэглэгчдийн хувьд интернэт банкны (цахим

банк) үйлчилгээг идэвхтэй хэрэглэх болж, банк санхүүгийн байгууллагын хувьд техник технологийн хөгжлийг ашиглан банк, санхүүгийн үйлчилгээг хялбарчлах, үүнийг даган ажиллах хүч, урсгал зардал гэх зэргээр үйл ажиллагааны зардлаа бууруулах боломжтой болсон. Гэсэн хэдий ч тус өөрчлөлт нь хэрэглэгч зөвхөн цахимаар данс нээх, хаах үйлчилгээг авах боломжтой байснаар хязгаарлагдаж, хадгаламж, зээлтэй холбоотой үйлчилгээг хамраагүй юм.

Гэвч бодит байдалд банк, санхүүгийн байгууллагууд аль хэдийнээ цахим санхүүгийн олон төрөлт үйл ажиллагааг эрхлэхээс гадна даатгалын компаниуд цахим хэлбэрээр даатгал хийх, цахим харилцааг ашиглан нөхөн төлбөрийг олгох зэрэг үйлчилгээг идэвхтэй үзүүлж байна¹³.

Тодруулбал, дэлхий даяар санхүүгийн хэрэглэгчдэд мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хөгжил дэвшлийн үр дүнд бий болсон дэвшилтэт технологи, цахим хэрэгслийг өдөр тутмын амьдралдаа ашиглах явдал хурдацтай нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор банк, эрх бүхий хуулийн этгээдээс үйлчилгээг мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилан харилцагчид үзүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хэдийгээр тоон гарын үсэг ашиглан гэрээ байгуулж болохоор ИХ болон Цахим гарын үсгийн тухай хуульд заасан боловч өнөөдрийг хүртэл тоон гарын үсгийн хэрэглээ төдийлөн хүртээмжтэй, өгөөжтэй бус байна. Тиймээс санхүүгийн тогтвортой харилцаа үүсгэсэн харилцагч, хадгаламж эзэмшиг-

¹³ Тухайлбал, хэд хэдэн даатгалын компани даатгалын бүтээгдэхүүнээ онлайн буюу цахим хэлбэрээр борлуулах, даатгуулагч нь зөвхөн цахим арга хэрэгслийг ашиглан даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр авах боломжийг бүрдүүлсэн болохыг даатгалын компаниудын цахим хуудаснаас тодорхой харж болно. Жишээ: “Бодь даатгал” ХК гэхэд энэ төрлийн үйлчилгээг 2018 оноос хэрэгжүүлж эхэлжээ. (<https://bodi-insurance.com/learn-more-online-insurance-service/>) (Хамгийн сүүлд 2022.05.15-ны өдөр хандав.)

чийн баталгаат мэдээлэлд үндэслэн, түүний зөвшөөрлөөр цахим хэлбэрээр түүний данстай холбоотой мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болох зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлага бий болсон.¹⁴

Иймд 2021 оны 5 дугаар сард УИХ-аас БЭБЭМХТТЗҮАтХ-ийг “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”¹⁵ болгон шинэчлэн найруулж, тус хуулийн 7 дугаар зүйлд Банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахимаар үйлчилгээ үзүүлэх тухай тусгай заалт оруулсан байна. Тодруулбал, тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу бичгээр гэрээ байгуулан данс нээсэн харилцагчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно”, 7.2-т “Энэ хуулийн 7.1-д заасны дагуу цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, цахим гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлэг, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ” гэж заажээ.

Ингэснээр банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг хөнгөвчлөх, нөгөө талаар санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор хэрэглэгч нь хадгаламж, зээл, төлбөр тооцоо, шилжүүлгийн үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон юм.

¹⁴ Монголбанк “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан” 2020 он, 6 дахь тал

¹⁵ Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, 2021 он. <https://www.legalinfo.mn/law/details/16682?lawid=16682> (Хамгийн сүүлд 2022.05.15-ны өдөр хандав.)

В. Цахим гарын үсгийн тухай хууль

Цахим гарын үсгийн тухай хууль нь 2011 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш 3 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр 3 зүйл, заалтыг өөрчилжээ. Энэ хуулиар цахим болон тоон гарын үсэг хэрэглэх эрх зүйн үндсийг тогтоож, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулж байна. Өөрөөр хэлбэл, нийтийн түлхүүр ашиглан мэдээллийг шифрлэн хувиргаж, түүнд хамааралтай хувийн түлхүүрээр мэдээллийг задлах, эсрэгээр мэдээллийг хувийн түлхүүрээр шифрлэсэн бол зөвхөн түүнд хамааралтай нийтийн түлхүүрээр задлах зарчмаар ажиллах нийтийн түлхүүрийн дэд бүтцийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын дэргэд байгуулж, иргэн, хуулийн этгээдийг цахимаар таньж, баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “цахим гарын үсэг” гэж *цахим баримтад гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зорилготой цахим баримт бичигт хавсаргасан буюу нэгтгэсэн үг, үсэг, тоо, тэмдэг, дүрсийг агуулсан цахим өгөгдлийг*; 4.1.2. “тоон гарын үсэг” гэдэг нь *“цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрлийг хэлнэ”* гэж тус тус заажээ.

Дээр дурдсанчлан ИХ-д 2021 онд өөрчлөлт орохоос өмнө бүх төрлийн цахим хэлцэл байгуулахад заавал тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс олгосон Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсгийг хэрэглэх хуулийн шаардлагатай байсан. Гэсэн хэдий ч бодит байдалд тус хуулийг баталснаас хойш 9 жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдэд нийт 38,407 тоон гарын үсэг олгогдсон байгаа нь практикт тус хууль хангалттай хэрэгжихгүй байгаагийн илрэл юм. Өөрөөр

хэлбэл, эдгээр тоон гарын үсгийн ихэнх нь аж ахуйн нэгж, байгууллагад олгогдож, иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгох ажил ихээхэн удаашралтай байна.¹⁶

Иймд 2021 оны ИХ-ийн нэмэлт өөрчлөлтөөр цахим хэлцэл байгуулахад зөвхөн тоон гарын үсгээр баталгааждаг байх тухай шаардлагыг зөөлрүүлж, тоон гарын үсгээс бусад төрлийн цахим гарын үсгээр цахим хэлцэл байгуулж болохоор заасан талаар дээр дурдсан. Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан “цахим гарын үсэг”-ийн тодорхойлолтоос үзвэл цахим хэлцэл байгуулагч этгээд өөрийг нь тодорхойлж болохуйц ямар ч хэлбэрээр цахим гарын үсэг ашиглах боломжтой юу, эсвэл тухайн цахим гарын үсэг гэдэг нь тоон гарын үсэгтэй адил шинж бүхий зөвхөн цахим гарын үсэг ашиглагч л ашиглах боломжтой, тухайн этгээдийг таньж мэдэх боломжтой баталгаатай зүйл байх уу гэдэг нь хуульд тодорхойгүй байна.

Тухайлбал, хэлцэл байгуулагч тал цаасан дээр гарын үсгээ зурж скайнердаад цахим шуудангаар илгээх, эсвэл илгээж буй гэрээ байгуулах санал, хүлээн зөвшөөрөх саналын доор өөрийн нэр, регистрийн дугаарыг хавсаргасан байхад хангалттай юу гэдгийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Энэ асуудлыг бусад улс орон тодорхой зохицуулсан байна. Жишээ нь: Япон улсын хувьд цахим гарын үсэг нь тоон гарын үсэгтэй адил ойлголт бөгөөд цахим хэлцэл хийх этгээд түүнийг тоон гарын үсгээр баталгаажуулах шаардлагатай. Гэвч энд дурдагдаж буй тоон гарын үсэг нь хэд хэдэн төрөлтэй байх бөгөөд зөвхөн хоёр этгээд бие биеэ баталгаажуулах зорилготой тоон гарын үсэг (*local electronic sign*), эсвэл гуравдагч этгээдийн оролцоотой баталгаажуулах тоон гарын үсэг (*trusted third*

¹⁶ “Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” 2021 он, 2 дахь тал.

party electronic sign) зэрэг төрөлтэй. Өөрөөр хэлбэл, үүний гол зорилго нь хэлцэл хийгч талууд нь жинхэнэ хэлцэл хийгч тал мөн болохыг баталгаажуулах бөгөөд ингэснээр гэрээний маргаан үүсэх тохиолдолд хэлцэл хийгч тал өөрөө хүсэл зоригоо илэрхийлэн хийсэн хүчин төгөлдөр хэлцэл гэдгийг баталгаажуулахаас гадна хэлцэл хийгч тал тухайн хэлцлийг жинхэнэ этгээдтэй хийж байгаа гэдэгт баттай итгэх нөхцөлийг бүрдүүлдэг.¹⁷

Учир нь цахим хэлцлийн онцлог нь талууд бие биеэ харахгүй, танихгүй байсан ч цахим сүлжээг ашиглан хэлцэл, гэрээ байгуулах боломжтой тул хэлцэл хийгчийн өмнөөс төлөөлөх эрхгүй этгээд хэлцэл хийх, гэрээг хуурамчаар үйлдэх зэрэг эрсдэл байдагтай холбоотой. Харин манай улсын хувьд тоон гарын үсэг бус өөр төрлийн цахим гарын үсэг ашиглаж цахим хэлцэл хийхээр хуульчилсан нь цахим хэлцлийг хялбар хийх сайн талтай ч хэлцэл хийгч талыг жинхэнэ этгээд мөн эсэхийг баталгаажуулах тал дээр цаашид асуудал үүсэж болзошгүй гэж үзэж байна.

Г. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенцыг соёрхон батлах тухай хууль

УИХ-аас 2020 оны 5 дугаар сард Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенцыг соёрхон батлах тухай хуулийг баталсан.¹⁸ Уг конвенцод “*аливаа харилцаа, эсвэл гэрээг цахим хэлбэрээр үйлдсэн гэсэн ганцхан үндэслэлээр түүний хүчин төгөлдөр байдлыг, эсвэл нэхэмжлэлийн*

¹⁷ Япон улсын Цахим гарын үсгийн тухай хууль (2001) (電子署名法) <https://www.gmosign.com/media/electronic-contract/post-0023/> (Хамгийн сүүлд 2022.05.15-ны өдөр хандав.)

¹⁸ Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагыг конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл <http://forum.parliament.mn/projects/10900> (Хамгийн сүүлд 2022.5.15-ны өдөр хандав.)

шаардлагыг үгцүйсгэж болохгүй” гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалт нь цахим болон цаасан суурьтай мэдээллийг эрх зүйн ижил тэнцүү чадамжтай байдлыг хадгалах, цахим харилцааг илгээх, хүлээн авах, гэрээ байгуулах автоматжуулсан мэдээллийн системийн ашиглалтын талаарх Монгол улсын хуульд зааснаас өөр журам тогтоохоор байна.

Монгол Улсын цахимаар гэрээ хэлцэл хийх харилцааг өнөөдөр ИХ-ийн 42¹ дүгээр зүйлд цахимаар хийх хэлцлийн тухай, 43 дугаар зүйлийн 43.2.4 дэх заалтад цахим хэлцлийг тоон гарын үсгээр баталгаажуулах тухай, 196 дугаар зүйлийн 196.1.8 дахь заалтад цахимаар гэрээ хийх болон түүнд тоон гарын үсэг зурах тухай зохицуулалтууд болон Цахим гарын үсгийн тухай¹⁹ хуулиар зохицуулж байна.

Гэвч Монгол Улсын дээр дурдсан хууль, эрх зүйн зохицуулалт нь цахим баримт бичгийн эрх зүйн үндсийг тодорхойлоогүй, цахим баримт бичгийг цаасан суурьтай баримт бичигтэй ижил тэгш хүлээн зөвшөөрөөгүй, и-мэйл, компьютерын файл, гар утасны зурвас (мессеж), мэдээллийн сангийн цахим өгөгдлийг нотлох баримт, хууль зүйн чадамжтай баримт гэж тодорхойлоогүй болно.

Мөн Цахим гарын үсгийн тухай хуулиар олон улсын жишгийн дагуу ердийн болон баталгаат гэсэн цахим гарын үсгийн харилцан ялгаатай хоёр хэлбэрийн зохицуулалт тодорхой тусгагдаагүй, тоон газрын үсгийн зохицуулалт давамгайлсан, олон улсын шинжтэй гэрээ, хэлэлцээр, харилцааны шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын худалдааны түгээмэл хэлэлцээрүүд болох Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц (Нью-Йорк,

¹⁹ Цахим гарын үсгийн тухай хууль <https://www.legalinfo.mn/law/details/574> (Хамгийн сүүлд 2022.5.15-ны өдөр хандав.)

1958), Бараа худалдах-худалдан авах тухай НҮБ-ын конвенц (CISG) зэрэг баримт бичигт заасан зарим шаардлага нь цахим харилцааг өргөн ашиглах явдалд саад төвөг болох талтайг ЮНСИТРАЛ-аас гаргасан илтгэлд дурдсаны дээр Монгол Улсын цахим орчны харилцааны зохицуулалтыг олон улсын зохицуулалттай уялдуулан нийцүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэжээ.

Тодруулбал, тус конвенцын 20 дугаар зүйл “Бусад олон улсын гэрээний дагуу харилцаа солилцох” гэсний 20.1-д “Дараах олон улсын гэрээний гишүүн, эсвэл гишүүн болох, энэхүү конвенцын оролцогч улс нь эдгээр олон улсын гэрээгээр зохицуулагдах гэрээг байгуулах, эсвэл хэрэгжүүлэхтэй холбогдуулан цахим харилцааг ашиглахдаа энэхүү конвенцын заалтыг хэрэглэж болно” гээд тус хэсэгт дээр дурдсан олон улсын худалдааны хэлэлцээрүүдийг дурдсан байна. Өөрөөр хэлбэл, манай улс нь дээрх олон улсын худалдааны түгээмэл хэлэлцээрүүдэд нэгдэн орсон бөгөөд тус конвенцод нэгдэн орсноор цахим харилцааг ашиглан тухайн гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах боломжийг бүрдүүлжээ.

Тус конвенц нь 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх бөгөөд ийнхүү хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах нь худалдааг хөнгөвчлөх, оролцогч талуудаас гарах зардал багасах, хил дамнасан цаасгүй харилцаа, олон улсын худалдааг дэмжих хамгийн оновчтой, түргэн шуурхай аргын нэг болно²⁰ гэжээ.

Иймд дээр дурдсанчлан БЭБЭМХТТЗҮАтХ, Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенцыг соёрхон батлах тухай хууль батлагдсантай холбогдуулан, ИХ

²⁰ “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”, 2020 он. 1-2 дахь тал

дахь цахим хэлцлийг зөвхөн тоон гарын үсгээр баталгаажуулж хүчинтэй байх тухай зохицуулалтыг өөрчлөх бодит болон хууль зүйн шаардлага үүсжээ.

Гэхдээ үүнд анхаарах шаардлагатай зүйл нь тус конвенц нь бүхий л төрлийн цахим харилцаанд үйлчлэхгүй бөгөөд конвенцын 2 дугаар зүйлийн 2.1-д зааснаар “гэр бүлийн, гэр ахуйн, эсвэл хувийн зорилгоор байгуулсан гэрээ”, “зохицуулалттай биржийн зах зээлд хийсэн гүйлгээ, гадаад валютын гүйлгээ, банк хоорондын төлбөр тооцооны гэрээ, зуучлагчид хадгалагдаж буй үнэт цаас, санхүүгийн хөрөнгө”-д үйлчлэхгүй байхаар заажээ.

1.4. ЦАХИМ ХЭЛЦЛИЙН ТАЛААРХ ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ

Цахим хэлцлийн гол онцлог нь түүнийг ИХ дахь хэлцлийн нийтлэг зохицуулалтаар зохицуулахад хангалтгүй байдаг явдал юм. Учир нь цахим хэлцэл нь энгийн иргэд хоорондоо хийдэг хэлцлээс илүүтэй интернэтийн цахим сүлжээ ашиглан хэлцэл хийгдэх тул дийлэнхдээ аж ахуй эрхлэгчээс хэрэглэгч (*business to customer - B2C*) болон аж ахуй эрхлэгчээс аж ахуй эрхлэгч (*business to business - B2B*) хоорондын бизнесийн харилцаанд түгээмэл хэрэглэдэг.

Энэ тохиолдолд B2C болон B2B харилцааг ялгамжтай авч үздэг эрх зүйн хэм хэмжээ шаардлагатайгаас гадна аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаанд зориулсан арилжааны эрх зүй, хэрэглэгчийн эрх зүйд зориулсан хэрэглэгчийн гэрээний эрх зүй болон гэрээний стандарт нөхцөлийн зохицуулалт бүхий эрх зүйн системийг бий болгох шаардлагатай. Манай улсын хувьд хараахан B2B харилцааг зохицуулсан арилжааны хууль тогтоомжгүй, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль

болон ИХ дахь гэрээний стандарт нөхцөлийн зохицуулалтаас өөрөөр хэрэглэгчийн гэрээний онцлог хийгээд хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт байхгүй. Энэхүү нөхцөл байдлаас цахим хэлцлийн талаар ИХ-д хэлцлийн ерөнхий зохицуулалтад зөвшөөрснөөс өөрөөр эрх зүйн тодорхой орчин бүрэлдээгүй нь энэ төрлийн маргаан гарсан тохиолдолд хэрэглэгчийн эрх ашгийг хэрхэн хамгаалах нь тодорхойгүй хэвээр байна.

Дэлхий нийтийн чиг хандлагыг үзвэл хувийн эрх зүйн харилцаанд оролцоходоо техник, технологийг ашиглаж байгаа онцлогоос нь хамаарч цахим хэлцлийг тусгайлан зохицуулах хандлага Европ, Америк болон дэлхийн бусад улсад түгээмэл байна. Цахим хэлцлийг субъектээр нь бус хэлцлийн хувьд бие даасан төрөл эсвэл хэлбэр байдлаар тусгайлан авч үзэж буй гол шалтгаан нь *нэгдүгээрт*, тухайн хэлцлийн зүйлийг хэлцлийн аль нэг тал (компьютер, гар утасны цаанаас) биечлэн үзэх, мэдрэх, шалгах бололцоогүй, үүнтэй холбоотойгоор тусгайлан зохицуулах шаардлагатай өвөрмөц шинжтэй эрсдэл гардаг; *хоёрдугаарт*, хэлцлийн талууд нь бие биеэ танихгүй, хэлцэл хийх эсэхээ чөлөөтэй сонгоход хэлцэл хийж байгаа этгээдийн хувийн байдлыг мэдэх боломжгүй байдагтай холбоотойгоор эрсдэл гардаг; *гуравдугаарт*, хэлцлийг хийхдээ төлбөр шилжүүлэгч алдаа мадаг (тоо, хэмжээ, хэлцлийн зүйлийг буруу сонгох г.м.) гаргавал алдааг засахад ихээхэн цаг хугацаа шаардаж, хөрөнгө мөнгөний хувьд зарлагатай; *дөрөвдүгээрт*, хэлцлийг хийхэд худалдагч, худалдан авагч оролцохоос гадна технологийн шийдэл санал болгогч (жишээлбэл, *www.amazon.com*, *www.ebay.com* г.м.), барааг агуулахаас худалдан авагчид хүргэх тээвэрлэгч эсвэл ложистикын компани, төлбөрийн шийдлийг санал болгогч (жишээлбэл, *paypal* төлбөрийн систем г.м.) зэргээр олон этгээд энэ хэлцэлд оролцдог явдал юм. Иймээс субъектэд тулгуурласан эрх зүйн харилцааны аль ангилалд хамаарах

эсэхээс үл хамааран цахим хэлцэлд тусгайлсан зохицуулалт үйлчилдэг байна. Гэхдээ зарим тохиолдолд зайнаас байгуулах хэлцлийн хүрээнд цахим хэлцлийг зохицуулах боломж байхыг огт үгүйсгэхгүй боловч манай улсын хувьд зайнаас хэлцэл байгуулах эрх зүйн зохицуулалт мөн адил зохицуулалтгүй байна.²¹

Иймд цахим хэлцлийн хүрээнд онцгойлон авч үзэх шаардлагатай В2С харилцаанд ИХ хууль дахь хэлцлийн хэм хэмжээнээс хэрхэн ялган авч үздэг талаар Япон улсын Цахим хэрэглэгчийн гэрээний тухай хуультай²² өөрийн орны ИХ-ийн зохицуулалтыг харьцуулан авч үзье.

А. Цахим хэлцэл дэх хэрэглэгчийн эрхийн хамгаалалт ба аж ахуй эрхлэгчийн хүлээх үүрэг

Цахимаар байгуулсан гэрээ хэлцлээс үүссэн маргааныг ИХ-ийн нийтлэг зохицуулалтаар шийдвэрлэх нь тохиромжгүй буюу хэрэглэгчийн эрхийн асуудал бодитоор үүсэж байна. Өөрөөр хэлбэл, 1. Хэрэглэгч захиалгаа буруу өгсөнтэй холбоотой төөрөгдөл, 2. Зайнаас гэрээ байгуулагдсан гэж үзэх хугацаа ба цахимаар гэрээ байгуулагдсан гэж үзэх хугацааг хэрхэн

²¹ Б.Амарсанаа, “Арилжаа, аж ахуй, худалдаа хэмээх нэр томъёоны хууль зүйн тайлбар, хэрэглээг нэг мөр болгох нь” Эрх зүй сэтгүүлд 2021 онд хэвлэгдэнэ. (Зохиогчийн зөвшөөрлөөр ишлэв.)

²² (電子消費者契約に関する民法の特例に関する法律) Хэрэглэгчийн цахим гэрээнд хамаарах ИХ-ийн тусгай журмын тухай хууль нь 2001 онд батлагдсан хууль бөгөөд ИХ-ийн хэлцлийн болон гэрээ байгуулагдсан тооцох тухай зохицуулалтыг Хэрэглэгчийн цахим гэрээнд ашиглахгүй бөгөөд ИХ-аас ялгамжтай зохицуулах зорилгоор тус хуулийг баталсан. Тус хуулийн гол зохицуулах зүйл нь 1. Хэрэглэгчийн төөрөгдлийн улмаас гэрээ хүчингүй болсон ч хэрэглэгч хариуцлага хүлээхгүй байх, аж ахуй эрхлэгчээс гэрээ байгуулах цахим системийг нэвтрүүлэхдээ хэрэглэгч төөрөгдөхөөс урьдчилан сэргийлж, гэрээний агуулгыг дахин нягтлах тусгай арга хэмжээ авах, 2. Хэрэглэгч гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн саналыг хүлээн авснаар гэрээ байгуулсанд тооцох тухай тусгай зохицуулалтыг агуулсан хууль юм. <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=413AC0000000095> (Хамгийн сүүлд 2022.5.15-ны өдөр хандав.)

тогтоох тухай асуудлууд үүсэж байна. Харин цахим худалдаанд түгээмэл тохиолддог бараа, бүтээгдэхүүний доголдол, бүтээгдэхүүний хариуцлага (*product liability*)-ын хувьд ИХ дахь гэм хорын эрх зүйн хүрээнд нийтлэг байдлаар зохицуулдаг тул тус хэсэгт энэ талаар дэлгэрүүлж авч үзээгүй болно.

Тодруулбал, цахим худалдаа хийхэд тухайн цахим худалдаагаар дамжуулан бараа, бүтээгдэхүүнээ худалдаж буй аж ахуй эрхлэгчийн зохион бүтээсэн программ, техник хэрэгслийг ашиглан хэрэглэгч гэрээ байгуулах санал гаргах, эсвэл хүлээн зөвшөөрсөн саналаа мэдэгдэхэд аж ахуй эрхлэгч технологийн шийдлийн хувьд гэрээний агуулгыг дахин нягтлах тусгай цонх, системийг хийх үүрэгтэй байх шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, хэрэглэгч цахимаар хэлцэл хийхэд аж ахуй эрхлэгчийн бэлтгэсэн цахим захиалгын системийг ашиглан маш хялбараар хүсэл зоригоо илэрхийлэх тул үүнийг дагаад тоо хэмжээ, үнийн дүн гэх мэт алдаа гаргах эрсдэл аман болон бичгэн хэлцэл хийснээс илүү өндөр байдаг.

Хэрэв энэ тохиолдолд тухайн хэрэглэгчийн гаргасан санал нь өөрийн бодит хүсэл зоригоос зөрүүтэй байсан үндэслэлээр хүчин төгөлдөр бус хэлцэл болно. Үүнийг Иргэний эрх зүйд хэлцлийн илэрхийллийн төөрөгдөл хэмээн авч үздэг. Гэтэл ИХ-ийн зарчмаар буюу ИХ-ийн 58 дугаар зүйлд зааснаар ноцтой төөрөгдлийн улмаас хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход тухайн хэрэглэгч ямар нэгэн хайхрамжгүй, болгоомжгүй үйлдэл гаргаагүй байх, хэрэв ийнхүү хайхрамжгүй үйлдэл гаргасан тохиолдолд хэлцлийн нөгөө талд хэлцлээс үүдсэн хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй болно.

Учир нь манай ИХ-д ноцтой төөрөгдсөн гэдэг үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тохиолдолд тухайн төөрөгдсөн этгээд нь аж ахуй эрхлэгч үү, эсвэл хэрэглэгч байсан уу гэж субъектийн хувьд ялгаж авч үздэггүй. Гэхдээ

ийнхүү ялгамжтай зохицуулаагүй нь ИХ-ийн дутагдал биш бөгөөд үүнийг тусгай хэрэглэгчийн гэрээний асуудал болгон авч үздэг.

Гэтэл хэрэглэгч аж ахуй эрхлэгчийн санал болгож буй цахим систем (*platform*)-ийг ихэвчлэн цахимаар ашиглан хүсэл зориггоо илэрхийлэх үед компьютерын товчоо андуурч дарах, илүү дарах, гар утасны дэлгэцийн харагдах байдал нь ердийн хэмжээнээс жижиг байдгаас давхар дарагдах гээд болгоомжгүй хийгээд хайхрамжгүй үйлдэл гаргах нь техникийн шинжтэй түгээмэл алдаа юм. Энэ бүх тохиолдолд хэлцлийн нөгөө тал болох аж ахуй эрхлэгчээс хайхрамжгүй хандсан тул хэлцлийг хүчинтэй гэж үзэж гэрээний үүргийн гүйцэтгэлтийг шаардах, эсвэл хэлцэл хийгч тал өөрийн хайхрамжгүй, болгоомжгүй үйлдлийн улмаас төөрөгдөж, хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулсан тул хохирол шаардах зэргээр хэрэглэгчид илүү дарамт үүсгэх эрх зүйн тогтолцоо бүрддэг. Өөрөөр хэлбэл, манай улсын ИХ-ийн 58 дугаар зүйлийн 58.7-д *“хэлцлийн нэг тал хайхрамжгүйгээс төөрөгдсөн, эсхүл энэ хуулийн 58.4-т заасан үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулсан бол гэм буруутай этгээд хэлцлийн нөгөө тал болон гуравдагч этгээдэд учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй”* гэж зааснаас харж болно.

Тиймээс В2С хооронд байгуулах цахим хэлцлийн хувьд хэрэглэгчийн төөрөгдөл буюу алдааны улмаас хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцоход аливаа гэм буруугийн хэлбэрийг шаардахгүй байх тусгай зохицуулалт шаардагддаг.²³

Түүнчлэн ИХ-д заасан агуулгын төөрөгдлөөс гадна 1. Хэрэглэгч угаас аж ахуй эрхлэгчтэй хэлцэл хийх хүсэл зориггүй байхдаа хэлцэл хийсэн, 2. Хэрэглэгч цахим системийг

²³ 経済産業省 電子消費者契約及び電子承諾通知に関する民法の特例に関する法律逐条解説 p.2
Японы Эдийн засаг, аж үйлдвэрийн яам “Цахим хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн тайлбар” 2 дахь тал.

ашиглаж илэрхийлсэн хүсэл зориг, гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл зэргийг илгээхдээ өөрийн хүсэл зоригоос өөрөөр буюу буруу илгээсэн тохиолдлыг хамааруулж авч үзнэ. Харин энэхүү тусгай зохицуулалт нь аж ахуй эрхлэгчийн хүсэл зоригийн илэрхийлэл төөрөгдсөн үед үйлчлэхгүй. Учир нь аж ахуй эрхлэгч нь тухайн цахим системийг өөрөө бий болгосон, хэрэглэгчтэй харьцуулахад харьцангуй өндөр мэдлэг чадвартай байж, тухайн хэлцлийн үр дүнд хэрэглэгчид хохиролтой нөхцөл үүсгэхгүй байх ёстой.

Мөн ИХ дахь ноцтой төөрөгдлийн улмаас хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцох ерөнхий зохицуулалтаас хэрэглэгчийн цахим гэрээний онцлогийг ялгаатай зохицуулах дараах шаардлагууд байдаг. Үүнд:

Нэг. Цахим хэрэглэгчийн гэрээний хувьд аж ахуй эрхлэгчийн урьдчилж бэлдсэн цахим системийн дэлгэцэд илэрхийлэгдэх дарааллын дагуу хүлээн зөвшөөрөх гэсэн тэмдэглэгээг дарснаар гэрээ байгуулах хүсэл зоригийг илэрхийлэх бөгөөд өөрийн овог нэр, хаяг, тоо хэмжээ, гэрээний агуулга зэргийг нөхөж бичин илгээх товчийг дарснаар гэрээ байгуулах хүсэл зоригийн илэрхийллийг нөгөө талдаа илгээнэ.

Хоёр. Үүний үр дүнд аж ахуй эрхлэгч тал урьдчилан хүсэл зоригоо хангалттай сайн судлан үзсэний үндсэн дээр түүнийгээ үг, үсгийн хэлбэрт оруулан хэлбэржүүлснийг нөгөө талд хэрэглэгчийн хувьд зөвхөн цахим системд мэдээллээ оруулах хэлбэрээр хүсэл зоригоо илэрхийлэх нь аман болон бичгэн гэрээ, хэлцэлтэй харьцуулахад алдаа гаргах магадлал харьцангуй их байдаг.

Гурав. Дээр дурдсанчлан ердийн бусад хэлбэрийн гэрээ байгуулах үе шаттай харьцуулахад хэрэглэгчийн хийх цахим хэлцэл нь технологи ашиглах явцад алдаа гарах магадлал өндөр ба нөгөө талд аж ахуй эрхлэгчийн хувьд хэрэглэгч ийм

алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх технологийн шийдлээр арга хэмжээ авах боломжтой зэргээс ноцтой төөрөгдлийн улмаас хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахад ижил үүрэг оногдуулах нь эсрэгээрээ тэгш бус нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй.

Дөрөв. Дээр дурдсанчлан цахим хэрэглэгчийн гэрээ байгуулах үеийн онцлог хийгээд аж ахуй эрхлэгчийн хувь хэрэглэгч технологи ашиглахад алдаа гаргахаас сэргийлэх арга хэмжээ авах боломжтой боловч тийнхүү арга хэмжээ аваагүй, авах үүргээ биелүүлээгүйгээс хэрэглэгч төөрөгдлийн улмаас гэрээг хүсэл зоригийн илэрхийллээ хүчингүй болгоход болгоомжгүй хийгээд хайхрамжгүй хандсан гэх нөхцөлийг тавихгүй байх нь хэлцлийн баталгаат байдлыг зөрчих үндэслэл болохгүй.

Тав. Тиймээс цахим хэрэглэгчийн гэрээнд талуудын диспозитив зарчмын үүднээс ИХ дахь ноцтой төөрөгдлийн улмаас хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах ерөнхий зохицуулалтаас ялгамжтай буюу хэрэглэгч төөрөгдсөн байсан ч хэлцлийг хүчин төгөлдөр бус болгоход гэм буруу шаардахгүй, хохирол нөхөн төлөх үүрэг хүлээлгэхгүй тусгай зохицуулалт шаардлагатай.²⁴ Мөн цахимаар үйлчилгээ үзүүлэгч аж ахуй эрхлэгч нь заавал хүсэл зоригийн илэрхийлэл үнэн зөв байгаа эсэх, гэрээний агуулгатай нийцэж байгаа эсэхийг хэрэглэгч дахин нягтлах боломжийг бүрдүүлсэн технологийн шийдлийг санал болгох үүрэгтэй байх ёстой.

Б. Цахимаар гэрээ байгуулах хугацаа

Орчин үеийн техник технологийн хөгжил нь хүн бүрийг заавал биеэр уулзах болон захидал, шуудангаар харилцахгүйгээр

²⁴ 経済産業省 電子消費者契約及び電子承諾通知に関する民法の特例に関する法律逐条解説 pp 17-18. Япон улсын Эдийн засаг, аж үйлдвэрийн яам “Цахим хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн тайлбар” 17-18 дахь тал.

интернэт, бусад сүлжээний төхөөрөмж ашиглан нүүр нүүрээ харж ярих, гэрээний талууд орон зайнаас үл хамаарч хүсэл зоригоо шууд болон цахим шуудан, онлайн худалдааны систем ашиглан нэн даруй илэрхийлэх боломжтой болсон зэрэг гэрээ, хэлцлийг богино хугацаанд, зардал багатай, хялбар аргаар байгуулах боломжтой болгосон юм.

Ялангуяа 2020 онд дэлхий дахинд тархсан COVID 19 цар тахлын улмаас аж ахуйн нэгж, байгууллагууд цахимаар буюу гэрээсээ, зайнаас ажиллах нь түгээмэл болж, түүнийг даган бичгээр гэрээ хэлцэл хийхээс аль болох зайлсхийж, цахим технологийн тусламжтай үйл ажиллагаагаа удирдах нь эрчимтэй нэмэгдэв.

Энэ бүх нөхцөл байдал нь интернэт, цахим орчин бидний өдөр тутмын ажил, амьдралд ихээхэн өөрчлөлтийг авчирч байгаа ч үүнийг дагасан эрх зүйн орчин бүрэлдэн бий болсон уу гэдэг нь асуулт хэвээр байна. Гэхдээ энэ нь зөвхөн манай улсын хувьд ч бус дэлхийн бусад оронд ч нийтлэг тулгарч буй асуудал юм.

Тэгвэл энэхүү хэсэгт яагаад цахим гэрээ ба цахим арга хэрэгслийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлэх явц нь бичгэн болон аман хэлбэрийн гэрээтэй адил байх уу эсвэл ялгаатай байх уу гэдгийг авч үзэх шалтгаан нь цахим хэлцэл буюу цахим гэрээ нь нүүр тулсан шууд тохиролцоогоор гэрээ хийх, талууд хоорондоо захидал харилцаа илгээх хэлбэрээр зайнаас гэрээ байгуулах зэргээс зарчмын хувьд ялгаатай байгаад оршино.

Тодруулбал, талууд бие биедээ гэрээ байгуулах талаар цахим шуудан илгээж, түүнийг хүлээн зөвшөөрсөн хариугаа цахим шуудангаар илгээх нь цахим гэрээ гэж үзэх үү, эсвэл зөвхөн цахим арга хэрэгслийг ашиглан гэрээ байгуулах хүсэл зоригоо илэрхийлсэн үү гэдгийг тодруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, ингэж байж гэрээ хэзээ байгуулагдсан огноо,

талуудын хооронд гэрээний үүрэг үүссэн үү, үгүй юү гэдгийг зөв тодорхойлсны үндсэн дээр гэрээ бодитоор хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Мөн аман болон бичгэн гэрээ байгуулагдсан гэж үзэх огноог тогтоохдоо гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн тухай хариугаа илгээснээр (Хүлээн зөвшөөрөх санал илгээснээр гэрээ байгуулагдсанд тооцох үзэл баримтлал) тухайн хариу нөгөө талд хүрсэн эсэхээс үл хамаарч гэрээ байгуулагдсан уу эсвэл хүлээн зөвшөөрөх санал нөгөө талд хүрснээр (Хүлээн зөвшөөрөх санал нөгөө талд хүрснээр гэрээ байгуулагдсанд тооцогдох үзэл баримтлал) гэрээ байгуулагдсан уу гэдгийг тодорхойлох шаардлага үүсдэг.

Тухайлбал, дээрх хоёр нөхцөлийн хувьд Ром-Германы буюу эх гарын эрх зүйн тогтолцоотой улсуудад хүлээн зөвшөөрөх санал хүрснээр гэрээ байгуулагдана гэж үздэг бол Англи-Америкийн эрх зүйн тогтолцоонд хүлээн зөвшөөрөх санал илгээснээр гэрээ байгуулагдсанд тооцох аргыг ашигладаг байна.²⁵ Гэвч үүнийг бүх төрлийн гэрээ буюу хэрэглэгчээс хэрэглэгч хоорондын (цаашид “C2C” гэх), бизнес эрхлэгчээс бизнес эрхлэгч хоорондын (цаашид B2B гэх) гэрээнд тусгайлан авч үзэхгүй харин бизнес эрхлэгчээс хэрэглэгч хоорондын (цаашид B2C гэх) гэрээнд тусгайлан авч үздэг байна.

Учир нь C2C гэрээний хувьд цахимаар тогтмол гэрээ

²⁵ Англи, АНУ, Япон улсын хувьд зайнаас гэрээ байгуулахад нөгөө талд хүлээн зөвшөөрөх санал илгээснээр гэрээ байгуулсанд тооцдог. Учир нь зайнаас гэрээ байгуулахад гэрээ байгуулах саналыг хүлээн авч, түүнийг хүлээн зөвшөөрсөн саналаа шуудан зэргийг ашиглан илгээхэд тодорхой хугацаа шаарддаг тул гэрээний хэрэгжилтийг шуурхай байлгах зорилгоор хүлээн зөвшөөрснөөр гэрээ байгуулах зарчмыг ашигладаг байна. (Adams v Lindsell) Гэвч цахимаар гэрээ байгуулах нь зайнаас гэрээ байгуулахтай адил гэж үзэж байсан боловч цахимаар гэрээ байгуулахад хүлээн зөвшөөрөх санал нэн даруй санал гаргагч талд хүрэх боломжтой бөгөөд нэг тал нь хэрэглэгч, нөгөө тал нь бизнес эрхлэгч бүхий гэрээнд хүлээн зөвшөөрөх санал илгээснээр гэрээ байгуулагдсанд тооцох нь хэрэглэгчийн хувьд ашиггүй тул хариу хүлээн зөвшөөрөх санал хүрснээр гэрээ байгуулагдсанд тооцдог байхаар зохицуулсан байна. (Entres Ltd. v Miles Far East Corp.)

байгуулах шаардлага гардаггүй тул аман болон бичгэн хэлбэрээр гэрээ байгуулах зохицуулалтаас ялгамжтай зохицуулалт шаарддаггүй байна. Харин B2B гэрээний хувьд аль аль тал нь энгийн хэрэглэгчтэй харьцуулахад харьцангуй тухайн гэрээ, хэлцлийн талаар харьцангуй илүү мэдлэгтэйн сацуу тухайн гэрээ хэлцлийн үр дүнгээс ашиг хүртэх зорилго агуулж байдаг. Иймд хуулийн зохицуулалтаас илүүтэй гэрээний агуулгыг харилцан тохиролцох, өөр өөрсдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг хийх боломжтой тул C2C гэрээний адил ИХ-ийн нийтлэг гэрээ байгуулах зохицуулалтад хамаардаг байна.

Гэтэл B2C гэрээний харилцаанд нэг талаас бизнес эрхлэгч буюу илүү өндөр түвшний мэдлэг чадвартай субъекттэй жирийн хэрэглэгч гэрээ байгуулахад хэрэглэгч илүү доогуур байр сууринд байх тул ИХ-ийн нийтлэг зарчим буюу санал илгээснээр гэрээ байгуулах зарчмыг бус хүлээн зөвшөөрөх санал хүрснээр гэрээ байгуулагдсанд тооцдог байх зарчмыг авч үздэг. Тодруулбал, хэрэглэгч нь бизнес буюу аж ахуй эрхлэгчтэй байгуулах гэрээний хувьд тухайн гэрээний эрсдэлийг бүрэн дүүрэн таньж мэдэх боломж хязгаарлагдмал, энэ талаарх мэдлэг дутах зэргээр сул талыг үүсгэдэг.

Тэгвэл манай улсын хувьд цахимаар хэлцэл хийх тохиолдолд гэрээ байгуулагдсан огноог дээрх хоёр зарчмын алинаар тогтоодог болохыг авч үзье. ИХ-ийн 42^{1.2}-т “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно”, 196 дугаар зүйлийн 196.1.8-д “цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн

хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлснийг харилцан хүлээн зөвшөөрч цахим гарын үсэг зурснаар гэрээ байгуулсанд тооцно” гэж зааснаас гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн хариу санал хүрснээр гэрээ байгуулах зарчмыг хуульдаа тусгасан байна.

Энэ нь дээр дурдсанчлан хэрэглэгчийн цахим гэрээний хувьд хэрэглэгчийн эрхэд нийцсэн зохицуулалт гэж дүгнэж байна.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн ИХ-д оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль батлагдахаас өмнөх эрх зүйн орчинд гарсан шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн болно.

2.1. ЦАХИМ ГЭРЭЭГ БАЙГУУЛАХААС ӨМНӨ БИЧГЭЭР ӨӨР ГЭРЭЭ БАЙГУУЛСАН БАЙХ УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛИЙГ ШҮҮХ ҮНЭЛЖ, ДҮГНЭСЭН БАЙДАЛ

Банк, санхүүгийн байгууллага хэрэглэгчидтэй цахимаар гэрээ байгуулж цахим зээл олгох үйлчилгээг нэвтрүүлснээр хэрэглэгчид ч идэвхтэй авч ашиглаж байна. Гэхдээ ИХ-ийн 451.2 “Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээг бичгээр хийнэ”, мөн хуулийн 451.3-т “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна” гэж зааснаар нарийвчилсан харилцааг 1995 оны 10 дугаар сарын 31-ны өдөр батлагдсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулж (цаашид “БЭБХЭМХТТЗҮАтХ” гэх) ирсэн. Тус хуулийн 22 дугаар

зүйлээр зохицуулсан зээлийн гэрээ, мөн 23 дугаар зүйлээр зохицуулсан зээлийн хувийн хэргийн талаарх зохицуулалт, тухайн үеийн хууль тогтоогчийн хууль батлан гаргасан үзэл санаа зэргээс үзвэл банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн гэрээг бичгээр байгуулах зохицуулалттай байсан ба зээлийн үйл ажиллагааг цахимаар явуулах, зээлийн гэрээг цахимаар хийх талаарх зохицуулалтыг тусгаагүй байв.

Мөн Улсын Дээд Шүүхийн (цаашид “УДШ” гэх) 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 01 тоот зөвлөмжид “БЭБХЭМХТТЗҮАмХ-ийн 24 дүгээр зүйлийн 1-д зааснаар зээлийн хүц нь зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцсон зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнэ юм. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээг заавал бичгээр хийх бөгөөд зээлийг хүцтэй олгосон бол гэрээнд зээлийн хүцгийн хэмжээг тодорхой тусгах нь Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.1-д заасантай нийцнэ” гэсэн байдаг.

Үүнээс үзвэл банк санхүүгийн байгууллагаас олгох зээлийн гэрээг заавал бичгээр хийх эрх зүйн зохицуулалт үйлчилж байсан нь харагдана. Хэрэв зээлийн гэрээг бичгээр байгуулах хуулийн шаардлагыг зөрчиж, гэрээ байгуулсан тохиолдолд ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8-т заасан “Хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн хэлцэл”-д хамаарч, зээлийн гэрээ анхнаасаа эрх зүйн үр дагавар үүсгэхгүй, хүчин төгөлдөр бус хэлцэл болох юм.

Иймд банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд энэхүү хуулийн саадыг тойрч гарахын тулд цаасан суурьтай гэрээ буюу “Үйлчилгээний мастер гэрээ”, “Цахим зээлийн эрх нээх гэрээ” (цаашид “Ерөнхий гэрээ” гэх) зэрэг бичгэн гэрээг байгуулж, уг гэрээнд үйлчилгээний ерөнхий нөхцөлийг тусгаж, хэрэглэгчид цахимаар зээл авах эрхийг нь олгож, мөн хэрэглэгчдэд цахимаар нэвтрэх нэр болон нэвтрэх

нууц дугаарыг олгох, улмаар харилцагчид олгосон нууц дугаарыг гарын үсэгтэй адилтгах байдлаар цахимаар зээл олгож байв. Гэвч үйлчилгээ үзүүлэх “Ерөнхий гэрээ”-нд зээлийн хэмжээ, зээлийн хугацаа, хүүгийн хэмжээ зэргийг заах боломжгүй буюу эдгээр нөхцөл нь харилцагчийн хүсэл зоригоос хамаарч шийдэгдэнэ. Мөн “Ерөнхий гэрээ” нь харилцагчид шууд зээл олгож, зээлийн гэрээний эрх үүргийг үүсгэхгүй бөгөөд гагцхүү цахимаар зээл авах эрхийг олгож буй ерөнхий гэрээ юм.

Тэгвэл харилцагч цахимаар зээл авах хүсэлт гаргаж, банк санхүүгийн байгууллагаас харилцагчийн дансанд зээлийг шилжүүлснээр зээлийн гэрээний харилцаа үүсэх юм. Энэхүү Ерөнхий гэрээнд заасан ерөнхий нөхцөл, цахим үйлчилгээ авах эрх олгосон үйлдэлд үндэслэн “Цахим зээлийн гэрээ” буюу “Тусгай гэрээ”-г байгуулж байна. Өөрөөр хэлбэл, Ерөнхий болон Тусгай гэсэн хоёр төрлийн гэрээний харилцаа үүснэ. Тэгвэл энэ хоёр гэрээний хоорондын харилцан хамаарал, хоорондоо зөрчилдсөн тохиолдолд аль гэрээ нь давуу үйлчлэх зэрэг асуудал хөндөгдөнө.

Ерөнхий гэрээ нь үргэлжилсэн шинжтэй байнга давтагдаж байх гэрээ хэлцэлд ашиглагдах гэрээ юм.²⁶ Гэрээний нөгөө талтай байнга давтагдах харилцаанд тэр болгон гэрээний нөхцөлийг нэг бүрчлэн тохиролцож, хэлэлцэж гэрээ байгуулах нь төвөгтэй тул талууд байнга давтагдах гэрээ хэлцэл, худалдааны харилцаанд үйлчлэх ерөнхий нөхцөлийг урьдчилан тохиролцож, Ерөнхий гэрээг байгуулдаг байна.²⁷ Харин Тусгай гэрээ бол хэлцэл тус бүрд үйлчлэх нарийвчлан тогтоосон агуулга бүхий гэрээ юм. Тухайлбал, төлбөр тооцоо хийх арга,

²⁶ “基本契約と個別契約の違いとは？ 基本を解説！,” keiyaku-watch, accessed September 7, 2021, <https://keiyaku-watch.jp/media/kisochishiki/kihon-kobetsu-keiyaku>.

²⁷ “基本契約書とは？ 個別契約との違いと、民法改正を踏まえた作成方法 | 脱印鑑応援ブログ「ハンコ脱出作戦」,” 「ハンコ脱出作戦」by電子印鑑GMOサイン, May 10, 2021, <https://www.gmosign.com/media/electronic-contract/post-154/>.

төлбөр төлөх хугацаа, өмчлөх эрх шилжих үе зэрэг байнга давтагдах нөхцөлүүдийг Ерөнхий гэрээнд тусгах бол захиалга өгсөн барааны төрөл, тоо зэрэг тухайн тохиолдол бүрд өөр өөр байх нөхцөлийг Тусгай гэрээгээр зохицуулах юм.

Хэрэв энэ хоёр гэрээ хоорондоо зөрчилдвөл тухайн гэрээ-нүүдэд аль гэрээний заалт давуу үйлчлэх талаарх зохицуулалтыг баримтлах ба ийм зохицуулалт гэрээнд байхгүй бол тухайн тохиолдол нөхцөл байдал, талуудын хүсэл зориг, гэрээг тайлбарлах замаар шийдвэрлэнэ. Ерөнхий гэрээг талууд урт хугацааны турш хэлэлцэн, нухацтай авч үзэж байгуулдаг бол Тусгай гэрээг тохиолдол нэг бүрд богино хугацаанд хэлэлцэн байгуулж байдаг онцлогтой.²⁸ Хэрэв талууд нэгдсэн нэг ойлголтоор гэрээний харилцааг тайлбарлах нь зүйтэй гэж үзвэл Ерөнхий гэрээг давуу үйлчилж байхаар, харин илүү уян хатан шинжтэй тухайн нөхцөлд тохируулан арга хэмжээ авахаар бол Тусгай гэрээг давуу үйлчилж байхаар тохиролцдог байна.

Гэтэл шүүхээс Ерөнхий гэрээ ба Тусгай гэрээний харилцааг ялгаж дүгнэхгүй байгаа дүр зураг харагдаж байгааг дараах тохиолдлоос харж болно.

Шүүхийн шийдвэр 1.

Баянхонгор аймгийн Анхан шатны шүүхийн шийдвэр,²⁹ давж заалдах шатны шүүхийн магадлал³⁰

Хэргийн товч агуулга:

Ц.Ү нь Төрийн банкны Гялс банкны үйлчилгээнд бүртгүүлж, интернэтээр гүйлгээ хийх, хадгаламж барьцаалсан онлайн

²⁸ “基本契約と個別契約の違いとは？基本を解説！.”

²⁹ Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатын шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн, дугаар 261 тоот шийдвэр.

³⁰ Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 14 тоот магадлал.

зээл авах эрх нээлгэсэн. Хадгаламж барьцаалсан зээлийн журмаар харилцагч хадгаламжийн 90 хүртэл хувьд хадгаламж барьцаалсан онлайн зээл авах боломжтой байдаг. Онлайнгаар зээл авч байх хугацаанд тухайн харилцагчийн онлайн бүртгэлд программын алдаа гарч нийт 6,860,000 төгрөгийн онлайн хадгаламж барьцаалсан зээл авсан бөгөөд хадгаламжийн дүнгээс давсан илүү дүнгээр зээл олгогдсон. Иймд үндсэн зээлийн үлдэгдэл 4,157,039.23 төгрөг, зээлийн хүүгийн өр 960,095.03 төгрөг, торгуулийн хүүгийн өр 76,998.75 төгрөг, нийт 5,194,133 төгрөг төлөөгүй тул Ц.Ү-ээс гаргуулахаар нэхэмжилжээ.

Хариуцагч Ц.Ү-ийн сөрөг нэхэмжлэл:

Төрийн банктай 2015 оны 11 дүгээр сард “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-г байгуулж, цахим үйлчилгээ авах эрх нээлгэсэн. Үүний дагуу хадгаламж барьцаалсан зээл авч байсан. Нэхэмжлэгч намайг илүү зээл авсан гэж хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хамт нэхэмжлэл гаргасан боловч хэрэгт авагдсан шинжээчийн дүгнэлтээр уг зээл нь системийн алдаанаас олгогдсон гэж дүгнэсэн. Миний бие энэхүү “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ” гэх зүйлийг хийснээс бус өөр ямар нэгэн байдлаар зээл авах талаар дахин гэрээ хийгээгүй. Гэтэл дээрх ерөнхий гэрээг зээлийн гэрээ хийсэнтэй дүйцүүлж үзэж хүү, алданги төлүүлэхээр нэхэмжлэл гаргасан нь үндэслэлгүй бөгөөд энэхүү “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ” нь хуульд заасан шаардлага зөрчсөн гэрээ байгаа тул Төрийн банктай байгуулсан “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-г бүхэлд нь хүчингүй болгож өгнө үү. Хэрвээ цахим хэлбэрээр гэрээ хийж болно гэж үзэхэд тухайн банканд тоон гарын үсэг буюу цахим гарын үсгийн систем нэвтрээгүй байгаа нь гэрээг хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлийг үгүйсгэж байна. Учир нь цахим гэрээ гэдэг нь 2 тал хоёулаа тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог. Үүнийг 2011 онд ИХ-д нэмэлт өөрчлөлтөөр орсон 42^{1.1} дүгээр зүйлд тодорхой заасан. Иймд ИХ-ийн 56-р зүйлийн 56.1.8-д заасан “*хуулиар тогтоосон*

хэлбэрийг зөрчсөн” буюу хүчин төгөлдөр бус байх хэлцэлд хамаарч байх ба ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээг бичгээр хийнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна. Иймд зээлийн гэрээний харилцаа үүсээгүй гэж маргажээ.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

“Төрийн банк” ХХК болон хариуцагч Ц.Ү нарын хооронд байгуулсан “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-ний 1.1-д: “Энэхүү гэрээний зорилго нь харилцагч нэгж дээр ирж эсхүл онлайнаар хүсэлт илгээж банканд данс эзэмших, мөнгө байршуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх, дансан дахь мөнгөн хөрөнгийг хамтран эзэмших, өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх, банкны бүх төрлийн үйлчилгээ авах, ашиглахтай холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино”, гэрээний 2.11-т: “Гэрээний 4.1.11-д дурдсан үйлчилгээг энэхүү гэрээ болон гэрээний 2.10-т заасан нууцлалуудыг ашиглан баталгаажуулсан цахим гэрээгээр зохицуулах ба харилцагч хадгаламж барьцаалсан онлайн зээл авахад өөрийн цахим банкны эрхээр хандсанаар зээлийн гэрээ байгуулагдсанд тооцно” гэж тус тус зааснаас үзвэл уг “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-г Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу зохигчдын хооронд байгуулсан Цахим зээлийн гэрээ гэж үзэх үндэслэлтэй боловч уг гэрээнд зээлийн хүү, торгуулийн талаар талууд тохиролцоогүй байна. Иймд “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-ээр хариуцагч Ц.Ү-гийн 21 удаагийн үйлдлээр авсан хадгаламж барьцаалсан зээлийг Төрийн банкнаас Ц.Ү-д хүү, торгууль тооцохгүйгээр олгосон зээл гэж үзэж, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн шаардлагыг хүчингүй болгож, үндсэн зээлийн хэмжээгээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

Шүүх сөрөг нэхэмжлэлийн хувьд “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ” нь “хуульд заасан шаардлага зөрчсөн буюу

санал гаргагч тал нь өөрт учирсан бодит хохирлоос хэт давсан хэмжээний нөхөн төлбөр шаардахаар тогтоосон, өөрийн хэт болгоомжгүй үйлдлийн улмаас учирсан хохирлыг хариуцахыг үгүйсгэсэн буюу хязгаарласан гэрээ байна” гэсэн нь үндэслэлгүй байх тул хариуцагч Ц.Ү-гийн гаргасан сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

“Төрийн банк” ХХК болон хариуцагч Ц.Ү нарын хооронд байгуулсан “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ” нь хадгаламжийн барьцааны дүн болох 1,143,322 төгрөгт хүртэлх хэмжээнд буюу зээл авах эрхийн хэмжээндээ “Цахим үйлчилгээний гэрээ” нь хүчинтэй, харин зээл авах эрхтэй үнийн дүнгээсээ хэтэрч байгаа тохиолдолд зээлийн гэрээ буюу “Цахим үйлчилгээний гэрээ” гэж үзэх үндэслэлгүй байна.

Хариуцагч Ц.Үгийн “Төрийн банк”-аас илүү авсан зээл нь Иргэний хуулийн бусдын хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авах гэсэн хуулийн зохицуулалтад хамаарч байхад анхан шатны шүүх “Төрийн банк” болон хариуцагч Ц.Ү нарын хооронд илүү авсан зээлийн харилцааг “ИХ-ийн Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох үйл ажиллагаа” гэж үзэж ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1-д зааснаар хэргийг шийдвэрлэсэн нь үндэслэлгүй гэж дүгнэсэн. Мөн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гэж дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Анхан шатны шүүх талуудын хооронд байгуулагдсан “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-г ИХ-ийн 42^{1.1}-т заасан “Цахим зээлийн гэрээ” гэж үзэх үндэслэлтэй боловч уг гэрээнд хүү, торгуулийн талаар тохиролцоогүй тул “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-ээр хүүгүй зээлийн гэрээ байгуулагдсан гэж дүгнэсэн. Шүүгчийн энэ дүгнэлтээс үзвэл “Цахим үйлчилгээний

ерөнхий гэрээ” болон “Цахимаар байгуулагдаж буй зээлийн гэрээ” хоёрыг нэг гэрээ мэтээр дүгнэсэн нь харагдана.

Бичгээр байгуулсан “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-нд зээлийн хэмжээ, хугацаа, улмаар хүүгийн хэмжээг тусгах боломжгүй. Энэ нь зээлдэгчийн хүсэл зоригоос хамаарч өөрчлөгдөнө. ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1-т “...зээлдэгч нь мөнгөн хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэх...” үүргийг хүлээж байдаг, мөн БЭБХЭМХТТЗҮАтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.4-т зааснаар “Зээлдэгчийн зээлийн дансанд гүйлгээ хийгдсэнээр зээлийг олгосонд тооцно” гэж зохицуулсан ба “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-г байгуулснаар зээлдүүлэгчид дээр дурдсан үүрэг үүсээгүй болно. Өөрөөр хэлбэл, “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-ээр зөвхөн үйлчилгээний нөхцөлийг танилцуулж, цахимаар банкны үйлчилгээг авах эрхийг л олгож байгаа ерөнхий гэрээ юм. Харин зээлдэгчийн зүгээс цахим системээр дамжуулан зээлийн хэмжээ, хугацааг оруулан зээл авах хүсэлт гаргаснаар банкны цахим системд автоматаар зээлийн хүү, бусад нөхцөл бүхий гэрээний нөхцөлүүд бэлэн болох бөгөөд банкнаас олгосон нууц үгээ ашиглан зээлийн гэрээг баталгаажуулж, банкнаас зээлийн дансанд мөнгөн хөрөнгийг шилжүүлснээр зээлийн гэрээ байгуулагдаж байна.

Гэхдээ тухайн үед ИХ-ийн 42 дугаар зүйлийн 42^{1.2}-т “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно” гэдэг хуулийн зохицуулалттай байсан. Өөрөөр хэлбэл, дээрх тохиолдолд банк болон Ц.Ү-ийн хооронд байгуулсан цахим зээлийн гэрээнд тоон гарын үсгийг ашиглаагүй тул ИХ-ийн 56.1.1-т заасан хууль зөрчсөн хэлцэл, ИХ-ийн 56.1.8-д заасан хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн хэлцэлд хамаарч, зээлийн гэрээ хүчин төгөлдөр болж чадаагүй байна.

Иймд талуудын хооронд хүчин төгөлдөр зээлийн гэрээ байгуулагдаагүй тул банкны зүгээс хүү, нэмэгдүүлсэн хүү шаардах эрхгүй болох юм. Харин ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1-т заасныг удирдлага болгон үндэслэлгүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгөө буцаан шаардах эрхтэй байна.

Харин Давж заалдах шатны шүүх “зээл авах эрхийн хэмжээнд талуудын хооронд цахим зээлийн гэрээ хүчин төгөлдөр байгуулагдсан” гэж дүгнэсэн. Ингэхдээ хоёр тусдаа үүргийн харилцаа үүссэн эсэх, цахим гэрээ байгуулагдсан гэж үзэж байгаа бол ИХ-д заасан тоон гарын үсгээр цахим хэлцэл байгуулах хуулийн шаардлагатай хэрхэн уялдаж байгаа талаар дүгнэлт хийгээгүй. Давж заалдах шатны шүүх “Цахим зээлийн гэрээ нь” зээл авах эрхийн хэмжээнд хүчинтэй гэж дүгнэсэн мөртөө зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү шаардсан шаардлагыг бүхэлд нь хүчингүй болгосон нь логик зөрчилтэй байна.

Анхан болон Давж заалдах шатны шүүхийн шийдвэрээс дүгнэвэл: Цахимаар буюу аппликэйшнээр зээлийн хүсэлт явуулан байгуулж буй “Цахим зээлийн гэрээ” болон урьдчилан бичгээр үйлдэж, гэрээ байгуулж буй “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ” хоёрыг ялгаж, тусад нь авч үзээгүй байна.

2.2. ЦАХИМ ГЭРЭЭНИЙ ХЭЛБЭР, ТҮҮНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДЛЫГ ШҮҮХ ҮНЭЛЖ ДҮГНЭСЭН БАЙДАЛ

Шүүхийн шийдвэр 2.

СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Хэргийн товч агуулга:

Зээлдэгч О нь манай байгууллагатай “Цахим зээлийн эрх нээх гэрээ” байгуулж, 230,000 төгрөгийг 45 хоногийн хугацаатай,

15,615 төгрөгийн шимтгэл төлөх, мөн хугацаа хэтэрсэн тохиолдолд 1 сарын 4 хувийн хүү төлөх нөхцөлөөр зээлдэж авсан юм. Бидний хооронд байгуулсан зээлийн гэрээний “4 дүгээр зүйлийн 4.2.2-т: Зээл тус бүрийн эргэн төлөх хугацаанд тухайн ашигласан зээлийн дүнг, түүнд ногдох шимтгэлийн хамт үл маргах журмаар төлөх; 4 дүгээр зүйлийн 4.2.3-т: Зээл, зээлийн шимтгэлийг тухайн зээлийн эргэн төлөх хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд хүү төлөх” гэж заасан. Манай байгууллагын зүгээс гэрээний 5 дугаар зүйлийн 5.1.5-д зааснаар зээл болон зээлийн шимтгэлийг эргэн төлөх хугацаанд төлөөгүй тохиолдолд хүү тооцож эхлэх эрхтэй бөгөөд эдгээр төлбөрийг нэхэмжлэх эрхтэй гэж заасан. Зээлдэгч О нь өнөөдрийг хүртэл зээл, зээлийн хүү, шимтгэлийг төлөөгүй тул зээлийн төлбөрт 230,000 төгрөг, шимтгэлийн төлбөрт 15,615 төгрөг, хүүгийн төлбөрт 47,183 төгрөг төлөхөөр байна. Иймд хариуцагч О-оос нийт 292,798 төгрөг нэхэмжилсэн.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Хариуцагч О нь шүүх хуралдааны товыг мэдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тул түүний эзгүйд хэргийг шийдвэрлэв.

Талуудын хооронд байгуулсан “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-нд заасан 15,615 төгрөгийн шимтгэл нь Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.1 дэх хэсэгт заасан зээлийн хариу төлбөр болох хүүгийн төлбөр гэж үзэхээр байна. Мөн нэхэмжлэгч нь хэтрүүлсэн хугацааны хүү гэх агуулгаар 47,183 төгрөг нэхэмжилсэн нь Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.1-д заасан нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр бус мөн хуулийн 452 дугаар зүйлийн 452.1-д заасан ердийн хүүгийн төлбөр гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, талууд “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-г байгуулж мөнгө зээлэхдээ гэрээний хугацаанаас хамаарч, 2 өөр төрлийн хүү тооцохоор харилцан тохиролцсон гэж үзэхээр байна. Тухайлбал, талууд

уг гэрээгээр, зээл авснаас хойш 45 хоногийн хугацаанд 15,615 төгрөгийн хүү төлөх, 45 хоногоос хойш үндсэн зээлийн төлбөр болох 230,000 төгрөгөөс 4 хувийн хүү тооцож төлөх талаар тус тус тохиролцжээ. Иймд нэхэмжлэгч нь “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ний дагуу үндсэн зээлийн төлбөрт 230,000 төгрөг, гэрээний 2.1.7-д заасан хүүгийн төлбөрт 15,615 төгрөг, гэрээний 2.1.6.2-т заасан хүүгийн төлбөрт 47,183 төгрөгийг тус тус хариуцагчаас нэхэмжлэх эрхтэй байна. Талуудын хооронд байгуулагдсан “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-г хүчин төгөлдөр бус гэж үзэх Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д заасан үндэслэл тогтоогдоогүй, уг гэрээний дагуу нэхэмжлэгч нь шаардлага гаргах хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөөгүй тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Шүүгч хэргийг шийдвэрлэхдээ “Цахим зээлийн эрх нээх” гэрээ болон “Зээлийн гэрээ”-г тусад нь ялгаж салгаж дүгнээгүй болох нь харагдаж байна. Үүний үр дүнд бичгээр байгуулсан “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ний хүчин төгөлдөр байдлыг л дүгнэсэн байх ба цахимаар зээл авах хүсэлт гаргасан зээл авах зээлдэгчийн хүсэл зориг, үүнд нь зөвшөөрч зээл олгосон зээлдэгч нарын хооронд байгуулсан “Цахим хэлбэртэй зээлийн гэрээ”-нд үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Шүүхийн шийдвэр 3.

ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр³¹

Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч “И ББСБ” ХХК нь хариуцагч М-тэй хэрэглээний зээлийн зориулалттай “Цахим зээлийн эрх нээх гэрээ”

³¹ Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 25 өдрийн 182/ШШ2021/00689 тоот шүүхийн шийдвэр.

байгуулсан. М-ийн цахимаар гаргасан хүсэлтийн дагуу зээлийн дансанд 68,000 төгрөгийн зээлийн олголтыг хийсэн. “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ээр Банк бус санхүүгийн байгууллагаас санал болгох зээлийн хугацаа нь 14 хоног, 30 хоног, 60 хоног болон бусад гэсэн сонголттой байх ба зээлдэгч зээл авах тухай бүрд зээлийн хугацааг өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сонгоно хэмээн заасан байдаг. Зээлдэгч М нь 68,000 төгрөгийн зээлийн хугацааг 60 хоног байхаар сонгож, зээлээр олгосон мөнгийг өөрийн цахим аппликейшний дансанд хүлээн авсан. “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ний онцлог нь зээлдэгч зээлийн гэрээний хүрээнд эргэн төлөлтийн хуваарийн дагуу үндсэн зээл болон үйлчилгээний төлбөр болох шимтгэлийг хугацаандаа төлсөн тохиолдолд зээлийн хүү төлдөггүй. Харин эргэн төлөлтийн хугацаандаа үндсэн зээл, шимтгэлийг төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоногоос эхлэн зээлийг ашигласны хариу төлбөр болох хүү, түүний 20 хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэг хүлээдэг. Улмаар нэхэмжлэгч үндсэн зээлийн үлдэгдэл 68,000 төгрөг, шимтгэл 9,766 төгрөг, үндсэн хүү 21,596 төгрөг, нэмэгдүүлсэн хүү 3,505 төгрөг, нэхэмжлэл гаргасантай холбогдон гарсан зардал 9,500 төгрөг; нийт 112,367 төгрөгийг хариуцагчаас нэхэмжилжээ.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Шүүгч шийдвэрийнхээ үндэслэлийг “Нэхэмжлэгч дээрх “Цхим зээлийн гэрээ”-ээр зээлдэгч зээлдсэн мөнгөө шимтгэлийн хамт хугацаандаа төлбөл хүү тооцогдохгүй, хугацаандаа төлөөгүй тохиолдолд хүү, нэмэгдүүлсэн хүү тооцогдож буйг тайлбарлаж байх боловч энэ талаарх баримтыг шүүхэд ирүүлээгүй байна. М-ийн “И ББСБ” ХХК-тай байгуулсан хэрэглээний зориулалттай “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ээр талууд ерөнхий нөхцөлийг тохирсон байх ба нарийвчилсан зохицуулалтыг заагаагүй байна” гээд хариуцагч М-ээс Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1, 453 дугаар зүйлийн 453.1-ийг баримтлан зээлийн 68,000 төгрөгийг, шимтгэл 9,766.31

төгрөгийн хамт гаргуулан нэхэмжлэгчид олгож, үлдэх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Дээрх шүүхийн шийдвэрээс үзвэл, талуудын хооронд байгуулсан зээлийн гэрээг шүүгч “Цахим зээлийн гэрээ” гэж дүгнээд, хэрэглээний зориулалттай “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ээр талууд ерөнхий нөхцөлийг тохирсон байх ба нарийвчилсан зохицуулалтыг заагаагүй гэж дүгнэжээ. Улмаар “Цахим зээлийн гэрээ”-ээр хүү, нэмэгдүүлсэн хүү авах талаарх баримтаа гаргаж өгөөгүй тул хүү шаардах эрхгүй гэж үзэн шийдвэрлэжээ. Үүнээс үзвэл шүүх мөн л бичгээр байгуулсан “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-г үнэлж дүгнэсэн байх ба цахимаар хүсэл зоригоо илэрхийлэн байгуулсан “Цахим зээлийн гэрээ”-ний хүчин төгөлдөр байдалд үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

2.3. ШҮҮХЭЭС ЦАХИМ ХЭЛЦЛИЙГ НОТЛОХ БАРИМТАД ТООЦОХ, ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ БАЙДАЛ

Цахим гэрээ, хэлцлийг шүүх хэрхэн нотлох баримтаар үнэлэх асуудал мөн тодорхойгүй байна. Тухайлбал, шүүх “Нэхэмжлэгч “Т” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.О нь *“хэргийн 1 дүгээр хавтасны 142-151 дэх тал, 203-212 дахь талд авагдсан хадгаламж барьцаалсан зээлийн мэдээлэл нь хариуцагчтай байгуулсан зээлийн гэрээ юм”* гэсэн тайлбар гаргаж байх боловч уг баримт нь хуулбар эсвэл эх хувь эсэх нь мэдэгдэхгүй, баримтыг нотариатаар гэрчлүүлээгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй байх тул уг баримтыг шүүх үнэлээгүй, шүүхийн шийдвэрийн үндэслэл болоогүйг дурдах нь зүйтэй байна”³² зэргээр цахимаар байгуулсан гэрээ, түүнтэй

³² Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатын шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн, 261 тоот шийдвэр. Үндэслэх хэсэг.

холбоотой нотлох баримтыг шүүгч хэрхэн үнэлж дүгнэх, мөн хэрхэн нотлох баримтын шаардлага хангуулан шүүхэд өгөх асуудал сорилт болж байна.

ИХШХШТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-т “Хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ” гэж заасан бөгөөд цахим хэлбэртэй баримтыг шүүх үзлэг хийж нотлох баримтаар бэхжүүлж байсан. Үзлэг хийх ажиллагаа нь нарийн ажиллагаа шаардахын зэрэгцээ нэлээн хугацаа зарцуулах тул шүүхэд болон талуудад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэдгийг үгүйсгэхгүй. Иймд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр ИХШХШТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.2-т “цахим баримт”-ыг нотолгооны хэрэгсэлд тооцох нэмэлтийг хуульд оруулж өгснөөр цахим хэлцэл, гэрээний ач холбогдлыг илүү нэмэгдүүлж өгсөн байна.

Түүнчлэн Иргэний хуулийн 42¹ дугаар зүйлийн 42^{1.1}-т “Хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно” гэж 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр ИХ-д өөрчлөлт оруулсан. Ингэснээр ИХ-д заасан аман, бичгэн, нотариатаар гэрчлүүлэх, бүртгүүлэх зэрэг бүх төрлийн хэлцлийг цахимаар хийх боломжтой болсон. Гэвч хууль хэрэгжээд, 3 жил өнгөрсөн байгаа ч өнөөдрийг хүртэл нотариатч цахимаар хийсэн гэрээ, хэлцлийг хэрхэн гэрчлэх, нотариатын үйл ажиллагааг цахимаар явуулах талаар эрх зүйн зохицуулалт Нотариатын тухай хуульд тусгагдаагүй байсаар байна.

Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2011 онд батлагдаж, 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд уг хуулийн 25¹ дүгээр зүйлд Цахим үйл ажиллагаа

эрхлэх талаар зохицуулалтыг оруулж өгсөн. Хуульд заасан “Цахим үйл ажиллагаа эрхлэх” гэдэг нь нотариатын үйл ажиллагаатай холбогдох бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлэх, нотариатч нь гэрчилсэн үйлдэл бүрээ цахимаар бүртгэлжүүлэх, мэдээлэл үүсгэх, цахим мэдээллийн санд байршуулах ажиллагааг хэлнэ гэснээс үзвэл цахим гэрээ, хэлцлийг хэрхэн гэрчлэх, цахимаар нотариатын үйлчилгээ үзүүлэх агуулга бүхий зохицуулалт биш юм.

Эцэст нь дурдахад, өмнө авч үзсэн шүүхийн шийдвэр 1, 2, 3-аас үзвэл шүүх бичгээр байгуулсан “Цахим зээлийн эрх нээх гэрээ” болон уг гэрээнд үндэслэн байгуулж буй “Цахим зээлийн гэрээ”-г ялгаж дүгнэхгүй байгаа тул цахим хэлцлийг нотлох баримтад хэрхэн тооцож, үнэлж дүгнэж буй талаар дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

2.4. ИХШХШТХ-ИЙН 72 ДУГААР ЗҮЙЛИЙГ ЯЛГААТАЙ ХЭРЭГЛЭЖ БУЙ БАЙДАЛ.

Зээлдэгчийн зүгээс ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.2-т заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор эсвэл шүүгчийн тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсвэл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй. Гэтэл энэ үүргээ биелүүлээгүй байхад шүүх хэрэгт цугларсан нотлох баримтын хэмжээнд дүгнэлт хийн хэргийг шийдвэрлэж буй тохиолдол байхад, зарим шүүх ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасны дагуу хариу тайлбар өгөх үүргээ биелүүлээгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцож нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн ханган хэргийг шийдвэрлэж байгаа хууль хэрэглээний зөрүүтэй тохиолдлууд ч байна.

Шүүхийн шийдвэр 4.

БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр³³

Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч “И ББСБ” ХХК шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “Зээлдэгч А нь манай компанитай хэрэглээний зориулалттай “Цахим зээлийн эрх нээх гэрээ” байгуулсан. Гэрээ байгуулагдсанаар зээлдүцлэгч нь “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ний 1.3.2 дахь хэсэгт заасан “Цахим зээл” буюу зээлдэгчийн ББСБ-д илгээсэн зээлийн хүсэлтийг үндэслэн, гар утасны аппликейшнээр дамжуулан зээлдэгчийн зээлийн дансанд 92,000 төгрөгийн зээл олголтыг хийсэн. Зээлдэгч нь үндсэн зээл, шимтгэлийг хугацаандаа төлж барагдуулаагүй тул үндсэн зээл 92,000 төгрөг, шимтгэл 12,900 төгрөг, үндсэн хүү 29,429.92 төгрөг, нэмэгдүүлсэн хүү 4,785.01 төгрөг, шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбоотой зардал 9,500 төгрөг; нийт 148,614.93 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэжээ.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т зааснаар хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож, А-аас 147,114.93 төгрөгийг гаргуулж шийдвэрлэсэн.

Дүн шинжилгээ:

Дээрх шүүхийн шийдвэрээр шүүгч ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасны дагуу хариуцагч талаас хуульд заасан хугацааны дотор нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, татгалзах эсэх талаарх тайлбар, нотлох баримтаа гаргаж өгөөгүй тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөнд тооцож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

³³ Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн, дугаар 101/ШШ2021/01143 тоот шийдвэр.

Харин Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулан, эрх үүргийг тайлбарлан өгсөн боловч хариу тайлбар, хэрэгт холбоотой нотлох баримт ирүүлээгүй. Гэсэн хэдий ч шүүгч хавтаст хэрэгт бүрдүүлсэн нотлох баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэр 5.

БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр³⁴

Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “Хариуцагч Э нь 2019.01.24-ний өдөр манай цахим зээлийн үйлчилгээнд “Цахим зээлийн эрх нээх гэрээ” байгуулж, 70,000 төгрөгийг 30 хоногийн хугацаатай, 6,500 төгрөгийн шимтгэлтэй, хугацаа хэтэрсэн тохиолдолд сарын 4 хувийн хүцтэй тохиролцож зээлсэн. “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ний 4 дүгээр зүйлийн 2.2-т “Зээл тус бүрийн эргэн төлөх хугацаанд тухайн ашигласан зээлийн дүнг, түүнд ноогдох шимтгэлийн хамт үл маргах журмаар төлөх”, 4 дүгээр зүйлийн 2.3-т “Зээл, зээлийн шимтгэлийг тухайн зээлийн эргэн төлөх хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд хүч төлөх” гэж заасан. Гэтэл зээлдэгч нь зээлээ гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй тул Хариуцагчаас үндсэн зээлийн үлдэгдэл 70,000 төгрөг, шимтгэл 6,500 төгрөг, хүцүгийн үлдэгдэл 24,301 төгрөг буюу нийт 100,801 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэжээ.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Шүүх шийдвэртээ “Нэхэмжлэгч нь хариуцагчид 70,000 төгрөгийг 30 хоногийн хугацаатай зээлж, зээлийн гэрээг бай-

³⁴ Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 02 өдрийн, дугаар 02432 тоот шийдвэр.

гуулсан байх бөгөөд зээлийн гэрээний хугацаанд тухайн ашигласан зээлийн дүнг, түүнд ногдох шимтгэлийг төлөх, хугацаа хэтэрсэн тохиолдолд сарын 4 хувийн хүү төлөхөөр тохиролцжээ. Энэхүү гэрээ нь ИХ-ийн 189 дүгээр зүйлийн 189.1-д “гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй” гэж заасан зарчимд нийцсэн, талууд хүсэл зоригоо илэрхийлэн, гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болжээ.

Гэрээний нөхцөл, агуулгаас дүгнэхэд нэхэмжлэгч нь Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрлийн хүрээнд зээлийг олгосон атлаа БЭБЭМХТТЗҮАТХ-ийн 22 (Зээлийн гэрээ) болон 24 дүгээр (Зээлийн хүү) зүйлд заасныг зөрчсөн байна.

Хэрэгт авагдсан гэрээгээр шимтгэл төлөхөөр тохиролцсон боловч хэдэн хувийн шимтгэлийг тооцох талаарх баримтыг ирүүлээгүй байх тул хангах үндэслэлгүй байна. Түүнчлэн 30 хоногт 4 хувийн хүү тохиролцсон, Хариуцагч нь үндсэн зээл 70,000 төгрөгийг төлөх үүргээ биелүүлээгүй байх тул 2,800 төгрөгийн хүүгийн төлбөрийг хариуцагчаас гаргуулан нэхэмжлэгчид олголоо. Харин талууд гэрээний хугацааг сунгасан гэдэг нь тогтоогдоогүй байх тул 21,501 төгрөгийг хүүгийн төлбөрт шаардах эрхгүй юм” гэжээ.

Дүн шинжилгээ:

Дээрх шүүхийн шийдвэрээр хариуцагч талаас хариу тайлбар, нэхэмжлэлийн шаардлагын татгалзал түүнтэй холбоотой нотлох баримтаа гаргаж өгөөгүй ч шүүгч хэрэгт цугларсан нотлох баримтын хэмжээнд хэргийг дүгнэн шийдвэрлэсэн нь хариуцагч талд ашигтай нөхцөл байдлыг бүрдүүлжээ.

Шүүгчийн дүгнэлтээс үзвэл “Цахим зээлийн гэрээ” болон “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-г ялгаж салгалгүй нэг гэрээ мэтээр дүгнэсэн байна.

2.5. ЕРӨНХИЙ ХУУЛЬ БА НАРИЙВЧИЛСАН ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ нарийвчилсан хууль буюу БЭБЭМХТТЗҮАтХ-ийг хэрэглэлгүй ИХ буюу ерөнхий хуулийг хэрэглэж шийдвэр гаргаж байна. Тухайлбал,

Шүүхийн шийдвэр 6.

СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр³⁵

Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч “Ц” ХХК-ийн шүүхэд гаргасан нэхэмжлэлд “Зээлдэгч О нь манай байгууллагатай “Цахим зээлийн эрх нээх гэрээ” байгуулж, 230,000 төгрөгийг 45 хоногийн хугацаатай, 15,615 төгрөгийн шимтгэл төлөх, мөн хугацаа хэтэрсэн тохиолдолд 1 сарын 4 хувийн хүч төлөх нөхцөлөөр зээлдэж авсан. Бидний хооронд байгуулсан зээлийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2.2-т: Зээл тус бүрийн эргэн төлөх хугацаанд тухайн ашигласан зээлийн дүнг, түүнд ногдох шимтгэлийн хамт үл маргах журмаар төлөх, 4 дүгээр зүйлийн 4.2.3-т: Зээл, зээлийн шимтгэлийг тухайн зээлийн эргэн төлөх хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд хүч төлөх гэж заасан. Манай байгууллагын зүгээс гэрээний 5.1.5-д зааснаар зээл болон зээлийн шимтгэлийг эргэн төлөх хугацаанд төлөөгүй тохиолдолд хүч тооцож эхлэх эрхтэй бөгөөд эдгээр төлбөрийг нэхэмжлэх эрхтэй гэж заасан. Зээлдэгч О нь өнөөдрийг хүртэл зээл, зээлийн хүч, шимтгэлийг төлөөгүй тул зээлийн төлбөрт 230,000 төгрөг, шимтгэлийн төлбөрт 15,615 төгрөг, хүцгийн төлбөрт 47,183 төгрөг буюу нийт 292,798 төгрөгийг гаргуулж өгнө үү.” гэжээ.

³⁵ Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн дугаар 184/ШШ2020/00608 шийдвэр.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Шүүх шийдвэртээ “Хариуцагч О нь нэхэмжлэгч “Ц” ХХК-тай байгуулсан “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ний дагуу, мөн өдөртөө 230,000 төгрөгийг 45 хоногийн хугацаатай, шимтгэл болон хүч төлөх нөхцөлтэй зээлж авсан болох нь нэхэмжлэгчийн тайлбар, хэрэгт цугларсан бичмэл нотлох баримтаар тогтоогдож байна. Нэхэмжлэгч нь зээлийн шимтгэл гэх агуулгаар 15,615 төгрөгийн нэхэмжилж байх боловч энэ нь Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.1 дэх хэсэгт заасан зээлийн хариу төлбөр болох хүчгийн төлбөр гэж үзэхээр байна. Иймд хариуцагч нь зээлийн хариу төлбөр болох 15,615 төгрөгийн хүчгийн төлбөрийг Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1-д зааснаар зээлдүцлэгчид төлөх үүрэгтэй юм.

Мөн нэхэмжлэгч нь хэтрүүлсэн хугацааны хүч гэх агуулгаар 47,183 төгрөгийг хариуцагчаас нэхэмжилжээ. Талуудын хооронд байгуулсан гэрээнээс үзвэл, нэхэмжилж буй хэтрүүлсэн хугацааны хүч нь Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.1-д заасан нэмэгдүүлсэн хүчгийн төлбөр бус, мөн хуулийн 452 дугаар зүйлийн 452.1-д заасан ердийн хүчгийн төлбөр гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, талууд “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-г байгуулж мөнгө зээлэхдээ гэрээний хугацаанаас хамаарч, 2 өөр төрлийн хүч тооцохоор харилцан тохиролцсон гэж үзэхээр байна. Тухайлбал, талууд уг гэрээгээр, зээл авснаас хойш 45 хоногийн хугацаанд 15,615 төгрөгийн хүч төлөх, 45 хоногоос хойш үндсэн зээлийн төлбөр болох 230,000 төгрөгөөс 4 хувийн хүч тооцож төлөх талаар тус тус тохиролцжээ.

Иймд нэхэмжлэгч нь “Цахим зээлийн эрх нээх гэрээ”-ний дагуу үндсэн зээлийн төлбөрт 230,000 төгрөг, гэрээний 2.1.7-д заасан хүчгийн төлбөрт 15,615 төгрөг, гэрээний 2.1.6.2-т заасан хүчгийн төлбөрт 47,183 төгрөгийг тус тус хариуцагчаас нэхэмжлэх эрхтэй” гэж шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэр 7.

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх³⁶

Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч “Ц ББСБ” нэхэмжлэлдээ “зээлдэгч манай банк бус санхүүгийн байгууллагатай “Цахим зээлийн эрх нээх гэрээ” байгуулж, 380,000 төгрөгийг 45 хоногийн хугацаатай, 42,700 төгрөгийн шимтгэлтэй, хугацаа хэтэрсэн тохиолдолд сарын 4 хувийн хүч төлөхөөр тохиролцож зээлсэн. Бидний хооронд байгуулсан “Зээлийн эрх нээх гэрээ”-ний 4.2.2 дахь хэсэгт Зээл тус бүрийн эргэн төлөх хугацаанд тухайн ашигласан зээлийн дүнг, түүнд ногдох шимтгэлийн хамт үл маргах журмаар төлөх, 4.2.3 дахь хэсэгт Зээл, зээлийн шимтгэлийг тухайн зээлийн эргэн төлөх хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд хүч төлөх гэж заасан. Мөн Банк бус санхүүгийн байгууллага нь зээлийн эрх нээх гэрээний 5 дугаар зүйлийн 5.1.5 дэх хэсэгт зааснаар Зээл болон зээлийн шимтгэлийг эргэн төлөх хугацаанд төлөөгүй тохиолдолд хүч тооцож эхлэх бөгөөд эдгээр төлбөрийг нийтэд нь төлүүлэх эрхтэй гэж заасан. Гэтэл зээлдэгч Ц нь зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, авсан зээл, зээлийн хүч, шимтгэлийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй. Иймд үндсэн зээлийн үлдэгдэл 380,000 төгрөг, шимтгэлийн үлдэгдэл 42,700, хүчгийн үлдэгдэл 162,702 төгрөг буюу нийт 585,402 төгрөг гаргуулж өгнө үү” гэжээ.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Шүүх хариуцагч “Ц” нь “Ц ББСБ” ХХК-ийн нэхэмжилсэн 585,402 төгрөгийг төлөхийг зөвшөөрч, шүүхээс хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, Ц-д холбогдох иргэний хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

³⁶ Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 01 дүгээр сарын 31 өдрийн дугаар 181/ШШ2020/00344 шийдвэр.

Дүн шинжилгээ:

Дээрх шүүхийн шийдвэрүүдээс үзвэл шүүгч мөн л “Цахим зээлийн эрх нээх гэрээ” болон “Цахим зээлийн гэрээ”-ний харилцааг ялгаж, дүгнэлт хийгээгүй. Шүүгч ерөнхий ба тусгай гэрээний харилцааг бичгээр байгуулагдсан нэг зээлийн гэрээ гэж дүгнэсэн байна. Түүнчлэн ББСБ-аас зээлийн үнийн дүнгээс хамаарч тооцох шимтгэлийг зээлийн хүү гэж, ББСБ-аас тооцсон нэмэгдүүлсэн хүүг ердийн хүү гэж дүгнэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж хэргийг шийдвэрлэжээ.

Мөн шүүгч хэргийг шийдвэрлэхдээ ИХ-ийн 451, 452, 453 дугаар зүйлийг үндэслэн шийдвэрлэсэн. ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.3-т “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна” гэж заасны дагуу нарийвчилсан хууль болох “БЭБЭМХТТЗҮАтХ-ийг батлан гаргасан байдаг. Үүнээс дүгнэж үзвэл, ИХ-ийн зохицуулалт нь ерөнхий зохицуулалт болох ба тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хууль байсаар байтал шүүх хэрэглэхгүй байгаа нь хэрэглэх ёстой хуулийг хэрэглэхгүй байх, цаашлаад шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдалд хүртэл нөлөөлөх хууль хэрэглээний эрэмбийн асуудлыг хөндөж байна. Ер нь судалгааны багийн зүгээс дүн шинжилгээ хийсэн бүх шүүхийн шийдвэрт дан ганц ерөнхий хууль болох ИХ-ийг үндэслэн, шүүх шийдвэрээ гаргасан нь анхаарал татаж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар цахим хэлцэлтэй холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхээс гадна цахим хэлцлийн хүрээнд хэрэглэгчийн эрхийг хэрхэн хамгаалах талаарх Япон улсын туршлагыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулж, манай улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал ба цаашид шинэ тутам үүсэж болзошгүй асуудлыг тодорхойлохыг зорилоо.

Манай улсын хувьд цахим хэлцэл байгуулахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор ИХ-д нэмэлт өөрчлөлт оруулах, банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч эрх бүхий этгээд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авч байгаа ч тэр нь хангалтгүй байна.

Тиймээс судалгааны дүгнэлт, саналыг манай улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсэж буй асуудал ба шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ гэсэн 2 хэсэгт тусад нь танилцуулъя.

1. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд

А. Цахим хэлцэл бие даасан хэлцлийн төрөл эсэх

2021 оны 5 дугаар сарын 21-нд ИХ-ийн өөрчлөлтөөр цахим хэлцэл нь зөвхөн Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс авсан тоон гарын үсгээр баталгаажуулж хүчинтэй болох бус техник хэрэгсэл, программ

хангамж ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, тоон гарын үсгээс бусад хэлбэрээр цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох боломжтой болсон.

Гэвч ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4-т “*цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурсан*” бол хэлцэл хийсэн гэж үзэх тухай зохицуулалтыг өөрчлөөгүй хэвээр үлдээжээ.

Үүнээс дүгнэн үзвэл, цахим хэлцэл нь бие даасан хэлцэл үү, эсвэл бичгэн хэлцлийг цахим хэлбэрт оруулсан бичгэн хэлцлийн нэг төрөл үү гэдэг асуудлыг тодруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4-ийг задлан үзвэл, ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2 буюу ерөнхий зохицуулалт нь хэлцлийг бичгээр хийсэнд тооцох тухай зохицуулалт юм. Тодруулбал, 43 дугаар зүйлийн 43.2.4 нь ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2-т хамаарах тул цахим хэлбэрээр хийх хэлцэлд тоон гарын үсэг зурснаар бичгээр хэлцэл хийсэнд тооцно гэж ойлгогдож байна.

Одоогоор тус асуудлыг тодорхойлсон шүүхийн маргаан гараагүй байгаа ч жишээлбэл, талууд цахим хэлбэрээр хэлцэл хийж тоон гарын үсэг бус бусад цахим арга хэрэгслээр цахим гарын үсэг зурж баталгаажуулсан гэрээг ИХ-ийн 42¹.2, 196 дугаар зүйлийн 196.1.8-д заасны дагуу цахим гэрээ байгуулагдсан гэж үзэх үү, эсвэл ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4-т заасны дагуу тоон гарын үсгээр баталгаажаагүй тул хэлцэл хийгдээгүй гэж үзэх эсэх асуудал үүсэхийг үгүйсгэхгүй.

Онолын хувьд цахим хэлцлийг бие даасан хэлцэл үү эсвэл бичгэн хэлцлийн тусгай төрөл үү гэдэг талаар нэгдсэн байр суурь үгүй ч судалгааны багийн хувьд ИХ-ийн зохицуулалт болон цахим хэлцлийн онцлогийг харгалзан үзвэл бичгэн хэлцлийн тусгай төрөл гэж үзэх нь оновчтой гэж дүгнэж байна. Учир

нь өмнөх хэсэгт дурдсанчлан бичгэн хэлцэл гэдэгт зөвхөн цаасан дээр хэвлэсэн гэж үзэх нь хэт явцуурсан тайлбар болох бөгөөд харин цахим гэдэг нь бичгэн хэлбэрийг цахим арга хэрэгслийг ашиглан цахим хэлбэрт оруулсан, түүнийг нотлох тодорхой баримт үлддэг бичгэн хэлцлийн нэг төрөл юм. Түүнчлэн цахим хэлцлийг бичгэн хэлцлийн тусгай төрөл гэж үзсэнээр бичгэн хэлцэлд тавигдах ерөнхий шаардлага үйлчлэх үндэслэл болох хэдий ч тусгай төрөл болохын хувьд түүнийг баталгаажуулах арга хэрэгсэл, хэрэглэгчтэй байгуулах гэрээний хувьд харгалзан үзэх онцлогийг ялгамжтай зохицуулах нь зохистой.

Б. Цахим гарын үсгийг тодорхойлох

2021 оны ИХ-ийн өөрчлөлтөөр цахим хэлцэл байгуулахад зөвхөн тоон гарын үсгээр баталгааждаг байх тухай шаардлагыг зөөлрүүлж, тоон гарын үсгээс бусад төрлийн цахим гарын үсгээр цахим хэлцэл байгуулж болохоор заасан. Өөрөөр хэлбэл, тоон гарын үсгээс өөр төрлийн цахим гарын үсэг гэдэгт ямар төрлийн гарын үсгийг хамааруулах вэ? гэдгийг тодруулах шаардлагатай юм. Тодруулбал, Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1”-д “цахим гарын үсэг” гэж “цахим баримтад гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зорилготой цахим баримт бичигт хавсаргасан буюу нэгтгэсэн үг, үсэгм баримтад гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зо” хэмээн тодорхойлсон нь цахим хэлцэл байгуулагч этгээд өөрийг нь тодорхойлж болохуйц ямар ч хэлбэрээр цахим гарын үсэг ашиглах боломжтой юу эсвэл тухайн цахим гарын үсэг гэдэг нь тоон гарын үсэгтэй адил шинж бүхий зөвхөн цахим гарын үсэг ашиглагч л ашиглах боломжтой, тухайн этгээдийг таньж мэдэх боломжтой баталгаатай зүйл байх уу гэдэг нь хуульд тодорхойгүй байна.

Тухайлбал, хэлцэл байгуулагч тал цаасан дээр гарын үсгээ

зураад, скайнердаад цахим шуудангаар илгээх, эсвэл илгээж буй гэрээ байгуулах санал, хүлээн зөвшөөрөх саналын доор өөрийн нэр, регистрийн дугаарыг хавсаргасан байхад хангалттай юу гэдгийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Учир нь цахим хэлцлийн онцлог нь талууд бие биетэйгээ уулзахгүй, танихгүй байсан ч цахим сүлжээг ашиглан хэлцэл, гэрээ байгуулах боломжтой тул хэлцэл хийгчийн өмнөөс төлөөлөх эрхгүй этгээд хэлцэл хийх, гэрээг хуурамчаар үйлдэх зэрэг эрсдэл гарч болзошгүйтэй. Харин манай улсын хувьд тоон гарын үсэг бус өөр төрлийн цахим гарын үсэг ашиглаж цахим хэлцэл хийхээр хуульчилсан нь цахим хэлцлийг хялбар аргаар хийх сайн талтай ч хэлцэл хийгч талыг жинхэнэ этгээд мөн эсэхийг баталгаажуулахад цаашид асуудал үүсэж болзошгүй гэж үзэж байна.

Энэ хүрээнд цахим хэлцэлд түгээмэл ашиглагдах болсон гуравдагч этгээдээр баталгаажуулах (*third-party authentication*) боломжийг нарийвчлан судлан үзэх нь зүйтэй.

В. Цахим хэрэглэгчийн гэрээний тусгай зохицуулалт

Цахим худалдааны хөгжлийг даган цахим хэрэглэгч гэдэг ойлголт бий болсон бөгөөд энэ нь цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэгч бизнес эрхлэгчээс цахим системийг ашиглан санал болгож буй бараа, үйлчилгээг өөрийн хэрэглээнд зориулан авч буй хувь этгээд юм. Тиймээс цахим хэлцлийн хувьд ч цахим хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалт бүхий цахим хэрэглэгчийн гэрээ нь хууль зүйн ойлголт болон тогтсон байна.

Өөрөөр хэлбэл, цахим хэлбэрээр гэрээ хийж буй хэрэглэгч нь аман болон бичгэн хэлбэрээр гэрээ хийхтэй харьцуулахад алдаа гаргах магадлал их байдаг. Үүнийг хууль зүйн үүднээс дүгнэвэл, хэрэглэгчийн гаргасан санал нь өөрийн бодит хүсэл

зоригоос зөрүүтэй байсан гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус хэлцэл болох ба тухайн хэрэглэгч ямар нэгэн хайхрамжгүй, болгоомжгүй үйлдэл гаргаагүй байх, хэрэв хайхрамжгүй үйлдэл гаргасан тохиолдолд хэлцлийн нөгөө талд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй болно.

Учир нь манай ИХ-д ноцтой төөрөгдсөн гэдэг үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тохиолдолд тухайн төөрөгдсөн этгээд нь аж ахуй эрхлэгч үү, эсвэл хэрэглэгч байсан уу гэдэг субъектийн хувьд ялгаж авч үздэггүй.

Тиймээс цахим хэрэглэгчийн гэрээнд талуудын диспозитив зарчмын үүднээс ИХ дахь ноцтой төөрөгдлийн улмаас хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах ерөнхий зохицуулалтаас ялгамжтай буюу хэрэглэгч төөрөгдсөн байсан ч хэлцлийг хүчин төгөлдөр бус болгоход гэм буруу шаардахгүй, хохирол нөхөн төлөх үүрэг хүлээлгэхгүй тусгай зохицуулалт шаардлагатай. Мөн цахимаар үйлчилгээ үзүүлэгч аж ахуй эрхлэгч нь заавал хүсэл зоригийн илэрхийлэл үнэн зөв байгаа эсэх, гэрээний агуулгатай нийцэж байгаа эсэхийг хэрэглэгч дахин шалгах шаардлагатай технологийн арга хэмжээ авах үүрэгтэй байх эрх зүйн зохицуулах шаардлагатай гэж дүгнэж байна.

2. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний хүрээнд

Шүүхээр шийдвэрлэгдэж буй цахим хэлцэлтэй холбоотой маргаанд банк, банк бус санхүүгийн байгууллагаас цахимаар олгож буй зээлийн гэрээ зонхилж байна. Эдгээрийг дүгнэвэл:

1. Шүүх банк, банк бус санхүүгийн байгууллага болон хэрэглэгчийн хооронд байгуулж буй гэрээний харилцааг зөв тодорхойлохгүй байна. Банк санхүүгийн байгууллагаас хэрэглэгчтэй цаасан дээр хэвлэмэл бичгэн гэрээг байгуулж, уг гэрээндээ цахим үйлчилгээтэй холбоотой

ерөнхий нөхцөлийг тусгаж, цахимаар үйлчилгээ авах эрхийг олгож, ерөнхий гэрээг байгуулж байна. Энэхүү ерөнхий гэрээгээр талуудад зээлийн харилцаа үүсэхгүй юм. Харин хэрэглэгч цахимаар үйлчилгээ авах эрхтэй болсноор, цахимаар зээлийн хүсэлт явуулж, зээлдэгчийн зүгээс хүсэлтийг хүлээн авч зээлийн гэрээний хүү, шимтгэл, нэмэгдүүлсэн хүү, гэрээний дуусах хугацаа зэргийг тусгасан зээлийн гэрээг цахим хэлбэрээр байгуулж байна. Гэтэл шүүх дээрх харилцааг ялгаж салгаж дүгнэхгүй байна. Хэрэв шүүх ялгаатай байдлаар дүгнэсэн бол цахимаар байгуулсан зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдал яригдах бөгөөд зээлдүүлэгч тал хүү шаардах эрхээ алдах нөхцөл байдал үүсэхээр байв.

2. Дээр дурдсанчлан банк, банк бус санхүүгийн байгууллага болон хэрэглэгчийн хооронд хоёр төрлийн гэрээний харилцаа үүсэж, “Цахим зээлийн эрх олгох гэрээ” зэргээр нэрлэсэн ерөнхий гэрээг цаасаар буюу бичгээр байгуулж байгаа бол “Зээлийн гэрээ”-г цахимаар байгуулж байна. Гэтэл ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.2-т *“хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээг бичгээр хийнэ”* гэж заасан. Энд *“хууль өөрөөр заагаагүй бол”* гэдэг тодотголтой тул хуульд өөрөөр заасан эсэхийг шалгах шаардлагатай. ИХ-ийн 42¹ дүгээр зүйлийн 42^{1.1}-т *“Хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчилгээлбэл зохих хэлцлээс бусад хуульд бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно”* гэж зааснаар зээлийн гэрээг цахимаар хийж болохоор байна. Гэтэл ИХ-ийн 42¹ дүгээр зүйлийн 42^{1.2}-т *“Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно”* гэж, мөн хуулийн 196.1.8-т *“цахим*

хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар” гэрээ байгуулсанд тооцох зохицуулалттай байсан. Гэтэл шинжилж дүгнэсэн шүүхийн шийдвэрүүдэд нэг ч тоон гарын үсэг ашигласан тохиолдол байхгүй. Өөрөөр хэлбэл, цахимаар зээлийн гэрээг байгуулах бол заавал тоон гарын үсгээр баталгаажуулсан байх хуулийн шаардлагыг зөрчиж хийсэн хүчин төгөлдөр бус хэлцэл болж байна. Шүүх дээрх байдлаар цахим хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг шинжилж дүгнэхгүйгээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэж байгаа нь шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх шаардлагад нийцэхгүй байна.

3. Шүүх нарийвчилсан хуулийн зохицуулалтыг бус ерөнхий хуулийн зохицуулалтыг хэрэглэж шийдвэрээ гаргаж байна. ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.3-т “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна” гээд банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг нарийвчилсан хуулиар зохицуулахаар БЭБЭМХТТЗҮА тухай хуулийг батлан гаргасан. Гэтэл шүүх хэргийг шийдвэрлэхдээ тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан тусгай хуулийн зүйл заалтыг хэрэглэхгүй ИХ-ийг барьж шийдвэрлэж байна. Энэ нь нарийвчлан зохицуулсан тусгай хууль нь ерөнхий хуулийн зохицуулалтаас давуу хүчинтэй байх эрх зүйн онолтой зөрчилдөх, цаашлаад хууль хэрэглээний буруу жишгийг тогтоох, хууль хэрэглээний алдаа гаргах нэг шалтгаан болох юм.
4. Шүүх ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3-т “Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн 72.2-т заасан үүргээ биелүцлээгүй, түүнчлэн энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд

ирж тайлбар өгөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож энэ хуулийн 100.3-т зааснаар түүний эзгүйд хэргийг шийдвэрлэнэ” гэсэн процессын хуулийн заалтыг өөр өөрөөр хэрэглэж байгааг нэг мөр болгох шаардлагатай. Ингэхдээ шүүхээс талуудын мэтгэлцэх зарчмыг хангах үүднээс дээрх заалтын *“нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож”* гэсэн үр дагавар заасан хэсгийг хуулиас хасах нь зүйтэй болов уу. Улмаар хариу тайлбар ирүүлэх үүргээ биелүүлээгүй бол хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэрлэдэг байх нь зүйтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

1. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын хууль, 2021.
2. Монгол Улсын Иргэний хууль, 2001.
3. Цахим гарын үсгийн тухай Монгол Улсын хууль, 2011.
4. Япон улсын Цахим гарын үсгийн тухай хууль, 2001 (電子署名法).
5. Япон улсын Хэрэглэгчийн цахим гэрээнд хамаарах Иргэний хуулийн тусгай журмын тухай хууль, 2001. (電子消費者契約に関する民法の特例に関する法律).

Ном, сурах бичиг, судалгааны тайлан

1. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2 дахь хэвлэл, УБ, 2014.
2. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2007.
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт”, 2011. https://nli.gov.mn/pdf/tsahim_hudaldaanii_olon_ulsiin.pdf
4. Монголбанк “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан

судлах үнэлгээний тайлан”, 2020.

5. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагыг конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл <http://forum.parliament.mn/projects/10900>
6. “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”, 2020.
7. “Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, 2021, 2 дахь тал.
8. Япон улсын Эдийн засаг, аж үйлдвэрийн яам “Цахим хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн тайлбар”, 2001. 経済産業省 電子消費者契約及び電子承諾通知に関する民法の特例に関する法律逐条解説 https://www.meti.go.jp/policy/it_policy/ec/e11225bj.pdf

Цахим хуудас

1. <https://www.cloudsign.jp/media/20170125-basics-of-e-contract-01/> (Cloud sign нь GMO Globalsign компанийн хөгжүүлсэн Японы цахим гарын үсэг болон гэрээний үйлчилгээ юм.)
2. <https://www.nolo.com/legal-encyclopedia/electronic-signatures-online-contracts-29495.html>
3. <https://www.gmosign.com/media/electronic-contract/post-0025/> (GMO Globalsign компанийн хөгжүүлсэн Япон улсын цахим гарын үсэг болон гэрээний үйлчилгээ юм.)
4. <https://www.gmosign.com/media/electronic-contract/post-0023/>
5. <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=413AC00000000095> (Тус цахим хуудас нь Япон улсын хууль тогтоомжийг нийтэлдэг албан ёсны цахим хуудас юм.)

2

ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧ, ТӨЛӨӨЛӨГЧ, КОМИССЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



ГАНХУЯГИЙН ДАВААНЯМ

Хууль зүйн доктор МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн ахлах багш, Нагоягийн Их Сургуулийн харьяа Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн багш

Судлаач нь компани нөхөрлөлийн эрх зүй, арилжааны эрх зүй, компанийн санхүүгийн эрх зүй, үнэт цаасны эрх зүйн чиглэлээр хичээл зааж, судалгааны ажил эрхэлж байна. Бүтээлийн хувьд “Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага” монограф, “Компани арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд” өгүүллийн эмхэтгэл, “Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт” сурах бичгийг тус тус монгол хэлээр эрхлэн гаргасан.



ГАНТӨМӨРИЙН УЯНГА

“ХААН банк” ХХК-ийн ахлах хуулийн зөвлөх

Судалгааны багийн гишүүн Г.Уянга нь 2012 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйч мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд 2020 онд тус сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Иргэний эрх зүй, компанийн эрх зүй, үнэт цаас, банкны эрх зүйн чиглэлээр сонирхон судалдаг.

Судлаачид:

Г.Давааням (LL.D)

Г.Уянга (LL.M)

АГУУЛГА

УДИРТГАЛ	82
НЭГ. ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧ, ТӨЛӨӨЛӨГЧ, КОМИССЫН ГЭРЭЭ.....	85
1.1. Худалдааны зуучлагч.....	86
1.1.1 Төсөөтэй ойлголтоос ялгах.....	86
1.1.2 Худалдааны зуучлагчийн гэрээний зохицуулалт....	88
1.1.3 Худалдааны зуучлагчийн гэрээний төрөл.....	94
1.2. ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ.....	97
1.2.1 Төсөөтэй ойлголтоос ялгах	98
1.2.2 Худалдааны төлөөлөгчийн гэрээний зохицуулалт	102
1.2.3 Худалдааны төлөөлөгчийн гэрээний төрөл.....	111
1.3. КОМИСС.....	112
1.3.1 Төсөөтэй ойлголтоос ялгах	112
1.3.2. Комиссын гэрээний зохицуулалт	115
1.3.3. Комиссын гэрээний төрөл.....	124
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	127
2.1. ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧИЙН ГЭРЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	127

2.1.1 Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	127
2.1.2 Дүгнэлт.....	152
2.2. КОМИССЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН МАРГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	153
2.2.1. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	153
2.2.2 Дүгнэлт	161
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	164
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	168

УДИРТГАЛ

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш 30 гаруй жил өнгөрчээ. Энэ хугацаанд арилжааны харилцаа хурдацтай хөгжиж, түүний эрх зүйн зохицуулалт ба хэрэглээг тодорхой болгох шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Сүүлийн жилүүдэд арилжааны эрх зүйд бусад этгээдийн тусламжтай бараа бүтээгдэхүүнээ борлуулахад чиглэсэн арилжааны харилцаа чухлаар тавигдах болсон. Энэ хүрээнд арилжаа эрхлэгч бараа бүтээгдэхүүнээ зах зээлд түгээхдээ өргөн хүрээнд дилерийн, дистербьютерийн, франчайзын гэрээ зэрэг олон төрлийн гэрээг хэрэглэж байна.

Эдгээрээс өнөөгийн Монгол Улсын бизнесийн практикт Иргэний хууль (цаашид ИХ гэх) дахь худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний онолын үндсийг тодорхойлох, өөр хоорондын болон бусад төсөөтэй гэрээнээс ялгарах онцлогийг тодруулах, эрх зүйн зохицуулалтын шүүх дэх хэрэглээг нэг мөр болгох шаардлага тулгарч байна.

Энэ төрлийн гэрээ нь Монгол Улс төдийгүй эх газрын эрх зүйн бүлийн улсуудад нийтлэг байдлаар тааралдах бөгөөд 1897¹, 1900² оны Герман Улсын Арилжааны хуулиас рецепц хийх

¹ Allgemeines Deutsches Handelsgesetzbuch (ADHGB).

² Handelsgesetzbuch (HGB)

замаар Европын улсуудад дэлгэрсэн байдаг³. Азийн улсуудаас хамгийн түрүүнд Япон Улс 1988, 1980 оны Арилжааны хуульдаа Герман Улсын Арилжааны хуулиас рецепц хийсэн⁴.

Улмаар ИХ дахь худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний зохицуулалтын суурь үзэл санаа, ялгааг тодорхой болгох үүднээс Герман болон Япон улсын Арилжааны хуулийн зохицуулалт, холбогдох судалгааны ажил тулгуурлах замаар харьцуулан авч үзнэ.

Мөн Монгол Улсын шүүхийн практикт 1). тээвэрлэлт, илгээмжийн гэрээнд хамаарах маргааныг худалдааны зуучлагчийн гэрээ, 2). даалгаврын гэрээ эсвэл худалдааны төлөөлөгчийн гэрээний маргааныг комиссын гэрээнд тооцон шийдвэрлэсэн тохиолдлууд гарч байна.

Энэ хүрээнд худалдааны зуучлагчийн гэрээний хүрээнд www.new.shuukh.mn вэбсайтаас 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр “Иргэний хуулийн 413 дугаар зүйл” түлхүүр үгээр хайлт хийж, Улсын Дээд шүүх (цаашид УДШ гэх)-ийн 6 шийдвэр, мөн комиссын гэрээн хүрээнд Иргэний хуулийн 415 дугаар зүйл” түлхүүр үгээр хайлт хийж, УШД-ийн 2 шийдвэрт дүн шинжилгээ хийв.

Харин худалдааны төлөөлөгчийн гэрээний хүрээнд “ИХ-ийн 415.1.” гэсэн түлхүүр үгээр шүүлт хийхэд худалдааны төлөөлөгчийн гэрээний талаар гарсан маргаан байгаагүй тул уг гэрээний дүн шинжилгээ хэсгийг бүтцэд оруулаагүй олно. Энэ төрлийн гэрээний маргаан шүүхийн практикт үүсээгүй байгаа нь дараах шалтгаантай байж болох юм. Үүнд:

³ 1938 оны Герман Улсын түрэмгийлэлтэй холбоотойгоор Европын улсуудад нөлөөлсөн. Mathias m. Siems, The Divergence of Austrian and German Commercial Law: What Kind of Commercial Law Do We Need in a Globalised Economy?, OPINION: I.C.C.L.R. 273, 274 (2004) .

⁴ Kitai et al, Minpou to tsunagaru Shouhou, Shoukoui, 5 (Shoujihoumu, 2013).

1. Монгол Улсад хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, салбар төлөөлөгчийн газрын байгуулах нь хялбар болсон;
2. Арилжааны эрсдэлийг бусдад шилжүүлэх боломж гэрээний бусад хэлбэр болох дилерийн гэрээ, дистербьютерийн гэрээг түгээмэл хэрэглэх болсон;
3. Европын Улсуудад хөгжсөн худалдааны төлөөлөгчийн нэгэн адилаар тухайн бүс нутагт мэргэшсэн худалдааны төлөөлөгч Монгол Улсад хараахан бүрэлдэж тогтоогүй.

НЭГ. ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧ, ТӨЛӨӨЛӨГЧ, КОМИССЫН ГЭРЭЭ

Арилжаа эрхлэгч нь арилжааны үйл ажиллагаа явуулахдаа орон зай, цаг хугацаа, хөрөнгө мөнгөний хүчин зүйлээс шалтгаалан бусад этгээдийн тусламжийг авах зайлшгүй шаардлагатай тулгардаг. Энэхүү арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд туслах чиг үүрэгтэйгээр оролцдог этгээд нь олон төрөл, хэлбэрээр оршиж байх боловч хувийн эрх зүйн судлаачид нийтлэг байдлаар

- Худалдааны дотоод төлөөлөл
- Худалдааны гадаад төлөөлөл гэж хоёр ангилан авч үздэг.

Худалдааны дотоод төлөөлөл гэдэг нь арилжаа эрхлэгчийн зүгээс өөрийн бүтцийн нэгж буюу эрх бүхий албан тушаалтан, ажилтны тусламжтай үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.⁵ Харин худалдааны гадаад төлөөлөл гэдэг нь бие даасан арилжаа эрхлэгчтэй гэрээ байгуулах замаар тэдгээрээр дамжуулан арилжааны харилцаанд орохыг хэлбэрийг илэрхийлдэг. Энэхүү гадаад төлөөлөл нь худалдааны зуучлагч, төлөөлөгч, комиссын гэрээгээр илрэх бөгөөд арилжаа эрхлэгчээс тусдаа, бие даасан, мэргэшсэн арилжаа эрхлэгч байдгаараа онцлог юм.

⁵ Иргэний хуульд заасан итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөх, хуульд заасны дагуу төлөөлөх бүрэн эрх үүсэх тогтолцоо хамаарна. Б.Амарсанаа, Г.Давааням, Арилжааны эрх зүй, 2022, 126-127 дахь тал

1.1. ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧ

Худалдааны зуучлагчийн талаар авч үзэхийн өмнө түүнийг ердийн зуучлагч буюу иргэний зуучлагчаас ялгах шаардлага үүснэ. Тэдгээрийн ялгааг авч үзье.

1.1.1 Төсөөтэй ойлголтоос ялгах

Ердийн зуучлагчаас ялгах

Зуучлагч (англи: *broker*) гэж бусад этгээд хооронд гэрээ хэлцэлд зуучлах үйл ажиллагаа явуулдаг этгээдийг хэлнэ.⁶ Зуучлагч нь зуучлалын гэрээний үндсэн дээр зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйл ажиллагаа явуулж, гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал авна.⁷

Зуучлагчийг худалдааны зуучлагчаас ялгахын тулд ердийн (иргэний) зуучлагч хэмээн нэрлэж болно. Иргэний хууль (цаашид, ИХ)-ийн 410-412 дахь зүйлд 1) зуучлалын гэрээ, 2) зуучлах онцгой эрх, 3) зээлийн гэрээ байгуулахад зуучлах асуудлыг тусгайлан зохицуулсан байна. Ердийн зуучлагчийн сонгодог жишээ нь бусад улсад нийтлэг тохиолдох гэрлэлт зуучлалын үйл ажиллагаа юм. Мөн худалдааны зуучлалын үйл ажиллагаанд хамаарахаас бусад хэлцэлд зуучлах болон арилжааны шинжгүй үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэлцэлд зуучлах нь ердийн зуучлалын үйл ажиллагаанд хамаарна (ИХ-ийн 413.2). Тухайлбал, орон сууц хөлслөх хэрэгцээ бүхий иргэнээс бусад иргэний орон сууцыг хөлслөхөд зуучлах үйл ажиллагаа нь иргэний зуучлалын гэрээнд хамаарна.

⁶ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ, 2013, 265 дахь тал (Соёмбо., 3 дахь хэвлэл).

⁷ Мөн тэнд.

Эрх зүйн зохицуулалтын хэрэглээний хувьд худалдааны зуучлагчид тооцогдоогүй бол ердийн зуучлагч байх бөгөөд худалдааны зуучлагчид хамаарах эрх үүргийн талаарх тусгайлсан зохицуулалт үйлчлэхгүй. Өөрөөр хэлбэл, ердийн зуучлагч нь худалдааны зуучлагчийн нэгэн адилаар маргаанаас урьдчилан сэргийлэх үүрэг, үүргийн гүйцэтгэлийн хангах үүрэг хүлээхгүй тул гэрээний нөгөө талаас зуучлалын хөлс шаардах эрхгүй байх зэрэг зохицуулалтын хүрээнд ялгаатай байдаг.

Худалдааны төлөөлөгч, комиссоос ялгах

Худалдааны зуучлагчийг худалдааны төлөөлөгч, комиссоос ялгах нь эрх зүйн хувьд чухал ач холбогдолтой юм.

Худалдааны зуучлагчийн гэрээний тал нь тодорхой бус байдаг шинжээрээ худалдааны төлөөлөгчөөс ялгаатай. Мөн гэрээний эрх үүрэг нь худалдааны зуучлагчид үүсэхгүй байх шинжээрээ комиссоос ялгарна.

Харин гэрээний тал тодорхой бус байх шинжээрээ комисстой төстэй бол эрх үүрэг нь худалдааны зуучлагчид үүсэхгүй байх шинжээрээ худалдааны төлөөлөгчтэй адил агуулгыг илэрхийлж байдаг. Эдгээрийг харьцуулбал:

Хүснэгт 1. Худалдааны зуучлагч, төлөөлөгч, комиссын ялгаа

№	Гэрээний төрөл	Үйл ажиллагааны төрөл	Гэрээний тал	Өөрт эрх үүрэг үүсэх
1	Худалдааны зуучлагч	Зуучлах	Тодорхой бус	Үүсэхгүй
2	Худалдааны төлөөлөгч	Төлөөлөх, зуучлах	Тодорхой	Үүсэхгүй
3	Комисс	Зуучлах	Тодорхой бус	Үүснэ

1.1.2 Худалдааны зуучлагчийн гэрээний зохицуулалт

Худалдааны зуучлагч (герман: *Haldelsmakler*) гэж зуучлагч тодорхой төрлийн үйл ажиллагааг аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулж буй этгээдийг хэлнэ.⁸ ИХ-д зааснаар дараах үйл ажиллагааг аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд эрхлэх тохиолдолд худалдааны зуучлагчид тооцно (413.1). Үүнд:

- Худалдах-худалдан авах,
- Даатгал,
- Тээвэр,
- Эд хөрөнгө хөлслөх, эсвэл худалдааны бусад үйл ажиллагаа хамаарна

Худалдааны зуучлагч нь арилжаа эрхлэгч байх бөгөөд зуучлуулагч болон гэрээний нөгөө талын хооронд зуучлалын үйл ажиллагаа явуулах замаар ашиг олдог. Худалдааны зуучлагчийн хүрээнд зуучлуулагч нь тодорхойлох боломжгүй этгээд байдгаараа худалдааны төлөөлөгчийн гэрээнээс ялгарна.

Худалдааны зуучлагчийн гэрээний шинж

Эх газрын эрх зүйд зуучлагчийн дотроос бусад этгээд хоорондын арилжааны үйл ажиллагаанд зуучлахад чиглэсэн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг тусгайлан зохицуулдаг бөгөөд тухайн этгээдийг худалдааны зуучлагч хэмээн нэрлэнэ.⁹

Худалдааны зуучлагчийн гэрээг

- Хоёр талын зуучлагчийн гэрээ
- Нэг талын зуучлагчийн гэрээ гэж хоёр ангилдаг.

⁸ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ, 2013, 268 дахь тал (Соёмбо., 3 дахь хэвлэл)

⁹ Мөн тэнд,

Хоёр талын зуучлагчийн гэрээний хүрээнд зуучлагч нь зуучлуулагчийн төлөө гэрээ байгуулахад чиглэсэн бүхий л чармайлтыг гаргах үүрэг хүлээж, гэрээ байгуулагдсан тохиолдолд зуучлуулагч нь тохирсон хөлсийг төлөх үүрэг хүлээнэ.¹⁰ Улмаар хоёр талын зуучлалын харилцаа нь даалгаврын гэрээнд хамаарна.¹¹

Харин нэг талын зуучлалын гэрээний хүрээнд зуучлагч нь зуучлуулагчийн төлөө гэрээ байгуулахад чиглэсэн бүхий л чармайлтыг гаргах үүргийг хүлээхгүй бөгөөд гэрээ байгуулагдсан тохиолдолд зуучлуулагч нь тохирсон хөлсийг төлөх үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл, гэрээ байгуулахад чиглэсэн бүхий л чармайлтыг гаргах үүргийг зуучлагчид хүлээлгэх эсэх нь зуучлуулагчийн эрх чөлөөний асуудал бөгөөд зуучлагч өөрийн хүчин чармайлтын үндсэн дээр дангаар гэрээ байгуулах боломжгүй байдаг. Улмаар энэ төрлийн гэрээний харилцаанд ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалтыг ашиглах боломжтой юм.¹²

Худалдааны зуучлагчийн эрх

Худалдааны зуучлагчийн эрхийн хүрээнд зуучлалын үйл ажиллагааны онцлог болон мэргэшсэн этгээд болохын хувьд хүлээх үүрэгтэй холбоотойгоор хоёр талаас хөлс шаардах эрх, зардлыг шаардах эрх, зуучлалын үр дүнгээс ашиг олох эрхийн асуудал яригдана.

Хоёр талаас хөлс шаардах эрх

Худалдааны зуучлагч нь гэрээний талуудын хооронд зуучлалын үйл ажиллагаа явуулах байр суурь бүхий этгээд байдаг тул зуучлуулагчаас гадна гэрээний нөгөө талын өмнө шударгаар, түүний эрх ашгийг хамгаалах үүрэг хүлээнэ.

¹⁰ Мөн тэнд, 265 дахь тал.

¹¹ Hatada Koumei et al., Lecture on commercial trade law, 127 (Chuuoukeizaishya., 2018);

¹² Мөн тэнл

Улмаар худалдааны зуучлагч нь гэрээний хоёр талаас хөлс шаардах эрхтэй байхаар зохицуулсан байдаг. Герман, Япон улс нь худалдааны зуучлагчийн гэрээний хоёр талаас хөлс шаардах эрхийн талаар Худалдааны хууль (цаашид, ХХ)-даа тодорхой байдлаар зохицуулжээ.

Монгол Улсын хувьд ч ИХ-ийн 413.12-д “Худалдааны зуучлагчид олгох зуучлалын хөлс, шагналыг хэн төлөх талаар тохиролцоогүй бол гэрээний талууд тогтоосон хөлс, шагналыг тэнцүү хэмжээгээр төлөх үүрэгтэй” хэмээн худалдааны зуучлагчийн гэрээний хоёр талаас хөлс шаардах эрхийг баталгаажуулж өгсөн. Өөрөөр хэлбэл, гэрээний талууд хөлс, шагналыг тэнцүү хэмжээгээр төлөх үүрэгтэй байхаар зохицуулсан нь хөлсний хэмжээг тогтоосон гэхээс илүүтэй худалдааны зуучлагчид гэрээний нөгөө талаас зуучлалын хөлсийг шууд шаардах боломжийг олгосон хэмээн ойлгож болно.

Түүнчлэн онолын хувьд зуучлалын үйл ажиллагааны явцад гарсан зардлыг зуучлуулагчаас шаардах боломжтой юм. Энэ талаар Монгол, Герман, Японы улсын холбогдох хуульд тодорхой зохицуулаагүй ч хориглоогүй тул зуучлалын гэрээнд заасан тохиолдолд гэрээний эрх чөлөөний зарчмын дагуу зардлыг шаардаж болно.

Зуучлалын үр дүнгээс ашиг олох эрх

Худалдааны зуучлагч нь зуучлалын үйл ажиллагаа явуулах төдий тул өөрөө зуучлагчаар оролцсон үйл ажиллагааны үр дүнгээс аливаа ашиг олох, гэрээний талаас мөнгөн төлбөр хүлээж авах эрх эдлэхгүй. Хэрэв гэрээний нэг талаас гэрээний үүргийн гүйцэтгэлд чиглэсэн мөнгөн төлбөрийг худалдааны зуучлагч хүлээн авсан тохиолдол гэрээний нөгөө талд төлөх үүргийн хүлээнэ.

Энэ талаар Монгол Улсын хувьд Герман Улсын ХХ-ийн 97.1-ийн нэгэн адилаар ИХ-ийн 413.10-т “Талууд хоорондын зуучлалын үр дүнд байгуулагдсан гэрээнээс худалдааны зууч-

лагч аливаа ашиг олох, эсхүл мөнгөн төлбөр авах эрхгүй” хэмээн зохицуулжээ. Харин Япон Улсын хувьд ХХ-ийн 544.1-д зарчмын хувьд хориглосон боловч “гэрээнд өөрөөр заасан эсвэл арилжааны заншил байгаа тохиолдолд” худалдааны зуучлагчийн зүгээс ашиг олох эсвэл мөнгөн төлбөр авч болохоор хуульчилжээ.

Худалдааны зуучлагчийн үүрэг

Худалдааны зуучлагч нь мэргэшсэн арилжаа эрхлэгч болохын хувьд тухайн үйл ажиллагааны хүрээнд бусдын өмнө тодорхой үүргийг хүлээнэ. Энэхүү худалдааны зуучлагчийн үүргийг дараах байдлаар ангилан харьцуулан авч үзэж болно.

Хянамгай байх үүрэг

Худалдааны зуучлагч (зөвхөн хоёр талын зуучлалын гэрээ) нь зуучлуулагчийн өмнө гэрээ хэлцэл байгуулахын төлөө чармайж ажиллахаас гадна байгуулсан гэрээ нь ямар нэгэн доголдолгүй хэрэгжихэд анхаарах буюу хянамгай байх (*duty of care*) үүргийг нийтлэг байдлаар хүлээнэ. Герман, Япон улс нь худалдааны зуучлагчийн хянамгай байх үүргийн талаар тусгайлан зохицуулаагүй бөгөөд даалгаврын гэрээний зохицуулалт үйлчилнэ.

Монгол Улсын хувьд ч худалдааны зуучлагчийн хянамгай байх үүргийн талаар тусгайлан зохицуулаагүй тул даалгаврын гэрээний зохицуулалт үйлчлэх учиртай. Энэ хүрээнд ИХийн 400.1-д заасан “Даалгавар гүйцэтгэгч даалгаврыг даалгавар өгөгчийн зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй” хэмээх зохицуулалтыг хянамгай байх үүргийн үүднээс тайлбарлах боломжтой юм.

Мөн салбар хуулиар тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй худалдааны зуучлагчид тодорхой төрлийн үүргийг хүлээлгэх тохиолдол бий. Тухайлбал, Японы хувьд “Орон сууц,

газар, барилгын арилжааны хууль”¹³-аар үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид тайлбарлах үүрэг (*duty of explanation*), нууц хадгалах (*duty of confidentiality*) үүргийг хүлээлгэсэн байна. Эдгээр үүргийг үл хөдлөх хөрөнгийн зуучлагч зөрчсөн тохиолдолд түүний гэм хорын хариуцлага яригдах боломжтой болно.

Маргаанаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үүрэг

Маргаанаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн худалдааны зуучлагчийн үүргийн хүрээнд дээж хувийг хадгалах үүрэг, гэрээний бичиг баримтыг хоёр талд олгох үүрэг, журнал хөтлөх үүрэг, баримт бичгийн хуулбар олгох үүрэг яригдана. Эдгээр үүргийн талаар Монгол Улсын ИХ-ийн 413, 414-д тусгайлан зохицуулсан байна.

Гэрээний талыг нэрлэх эсхүл нууцлах үүрэг

Япон Улсын ХХ-ийн 548-т зуучлуулагч болон гэрээний нөгөө талын зүгээс өөрийн нэрийг нууцлахыг худалдааны зуучлагчид илэрхийлсэн тохиолдолд хоёр талын байгуулах гэрээ болон тэдгээр олгох гэрээний хувь, хуулбарлах олгох баримт бичигт тухайн талын нэрийг бичихгүй байх үүргийг хүлээхээр зохицуулжээ. Монгол Улсын хувьд ИХ-ийн 413.8-д гэрээний нэг тал нь нэрлэгдээгүй байхыг хүлээн зөвшөөрсөн боловч, энэ тохиолдолд хүлээх худалдааны зуучлагчийн үүргийн талаар тодорхой зохицуулаагүй байна.

Япон бизнесийн практикт хэлэлцээрийн эхэн үед өөрийн нэрийг нууцлах үүргийн худалдааны зуучлагчид хүлээлгэх, гэрээ байгуулах хүртэл гэрээний нөгөө талыг мэдэх боломжгүй байх тохиолдол байдаг боловч, гэрээ байгуулсны дараа гэрээний нэг талын нэрийг нууцлах шаардлага бүхий арилжаа байх эсэхэд эргэлзэх судлаачид байдаг¹⁴.

¹³ 宅地建物取引業法 (1952年).

¹⁴ 竹田省『商行為法』112頁(弘文堂書 1931年)、小町谷操三『商行為法論』207頁(有斐閣 1943年).

Герман Улсын хувьд ХХ-ийн 95.1-д “худалдааны зуучлагч нэг тал нь нэрлэгдээгүй гэрээг нөгөө тал нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд сүүлд тухайн гэрээнд нэр нь бичигдэх этгээдтэй гэрээ байгуулсанд тооцно. Харин гэрээний тал нь үндэслэл бүхий гомдол гаргасан бол гэрээ байгуулсанд тооцохгүй.”, 95.2-т “гэрээний нөгөө талын нэрийг тухайн бүс нутгийн арилжааны заншлаар тогтсон хугацаанд тусгана. Тогтсон хугацаа байхгүй тохиолдолд тухайн нөхцөл байдлаас шалтгаалан боломжит хугацааны дотор тусгана. ”, 95.3-д “гэрээний тал нэрлэгдээгүй байгаа цед эсвэл нэрлэгдсэн талын эсрэг үндэслэл бүхий гомдол гаргасан тохиолдолд гэрээний талууд худалдааны зуучлагчаас гэрээний үр дагаврыг шаардах эрхтэй” хэмээн тодорхой байдлаар зохицуулжээ.

Эндээс үзэхэд Монгол Улсын хувьд худалдааны зуучлагч нэрлэгдээгүй гэрээний талын нэрийг ил болгох үүрэг хүлээх эсвэл нууцлах үүрэг хүлээх эсэх нь тодорхойгүй байна. Цаашид бизнесийн практик, түүний нөхцөл байдлыг харгалзсаны үндсэн дээр Монгол Улс дахь худалдааны зуучлагчид аль үүргийг хүлээлгэх талаар нарийвчлан судлах шаардлагатай юм.

Үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг

Гэрээний тал нэрлэгдээгүй тохиолдолд гэрээний нөгөө талын эрхийг хамгаалах шаардлага үүснэ. Улмаар Германы ХХ-ийн 95.2-д Японы ХХ-ийн 549-д зааснаар гэрээний тал нэрлэгдээгүй худалдааны зуучлагч нь гэрээний талыг нэрлээгүй бол нөгөө талын өмнө үүргийн гүйцэтгэлийг хангах үүргийг хүлээхээр хуульчилжээ.

Энэ талаар Монгол Улсын хувьд ИХ-ийн 413.8-д “Гэрээний нэг тал нь нэрлэгдээгүй, ... бол нөгөө тал нь гэрээ байгуулахтай холбогдсон үр дагаврыг шаардах эрхтэй” хэмээн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хэнээс шаардах нь тодорхой бус байдлаар зохицуулжээ. Гэвч энэхүү зохицуулалтыг Герман Улсын

зохицуулалттай харьцуулан авч үзвэл худалдааны зуучлагчид гэрээний нөгөө талын өмнө үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээлгэсэн хэмээн дүгнэж болохоор байна. Дээр дурдсан үүргийн талаар заасан холбогдох улсын хуулийн заалтыг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Худалдааны зуучлагчийн үүргийн харьцуулалт

	Үүргийн төрөл	Монгол	Герман	Япон
1	Хянамгай байх үүрэг	ИХ 400.1	ИХ 662	ИХ 656, 644
2	Дээж хадгалах үүрэг	ИХ 413.1	XX 96	XX 545
3	Гэрээний бичиг баримтыг хоёр талд олгох үүрэг	ИХ 413.3	XX 94	XX 546.2
4	Журнал хөтлөх үүрэг	ИХ 414.1	XX 100	XX 547.1
5	Журналын хуулбар олгох үүрэг	ИХ 414.2	XX 101	XX 547.2
6	Гэрээний нэг тал гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд нөгөө талд нэн даруй мэдэгдэх үүрэг	ИХ 413.5	XX 94.3	XX 546.3
7	Гэрээний талын нэрийг ил болгох үүрэг	-	XX 95	-
	Гэрээний талын нэрийг нууцлах үүрэг	-	-	XX 548
8	Үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг	ИХ 413.8	XX 95.3	XX 549

1.1.3 Худалдааны зуучлагчийн гэрээний төрөл

Худалдааны зуучлагчийн гэрээний түгээмэл хэлбэр нь даатгалын зуучлагчийн гэрээ, үл хөдлөх хөрөнгийн зуучлагчийн гэрээ

байдаг. Энэ хэсэгт өмнө дурдсан хоёр гэрээний талаар авч үзье.

Даатгалын зуучлагчийн гэрээ

Худалдааны зуучлагчийн хамгийн түгээмэл хэлбэр нь даатгалын компани болон даатгуулагч хооронд зуучийн үйл ажиллагаа явуулдаг даатгалын зуучлагч (*insurance broker*) юм.

Монгол Улсын Даатгалын тухай хуульд зааснаар даатгалын зуучлагч гэж “*даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээдийг*” хэлнэ хэмээн тодорхойлсон байна.¹⁵

Даатгалын зуучлагч нь даатгуулагчийн даалгавраар даатгалын гэрээний нөхцөлийг хянах, тохиромжтой даатгалын төлбөрийг тогтоох, даатгалын талаар зөвлөх замаар түүнд даатгалын гэрээ байгуулахад зуучлах чиг үүрэг бүхий этгээдийн хэлнэ. Өөрөөр хэлбэл, даатгалын компаниас бие даасан этгээд байдаг тул даалгуулагчийн төлөө ажиллах үндсэн механизм бүрддэг хэмээн хэлж болно.

Энэ шинжээрээ худалдааны төлөөлөгчийн хүрээнд яригдах даатгалын төлөөлөгчөөс ялгагдана. Монгол Улсын Даатгалын тухай хуульд ч “*даатгагчид даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг олгохгүй*”¹⁶ байхаар, “*даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг давхардуулан олгохгүй*”¹⁷ байхаар зохицуулсан байна.

2021 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид, СЗХ)-нд 45 даатгалын зуучлагч компани, 11 банк даатгалын зуучлагчийн бүртгэлтэй-

¹⁵ Даатгалын тухай хуулийн 3.2.3, 2004 он.

¹⁶ Мөн тэнд, 12.3.

¹⁷ Мөн тэнд, 12.5.

гээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр даатгалын зуучлагч нь худалдааны зуучлалын гэрээ байгуулах замаар даатгагч болон даатгуулагчийн хооронд зуучийн үйл ажиллагаа явуулдаг.

Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчийн гэрээ

Зуучлагчийн хамгийн түгээмэл хэлбэр нь үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх талуудын хооронд зуучийн үйл ажиллагаа явуулдаг үл хөдлөх хөрөнгийн зуучлагч (*real estate broker*) юм.

Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч нь түрээслэгч, худалдан авагчийн даалгавраар тохиромжтой үл хөдлөх хөрөнгийг тогтоох, танилцуулах, үл хөдлөх хөрөнгийн зөвлөх замаар түүнд үл хөдлөх хөрөнгийг олж авахад зуучлах чиг үүрэг бүхий этгээдийн хэлнэ. Өөрөөр хэлбэл, үл хөдлөх хөрөнгийн эзнээс бие даасан этгээд байдаг. Энэ шинжээрээ худалдааны төлөөлөгчийн хүрээнд яригдах үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгчөөс ялгагдана.

Монгол Улсад 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар СЗХ-нд бүртгэлтэй 195 үл хөдлөх хөрөнгийн зуучлагч үйл ажиллагаа явуулж байна. Эрх зүйн зохицуулалтын хувьд СЗХ-ны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг баталсан.

Энэхүү журмын 1.2-т үл хөдлөх хөрөнгийн зуучлагч нь дараах үйл ажиллагааг явуулахаар заасан.

Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааг зуучлах,

Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслүүлэх, хөлслөх үйл ажиллагааг зуучлах.

Харин Монгол Улсын ИХ-ийн 413.2-т “Энэ хуулийн 413.1-д зааснаас бусад хэлцэл болон үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэлцлийг худалдааны зуучлагчийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн тохиолдолд худалдааны зуучлагч гэж үзэхгүй” хэмээн зохицуулсан.

Энэхүү зохицуулалтын үзэл санаа нь ахуйн шинжтэй үл хөдлөх хөрөнгийн хэлцэлд үл хөдлөх хөрөнгийн зуучлагчийн тусламжийг авсан тохиолдолд хамаарах юм. Өөрөөр хэлбэл, ИХ-ийн 413.1-д “аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд үл хөдлөх хөрөнгө худалдах-худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ” заажээ.

Тухайлбал, орон сууц хөлслөхдөө үл хөдлөх хөрөнгө зуучлагчийн тусламжийг авсан тохиолдолд тухайн үл хөдлөх хөрөнгө зуучлагч нь худалдааны зуучлагчид тооцогдохгүй юм. Энэ тохиолдолд ердийн зуучлалын гэрээний зохицуулалт үйлчилнэ.

Үүнээс гадна даатгал зуучлагчийн гэрээ, үл хөдлөх хөрөнгө зуучлагчийн гэрээнээс гадна аялал зуучлагчийн гэрээ нь нэлээд түгээмэл тохиолдох бөгөөд жуулчин тээвэрлэх зуучлагчийн гэрээ, хоноглох газар зуучлагчийн гэрээ зэрэг томоохон байр суурийг эзэлдэг

1.2. ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ

Худалдааны төлөөлөгчийн талаар авч үзэхийн өмнө түүнийг худалдааны төлөөлөл, худалдааны дилер болон дистрибьютерээс ялгах шаардлагатай юм. Улмаар худалдааны төлөөлөл, дилер, дистрибьютерийн ойлголт болон арилжааны эрх зүйн зохицуулалтыг товч танилцуулъя.

1.2.1 Төсөөтэй ойлголтоос ялгах

Худалдааны төлөөллөөс ялгах

Худалдааны төлөөлөгчийн талаар авч үзэхийн тулд худалдааны төлөөллөөс ялгах шаардлага үүснэ. Мөн иргэний эрх зүйн төлөөлөл болон худалдааны төлөөллийн холбоо хамаарал, ялгааг тодорхойлох шаардлагатай болно.

Эх газрын иргэний эрх зүй дэх төлөөлөл нь “илэрхий байх” зарчимд тулгуурлах бөгөөд төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаа тохиолдолд энэ талаар нөгөө талд илэрхийлээгүй бол төлөөлөгчид тооцогдохгүй байх зарчим үйлчилнэ.¹⁸ Өөрөөр хэлбэл, төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн төлөө хийж буй хэлцлийн үр дагаврыг төлөөлүүлэгчид үүсгэхийн тулд бусдыг төлөөлж байгаа талаар гэрээний нөгөө талд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаагаа гэрээний нөгөө талд илэрхийлээгүй тохиолдолд гэрээний нөгөө тал нь гэрээний талыг төлөөлөгч хэмээн бодох тул илэрхийлээгүй төлөөлөгчийн үйлдэл нь ИХ-ийн дагуу тухайн төлөөлөгчийн үйлдэлд тооцогдох зарчим үйлчилдэг.¹⁹

Монгол Улсын ИХ-ийн Ерөнхий ангийн 62 дугаар зүйл болон түүнээс хойших зохицуулалт нь төлөөллийн “илэрхий байх” зарчмыг хүлээн зөвшөөрсөн байна. Мөн төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаагаа мэдэгдэлгүйгээр хэлцэл хийсэн бол түүнтэй хэлцэл хийсэн этгээд бусдыг төлөөлж байгаа этгээдтэй хэлцэл хийж байгаагаа мэдэх ёстой байсан тохиолдолд төлөөлүүлэгчид хэлцлийн үр дагавар үүсэхээр тусгажээ (ИХ 65.2.).

Харин арилжааны эрх зүйн хүрээнд түргэн шуурхай байдал чухлаар тавигдах тул хэлцэл хийх бүрд нэг бүрчлэн бусдыг төлөөлж байгаа талаар гэрээний талд илэрхийлэх нь

¹⁸ Б.Амарсанаа, Г.Давааням, Арилжааны эрх зүй, 2022, УБ, 125 дахь тал.

¹⁹ Мөн тэнд, 126 дахь тал.

түргэн шуурхай байдал харшилна. Мөн гэрээний талын хувьд ч төлөөлөгчийг бусдын нэрийн өмнөөс хэлцэл хийж байгаа талаар мэдэж байх нь нийтлэг тул илэрхийлэл байхгүй байсан ч төлөөлөгчийн хийсэн хэлцлийн эрх зүйн үр дагавар төлөөлүүлэгчид үүсэх зарчим үйлчилдэг.²⁰

Энэхүү ойлголтыг худалдааны төлөөлөл (герман: *Handlungsvollmacht*) хэмээн нэрлэж болох бөгөөд Германы ХХ-ийн 54-р зүйл, Япон Улсын ХХ-ийн 504, 506-д зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, Япон, Германы ХХ дахь худалдааны төлөөллийн талаарх зохицуулалт нь Иргэний эрх зүй дэх төлөөллийн “илэрхий байх” зарчмын дүрмийн бус зохицуулалт хэмээн дүгнэж болно. Монгол Улсын хувьд худалдааны төлөөлөлд хамаарах тусгай зохицуулалт байхгүй байна.²¹

Учир нь, Монгол Улсын ИХ-ийн тусгай анги дахь худалдааны төлөөлөгчийн гэрээ нь худалдааны төлөөллөөс ялгаатай ойлголт юм. Худалдааны төлөөлөгч болон худалдааны төлөөллийг дараах хүснэгтэд дурдсан шалгуурын үндсэн дээр ялгаж болно.

Хүснэгт 3. Худалдааны төлөөлөл, худалдааны төлөөлөгчийн ялгаа²²

№	Эрх зүйн байдал	Орлого	Төлөөлөх этгээд	Зардал хариуцах
1	Худалдааны төлөөлөл / ажилтан/	Цалин, урамшуулал	Зөвхөн нэг этгээдэд үйлчлэх	Төлөөлүүлэгч
2	Худалдааны төлөөлөгч	Үйлчилгээний хөлс	Олон тооны этгээдтэй гэрээ байгуулах	Өөрөө

²⁰ 江頭憲治郎『商取引法（第8版）』283頁（成文堂、2018年）。

²¹ Б.Амарсанаа, Г.Давааням, Арилжааны эрх зүй, 2022, 126 дахь тал.

²² Ootsuki Toshie, A Study on Agent Commercial, The Chuo-Gakuin University Rev., of Economic & Commerce 7(2) 25, 29 (1993).

Худалдааны төлөөлөгчийн хувьд тодорхой арилжаа эрхлэгчийн төлөө гэрээ байгуулах замаар байнгын байдлаар төлөөлөх үйл ажиллагаа явуулдаг. Тодорхой арилжаа эрхлэгч гэдэг нь нэг этгээдээр хязгаарлагдахгүй бөгөөд хэдэн хэдэн арилжаа эрхлэгч байх боломжтой.

Харин худалдааны төлөөлөгчийн байнгын гэх шинжийн хүрээнд худалдааны төлөөлөгчийг нэг удаагийн эсвэл хэд хэдэн удаагийн төлөөллийн үйлчилгээ үзүүлэх богино хугацааны гэрээний харилцаанаас ялган авч үзэх шаардлагатай байдаг.

Худалдааны дилер, дистрибьютерээс ялгах

Бараа бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг арилжаа эрхлэгчдийн дотор үйлдвэрлэгч болон нийлүүлэгч (цаашид, нийлүүлэгч) нараас бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, тухайн брэндийн албан ёсны нэрийн өмнөөс зах зээлд нийлүүлэх замаар үйл ажиллагаа явуулдаг арилжаа эрхлэгч (цаашид, борлуулагч) байдаг.

Бизнесийн практикт борлуулагч болон нийлүүлэгч талын хооронд үл өрсөлдөх үүрэг хүлээлгэх, монопол эрхтэйгээр борлуулах, барааны тэмдгийг ашиглах эрх, дамжуулан борлуулах эрх, борлуулах зах зээлийн заах, борлуулах ноу хауг олгох зэрэг олон зүйлийн талаар тусгасан дилерийн эсвэл дистербютерийн гэрээ гэх зэрэг ерөнхий гэрээг байгуулдаг. Улмаар борлуулагч нь эдийн засгийн хувьд нийлүүлэгчийг дагалдах шинжтэй байх бөгөөд эрх зүйн байдлын хувьд ч худалдааны төлөөлөгчтэй төстэй байх нь бий.

Энэ төрлийн худалдах, худалдан авах гэрээг нийтлэг байдлаар нь

1. Монопол эрхтэй гэрээ (sole/exclusive dealer),
2. Монопол эрхгүй гэрээ (non-exclusive dealer) гэж ангилж болно.

Монопол эрхтэй гэрээ гэдэг нь борлуулагч тухайн зах зээлд нийлүүлэгчийн бараа бүтээгдэхүүнийг дангаараа борлуулах эрх бүхий гэрээг хэлнэ. Энэ төрлийн гэрээг гадаад худалдаанд түгээмэл ашигладаг. Өөрөөр хэлбэл, нэг улсын үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, нөгөө улсад борлуулах тохиолдолд хэрэглэх бөгөөд борлуулагчийн хувьд үйлдвэрлэгчийн охин компани байх тохиолдол нийтлэг байна.

Харин монопол эрхгүй гэрээ гэдэг нь нийлүүлэгчийн бараа бүтээгдэхүүнийг олон тооны борлуулагч тухайн зах зээлд борлуулах эрхтэй байхыг хэлнэ. Энэ төрлийн гэрээ нь үйлдвэрлэгчээс монопол эрх авсан борлуулагчаас бусад зах зээл рүү дамжуулах борлуулах тохиолдолд түгээмэл хэрэглэгдэнэ.

Дилер, дистрибьютерийн гэрээ нь худалдааны төлөөлөгчтэй төстэй боловч эрх зүйн зохицуулалтын хувьд худалдааны төлөөлөгчийн гэрээний ойлголтод хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, эрх зүйн зохицуулалтын хувьд ИХ-д заасан даалгаврын гэрээнээс илүүтэй худалдах, худалдан авах гэрээнд хамаарна.

Хүснэгт 4. Дилер, дистрибьютерийн гэрээ болон худалдааны төлөөлөгчийн гэрээний харьцуулалт

№	Гэрээний төрөл	Борлуулалтын арга	Орлого	Харилцагчтай байгуулах гэрээний тал
1	Дилер, дистрибьютерийн гэрээ	Нийлүүлэгчээс бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, зах зээлд борлуулах	Худалдан авсан болон худалсан үнийн зөрүү	Дилер, дистрибьютер
2	Худалдааны төлөөлөгчийн гэрээ	Нийлүүлэгчийн төлөөлөх, зуучлах	Үйлчилгээний хөлс	Нийлүүлэгч

1.2.2 Худалдааны төлөөлөгчийн гэрээний зохицуулалт

Худалдааны төлөөлөгч гэж тодорхой арилжаа эрхлэгчийн төлөө байнгын шинжтэй, түүний үйл ажиллагаанд хамаарах асуудлаар төлөөлөх үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн хэлнэ. Уг үйл ажиллагааг арилжааны хуулийн этгээд төдийгүй хувь хүн эрхэлж болно.²³ Монгол Улсын ИХ-ийн 415.1-д зааснаар *“Үйлчилгээний нэрийн өмнөөс, түүний зардлаар гэрээ байгуулах буюу бараа, эрх, үйлчилгээг борлуулахад зуучилж байгаа этгээдийг худалдааны төлөөлөгч гэнэ”*.

Худалдааны төлөөлөгч нь төлөөлүүлэгч арилжаа эрхлэгчийн төлөөлөгчийн хувиар бараа бүтээгдэхүүнийг борлуулах, гэрээ байгуулах асуудлаар тодорхой хугацааны туршид эрх олгогдсон бие даасан арилжаа эрхлэгч байдгаараа ерөнхий худалдааны төлөөллийн ойлголтоос ялгарна. Улмаар арилжаа эрхлэгчийг тодорхой зах зээлд бараа бүтээгдэхүүнийг борлуулахад зуучлах, зах зээлд нэвтрэх, түүнд мэдээлэл олгосны оронд үйлчилгээний хөлс авах үндсэн зорилго бүхий худалдааны төлөөлөгчийн гэрээ байгуулах замаар үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улсын хувьд томоохон хэмжээний импортлогч болон үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд орон нутагт бараа бүтээгдэхүүнээ борлуулахдаа худалдааны төлөөлөгч хувь хүн эсвэл хуулийн этгээдийн тусламжтай үйл ажиллагаа явуулах тохиолдол байна.

Монгол Улсад том хэмжээний худалдааны төлөөлөгч (англи: commercial agency, герман: Handelsvertreter)²⁴ нь төдийлөн түгээмэл биш боловч, XIX зууны сүүл үеийн Европын улсуудад хүчтэй дэлгэрч, өнөөгийн арилжааны салбарт томоохон үүргийг гүйцэтгэж байна. Үйл ажиллагааны зардлаа бага, ашгаа их байлгах зорилго бүхий арилжаа эрхлэгчийн хувьд тухайн

²³ Philipp S. Fischinger, Handelsrecht, 248 (C.F Müller, 2019).

²⁴ Мөн тэнд

бүс нутгийн талаарх мэдээлэл, өргөн холбоо харилцаа бүхий худалдааны төлөөлөгчийг ашиглах нь оновчтой сонголт байдаг.

Энэ нь арилжаа эрхлэгчийн хувьд шинэ зах зээлд салбар, төлөөлөгчийн газар байгуулахад ихээхэн зардал, эрсдэл дагалддагтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, тухайн зах зээлийг шинээр таньж мэдэхээс эхлээд салбар, төлөөлөгчийн газар байгуулах, ажилтан илгээх зэрэг нь үйл ажиллагааны үр дүнд олж авах ашигтай харьцуулахад их хэмжээний зардлыг дагуулна. Улмаар тухайн бүс нутгийн талаар сайн мэдэх, бусад нутагтаа танигдсан этгээдийг ашиглах нь арилжаа эрхлэгчийн хувьд арилжааны шинэ суваг нээх боломжийг хялбар болгодог байна.²⁵ Худалдааны төлөөлөгч ажиллуулахын давуу болон сул талыг авч үзвэл:

Худалдааны төлөөлөгчийн давуу тал:²⁶

1. Төлөөлүүлэгч нь худалдааны төлөөлөгчид зөвхөн хураамж (*commission*) төлөх бөгөөд тухайн зах зээлд нэвтрэхэд шаардлагатай зардлыг хэмнэх;
2. Төлөөлүүлэгч нь харилцагчийн өмнө хүлээх хариуцлага, бараа бүтээгдэхүүний үнэ, сурталчилгаа, хүргэлт, үйлчилгээ зэрэгт хамаарах шийдвэр гаргах эрхийг эдлэх;
3. Төлөөлүүлэгч нь худалдааны төлөөлөгчийн эзэмшиж буй тодорхой бүс нутгийн мэдээлэл, харилцаа холбоог ашиглах замаар тухайн зах зээлд нэвтрэх;
4. Төлөөлүүлэгч нь худалдааны төлөөлөгчийн тухайн бүс нутаг дахь хэлний мэдлэгийг ашиглах замаар харилцагчтай зохистой харилцах боломжтой болох;
5. Төлөөлүүлэгч нь худалдааны төлөөлөгчийн мэргэжлийн

²⁵ Ootsuki Toshie, A Study on Agent Commercial, The Chuo-Gakuin University Rev., of Economic & Commerce 7(2) 25, 26 (1993).

²⁶ ICH Japan Inc., Европ бүс нутгийн худалдааны төлөөлөгчийн байдал, чиг үүрэг-борлуулалтын сувгаа өргөжүүлэх апра болох уу? [<http://www.ichgmbh.com/whats-new/2013/07/16/167>].

чадвар, зөвлөгөөнд тулгуурлах замаар бараа бүтээгдэхүүнийг сайжруулах боломжтой юм.

Худалдааны төлөөлөгчийн сул тал:²⁷

1. Худалдааны төлөөлөгчийг оновчтой сонгож чадаагүй тохиолдолд тухайн худалдааны төлөөлөгчөөр дамжуулан явуулж буй үйл ажиллагаа нь үр ашиггүй байх эрсдэлтэй;
2. Худалдааны төлөөлөгчийн гэрээний харилцаа нь хоёр талын итгэлцэлд суурилах тул худалдааны төлөөлөгчөөс шалтгаалан гэрээг цуцлах тохиолдолд төлөөлүүлэгч нь нөхөн төлбөр шаардах эрсдэлтэй;
3. Худалдааны төлөөлөгчид хэт найдсанаас болж, төлөөлүүлэгч тухайн зах зээлийн талаар мэдээлэлгүй болох эрсдэлтэй;
4. Төлөөлүүлэгчийн бараа бүтээгдэхүүний зах зээлд эзлэх байр суурь томорсон тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийг зөрчих эрсдэлтэй;
5. Худалдааны төлөөлөгч нь өрсөлдөх арилжаа эрхлэгчтэй хамтран ажилладаг тохиолдолд мэдээлэл алдагдах эрсдэлтэй юм.

Худалдааны төлөөлөгч нь даатгал, далайн тээвэр, бараа бүтээгдэхүүнийг худалдах зорилго бүхий арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны хүрээнд түгээмэл байдлаар оролцдог. Сүүлийн үед тухайн бүс нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахдаа аялал жуулчлалын төлөөлөгч (англи: *travel agency*)-ийг ашиглах замаар хүний нөөцийн зардал, эрсдэлийг бууруулах тохиолдолд нэмэгдэж байна.²⁸

Төлөөлүүлэгч нь арилжаа эрхлэгч байх нийтлэг бөгөөд худалдааны төлөөлөгчийн хувьд ч арилжаа эрхлэгч байх

²⁷ Мөн тэнд

²⁸ Ootsuki Toshie, A Study on Agent Commercial, The Chuo-Gakuin University Rev., of Economic & Commerce 7(2) 25, 27 (1993).

шаардлага тавигдаж байна. Монгол Улсын ИХ-д худалдааны төлөөлөгчийн эрх зүйн байдлын талаар тодорхой зохицуулаагүй боловч зохицуулалтын агуулгаас үзэхэд хуулийн хэрэглээний хүрээнд арилжаа эрхлэгч байхаар тайлбарлах нь зүйтэй.

Мөн худалдааны төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бие даасан арилжаа эрхлэх гэсэн шаардлагыг тавих бөгөөд төлөөлүүлэгчийн бүтцийн нэгж эсвэл түүний ажилтан байх тохиолдолд худалдааны төлөөлөгчийн харилцаа үүссэн гэж үзэх боломжгүй.²⁹ Харин худалдааны төлөөлөгчийн гэрээний нөгөө тал нь арилжаа эрхлэгч эсвэл иргэн байх эсэх нь эрх зүйн үр дагаврын хувьд төдийлөн ач холбогдолтой биш байдаг.

Худалдааны төлөөлөгчийн гэрээний шинж

Бизнесийн практикт худалдааны төлөөлөгчийн гэрээг “агентын гэрээ”³⁰ хэмээн нэрлэх тохиолдол байна. Энэхүү худалдааны төлөөлөгчийн гэрээ нь онолын хувьд даалгаврын гэрээний нэг төрөл юм.

Улмаар худалдааны төлөөлөгчийн гэрээ болон ИХ дахь худалдааны төлөөлөгчийн гэрээнд тусгайлсан зохицуулалт байхгүй тохиолдолд даалгаврын гэрээний ерөнхий зохицуулалт үйлчлэх учиртай.

Монгол Улсын ИХ-д худалдааны төлөөлөгчийн гэрээнд тусгайлсан зохицуулалт байхгүй тохиолдолд даалгаврын гэрээний зохицуулалт ашиглаж болох эсэх талаар тодорхой зохицуулаагүй. Гэвч худалдааны төлөөлөгчийн гэрээний онол болон Герман, Япон улсын эрх зүйн сургаалаас³¹ үзэхэд худалдааны

²⁹ Philipp S. Fischinger, Handelsrecht, 249 (C.F. Müller, 2019).

³⁰ Б.Хатантуул, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр, Гэрээний загварын эмхэтгэл, 2020, УБ, 156 дахь тал.

³¹ Ootsuki Toshie, A Study on Agent Commercial, The Chuo-Gakuin University Rev., of Economic & Commerce 7(2) 25, 30 (1993).

төлөөлөгчийн гэрээний хүрээнд даалгаврын гэрээний ерөнхий зохицуулалт үйлчлэх боломжтой байна.

Худалдааны төлөөлөгчийн эрх

Худалдааны төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бие даасан арилжаа эрхлэгч болохын хувьд өөрийн арилжааны үйл ажиллагааг хамгаалах үүднээс тодорхой эрхийг эдэлдэг.

Хөлс, зардал шаардах эрх

Худалдааны төлөөлөгч нь арилжаа эрхлэгч болохын хувьд гэрээгээр тусгайлан тохиролцоогүй байсан ч хөлс шаардах эрхийг эдэлнэ. Энэхүү худалдааны төлөөлөгчийн хөлс шаардах эрхийн талаар Герман Улсын ХХ-ийн 87a-д нарийвчлан зохицуулжээ. Мөн Япон Улсын хувьд ХХ-ийн 512.1-д заасан арилжаа эрхлэгчийн хөлс шаардах эрхийн ерөнхий зохицуулалт үйлчилдэг байна.

Харин Монгол Улсын хувьд худалдааны төлөөлөгчийн хөлс шаардах эрхийн ерөнхий зохицуулалтыг тусгаагүй тул ИХ-ийн 399.1-д заасан даалгаврын гэрээний ерөнхий хөлс шаардах эрхийн ерөнхий зохицуулалтыг ашиглах боломжтой.

Мөн худалдааны төлөөлөгч нь үйл ажиллагааны явцад үүссэн зардлыг төлөөлүүлэгчээс буцаан шаардах эрхтэй байдаг. Энэ талаар Герман Улсын ХХ-ийн 87d1-д *“худалдааны төлөөлөгч нь худалдааны заншлын үүднээс ердийн хэмээн хүлээн зөвшөөрөгдөх хүрээнд арилжааны явцад үүссэн зардлыг л шаардаж болно”* хэмээн зохицуулсан байна. Харин Япон Улсын ХХ-д тодорхой зохицуулалт байхгүй боловч Иргэний хууль дахь даалгаврын гэрээний даалгавар гүйцэтгэгчийн зардал шаардах эрхийн зохицуулалт нөхөх байдлаар үйлчилдэг байна.

Монгол Улсын хувьд худалдааны төлөөлөгчийн зардал

шаардах эрхийн хүрээнд ИХ-ийн 415.1-д заасан худалдааны төлөөлөгчийн гэрээний тусгай зохицуулалтаас гадна 416.2-т заасан даалгаврын гэрээний ерөнхий шаардах эрхийг хэрэглэх боломжтой юм.

Саатуулан барих эрх

Худалдааны төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бие даасан арилжаа эрхлэгч болохын хувьд үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргаар хангагдсан байх ёстой. Улмаар Япон Улсын ХХ-ийн 31.1-д *“талууд гэрээнд өөрөөр тохиролцоогүй бол худалдааны төлөөлөгч нь арилжаанд төлөөлөх эсвэл зуучилсны үр дүнд бий болсон шаардах эрхийг хэрэгжүүлэх хугацаа болсон бол үүргийн гүйцэтгэлийг хангуулах хүртэл арилжаа эрхлэгчийн төлөө тухайн төлөөлөгчийн газраас эзэмшиж буй эд зүйл эсвэл үнэт цаасыг саатуулан барьж болно”* хэмээн зохицуулсан байна.

Мөн Герман Улсын ХХ-ийн 88а-д *“худалдааны төлөөлөгчийн газар нь хууль заасан саатуулан барих эрхийг урьдчилан хэрэгжүүлэхгүй байхаар тохиролцож болохгүй”*, 88а2-т *“гэрээний харилцаа дуусвар болсон тохиолдолд худалдааны төлөөлөгч нь хэрэгжүүлэх хугацаа болсон хөлс шаардах эрх, зардал шаардах эрхийг гагцхүү хэрэгжүүлэх үүднээс тохиолдолд худалдааны төлөөлөгч нь хэрэгжүүлэх хугацаа болсон хөлс шаардах эрх, зардал шаардах эрхийг гагцхүү хэрэгжүүлэх ”* хэмээн зохицуулжээ.

Өөрөөр хэлбэл, Япон, Герман улсууд худалдааны төлөөлөгчийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүднээс тодорхой хүрээнд саатуулан барих эрхтэй байхыг зөвшөөрчээ. Харин Монгол Улсын хувьд худалдааны төлөөлөгчид төлөөлүүлэгчээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах чиглэсэн саатуулан барих эрх олгогдоогүй байна.

Нөхөн олговор шаардах эрх

Худалдааны төлөөлөгч нь эсвэл хэд хэдэн арилжаа эрхлэгчийн төлөө тэдгээрийг төлөөлөх, зуучлах чиг үүрэг бүхий туслах шинжтэй үйл ажиллагаа явуулдаг тул түүний эрх ашиг, зах зээлийн ач холбогдлыг хамгаалах шаардлага үүсдэг. Улмаар Герман Улсын ХХ нь худалдааны төлөөлөгч гэрээ дуусгавар болсны дараа тодорхой тохиолдолд нөхөн олговор олгохыг шаардах эрхтэй байхаар зохицуулжээ. Монгол Улсын ИХ дахь худалдааны төлөөлөгчийн нөхөн олговор олгохыг шаардах эрх нь Герман Улсын ХХ-ийн зохицуулалтай ойролцоо агуулгатай байна.

Хүснэгт 5. Худалдааны төлөөлөгчийн эрхийн харьцуулсан судалгаа

	Эрхийн төрөл	Монгол	Герман	Япон
1	Хөлс шаардах эрх	ИХ 399.1, 415.5	ХХ 87a	ХХ 512.1
	Зардал шаардах эрх	ИХ 401.1, 416.2	ХХ 87d1	ИХ 649, 650
2	Саатуулан барих эрх	-	ХХ 88a1, 88a2	ХХ 31.1
3	Нөхөн олговор шаардах эрх	ИХ 418	ХХ 89b	-

Худалдааны төлөөлөгчийн үүрэг

Худалдааны төлөөлөгч нь арилжаа эрхлэгч болохын хувьд төлөөлүүлэгчийн өмнө тодорхой үүргийг хүлээнэ.

Хянамгай байх үүрэг

Худалдааны төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн төлөө түүнийг

төлөөлөх, зуучлах үйл ажиллагаа явуулах тул төлүүлэгчийн эрх ашгийг чухалчлах, уг үйл ажиллагаандаа анхааралтай хандах үүргийг хүлээнэ.

Энэхүү үүргийн нэршил болон агуулга нь тухайн улсын зохицуулалтын онцлогоос шалтгаалан бага зэрэг ялгаатай байх боловч, Герман, Япон улсуудын ХХ-д ч ойролцоо агуулгаар туссан байна.

Харин Монгол Улсын хувьд ИХ-ийн 415.3-д *“Худалдааны төлөөлөгч ... нь үйлчилцүлэгчийн заавраар түүний эрх ашиг, ердийн шаардлагад нийцүүлэн цүргээ гүйцэтгэнэ”* хэмээн хянамгай байх үүргийг зохицуулжээ.

Мэдэгдэх үүрэг

Худалдааны төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн төлөө түүнийг төлөөлөх, зуучлах үйл ажиллагаа явуулах үндсэн чиг үүрэг бүхий этгээд байдаг тул түүнийг төлөөлсөн эсвэл зуучилсан тохиолдолд энэ талаар төлөөлүүлэгчид мэдэгдэх үүргийг хүлээдэг.

Монгол Улсын хувьд Герман болон Япон улсуудын ХХ-д заасны нэгэн адилаар ИХ-ийн 415.3-д худалдааны төлөөлөгч нь *“үйлчилцүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол улирал бүрийн сүцүлчийн арав хоногт өөрийн үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний хөлс, шагналын тооцоо, комиссын төлбөрийн дүн зэргийг агуулсан тайланг үйлчилцүлэгчид гаргаж өгнө”* хэмээн зохицуулсан байна.

Нууц хадгалах үүрэг

Худалдааны төлөөлөгч нь төлөөлүүлэгчийг төлөөлөх, зуучлах үйл ажиллагааны хүрээнд олж авсан мэдээллийг бусдад задруулахгүй байх үүргийг хүлээнэ. Энэхүү үүргийг нууц хадгалах үүрэг гэх бөгөөд гэрээ дуусгавар болсны дараа ч хүчинтэй хэвээр үйлчилдгээрээ онцлог.

Герман Улсын ХХ-ийн 90.1-т нөхцөл байдлаас шалтгаалан энгийн арилжаа эрхлэгч олж авах боломжтойгоос бусад мэдээллийг худалдааны төлөөлөгч бусад этгээдэд гэрээ дуусгавар болсны дараа ч задруулахгүй байх үүргийг хүлээхээр зохицуулжээ.

Харин Монгол Улсын ИХ-д худалдааны төлөөлөгчийн нууц хадгалах үүргийн талаар зохицуулаагүй. Гэвч талууд гэрээний эрх чөлөөний зарчмын дагуу гэрээндээ тусгах замаар худалдааны төлөөлөгчид нууц хадгалах үүргийг хүлээлгэх боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй.

Үл өрсөлдөх үүрэг

Худалдааны төлөөлөгчийн гэрээнд төлөөлөгчийн үл өрсөлдөх үүрэг томоохон байр суурийг эзэлдэг. Монгол Улсын ИХ-д худалдааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийн талаар нарийвчлан зохицуулж өгчээ.

Зарчмын хувьд худалдааны төлөөлөгч нь үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр өөр өрсөлдөгч үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг төлөөлөхийг хориглосон (ИХ-ийн 419.4). Харин гэрээ байгуулах үед худалдааны төлөөлөгч, комисс нь өрсөлдөгч үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг төлөөлж байгааг үйлчлүүлэгч мэдэж байсан бол зөвшөөрөл олгосон гэж үзэхээр зохицуулжээ.

Үүргийн зөрчлөөс үүдэх эрх зүйн үр дагаврын хувьд худалдааны төлөөлөгч төлөөлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр өөр өрсөлдөгч этгээдийн төлөө ажилласан бол түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагыг хүлээнэ (ИХ-ийн 419.5).

Мөн гэрээ дуусгавар болсны дараа өрсөлдөгч байгууллагад ажиллахыг хориглосон нөхцөлийг гэрээнд тусгасан бол энэ нь үйлчлүүлэгч нөхөн төлбөр хийж байгаа тохиолдолд хүчинтэй байх (ИХ-ийн 419.6) бөгөөд гэрээний хугацаа нэг жилээс илүүгүй байхаар зохицуулсан (ИХ-ийн 419.7).

Харин төлөөлүүлэгч нь худалдааны төлөөлөгчид худалдах

бараа бүтээгдэхүүний үнийг тогтоох, үл өрсөлдөх үүрэг хүлээлгэсэн зэрэг тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийг зөрчих эсэх тухай төвөгтэй асуудал үүснэ.

Хүснэгт 6. Худалдааны төлөөлөгчийн цүрэг, харьцуулалт

№	Эрхийн төрөл	Монгол	Герман	Япон
1	Хянамгай байх үүрэг	ИХ 400.1	ХХ 86.1, 86.3	ИХ 656, 644
2	Мэдэгдэх үүрэг	ИХ 415.3	ХХ 86.2	ХХ 27.1
3	Нууц хадгалах үүрэг	-	ХХ 90.1	-
4	Үл өрсөлдөх үүрэг	ИХ 419.1	ХХ 90а	ХХ 28

1.2.3 Худалдааны төлөөлөгчийн гэрээний төрөл

Худалдааны төлөөлөгчийн гэрээний түгээмэл хэлбэр нь даатгалын төлөөлөгч болон үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгч байдаг. Эдгээрийг товч авч үзье.

Даатгалын төлөөлөгчийн гэрээ

Худалдааны төлөөлөгчийн хамгийн түгээмэл хэлбэр нь даатгагчийг төлөөлөх, зуучлах үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын төлөөлөгч юм.

Монгол Улсын Даатгалын тухай хуульд даатгалын төлөөлөгч гэж “даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх цүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг”³² хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Мөн “даатгагчаас цалинжин ажиллаж буй ажилтан нь даатгалын

³² Даатгалын тухай хуулийн 3.2.2, 2004.

төлөөлөгчид хамаарахгүй”³³ байхаар зохицуулсан нь даатгалын төлөөлөгчийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

2021 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар СЗХ-нд бүртгэлтэй “Бодь даатгал” ХХК-ийн 750, “Амар даатгал” ХХК-ийн 12, “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 42, “Мандал даатгал” ХХК-ийн 19, “Ган зам даатгал” ХХК-ийн 1, “Хаан даатгал” ХХК-ийн 30, “Ард даатгал” ХХК-ийн 153 даатгалын төлөөлөгч хувь хүн үйл ажиллагаа явуулж байна.

Үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгчийн гэрээ

Худалдааны төлөөлөгчийн нийтлэг хэлбэрийн нэг нь үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг арилжаа эрхлэгчийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг худалдах, түрээслүүлэхэд төлөөлөх, зуучлах үйл ажиллагаа явуулдаг үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгч юм.

Монгол Улсын хувьд үл хөдлөх хөрөнгийн арилжааны харилцааг зохицуулсан бие даасан хууль байхгүй тул үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгчийн эрх зүйг харилцаанд ИХ дахь худалдааны төлөөлөгчийн гэрээний зохицуулалт нийтлэг байдлаар үйлчилнэ.

1.3. КОМИСС

1.3.1 Төсөөтэй ойлголтоос ялгах

Комиссын гэрээг авч үзэхийн өмнө түүнийг ИХ дахь шууд төлөөлөл болон тээвэрлэлтийн гэрээнээс ялгах шаардлагатай юм.

³³ Өмнөхтэй адил, 3.3.

Иргэний хууль дахь шууд төлөөллөөс ялгах

Арилжааны эрх зүй дэх төлөөллийн харилцаа нь Ромын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдөөгүй боловч дундад зууны үеэс арилжааны харилцаа хурдацтай хөгжсөнтэй холбоотойгоор бүрэлдэж тогтсон байдаг. Улмаар Эх газрын эрх зүйн бүлд хамаарах Герман, Франц, Япон зэрэг улсад төлөөллийн харилцааг 1) шууд төлөөлөл болон 2) шууд бус төлөөлөл хэмээн ангилан авч үзэх болжээ. Тухайлбал, 1) шууд төлөөллийн хүрээнд “илэрхий байх” зарчимд суурилсан төлөөллийн ойлголт яригдах бол 2) шууд бус төлөөллийн хүрээнд комиссыг хамааруулан ойлгоно.

Монгол Улсын арилжааны эрх зүй дэх төлөөллийн харилцааны хувьд ч эх газрын эрх зүйн зарчмын дагуу 1). шууд төлөөллийн хүрээнд ИХ-ийн Ерөнхий анги дахь итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөх (ИХ-ийн 63.2), 2) шууд бус төлөөллийн хүрээнд ИХ-ийн Тусгай анги дахь комисс (ИХ 415.2)-ын гэрээг хуульчилжээ.

Харин Англи, Америкийн эрх зүйд төлөөллийн харилцааг тодорхой байдлаар ангилан авч үздэггүй бөгөөд төлөөлөгч нь төлөөлөгчийн хувиар эрх зүйн харилцаанд оролцсон тохиолдолд төлөөлүүлэгчийн талаар гуравдагч этгээдэд мэдэгдсэн эсэхээс үл хамааран эрх зүйн үр дагавар нь төлөөлүүлэгчид үүснэ. Энэ нь арилжааны эрх зүй дэх төлөөллийн тогтолцоо бүрэлдэж тогтсон үе буюу дундад зууны үед төлөөллийн харилцааны ангилал тодорхой байдлаар хэвшиж тогтоогүй байсантай холбоотой юм. Улмаар Англи, Америкийн эрх зүй дэх төлөөллийн онол нь тодорхой байдлын зарчимд суурилагагүй тул шууд бус төлөөлөлд хамаарах комиссын харилцаанд шууд дүйцэх ойлголт байхгүй.³⁴

Улмаар Монгол Улсын ИХ дахь комиссын гэрээний харилцааг тодорхой болгох үүднээс Герман, Япон улсын комиссын гэрээний харилцааг авч үзэх шаардлага үүснэ.

³⁴ Б.Амарсанаа, Г.Давааням, Арилжааны эрх зүй, 126 (2022).

Тээвэрлэлтийн гэрээнээс ялгах

Комиссын гэрээг тээвэрлэлтийн гэрээнээс ялгах нь төдийлөн төвөгтэй биш боловч илгээмжийн гэрээг зарим төрлийн тээвэрлэлтийн гэрээнээс ялган ойлгох нь чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, тээврийн салбарт өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлгүй боловч тээвэрлүүлэгчтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулах замаар бусад компанийн тээврийн хэрэгслийг ашиглаж, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг арилжаа эрхлэгч байдаг.³⁵ Энэ төрлийн арилжаа эрхлэгч нь Монгол Улсад **“тээвэр зуучийн компани”** гэсэн нэрийн дор үйл ажиллагаа явуулж байна.

Энэ төрлийн бизнесийн загвар нь тээвэрлүүлэгчийн үүднээс үзэхэд тээврийн хөлснөөс гадна тухайн этгээдэд үйлчилгээний хөлс төлөх тул шууд тээвэрлэгчтэй гэрээ байгуулснаас өндөр төлбөртэй байдаг. Ийм тохиолдолд онолын хувьд тээвэрлүүлэгч болон бусдын тээврийн хэрэгслийн ашиглаж буй этгээд хоёрын хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан гэж үзэх боломжтой юм. Улмаар тухайн этгээд буюу “тээвэр зуучийн компани” нь тээвэрлүүлэгчийн өмнө тээвэрлэгчийн хариуцлагыг хүлээнэ.³⁶

Харин тээвэрлүүлэгч болон тээвэрлэгч нарын хооронд зуучлалын үйл ажиллагаа явуулж буй тээвэр зуучлагчийн хувьд илгээмжийн гэрээний зохицуулалт үйлчилнэ. Энэ төрлийн үйл ажиллагаанд бүхий төрлийн хоол хүнс, бараа бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээ, “тээвэр зуучийн компани”-ийн зарим төрлийн үйлчилгээ хамаарч болно. Улмаар тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн өмнө тээвэрлэгчийн хариуцлагыг хүлээх бөгөөд тээвэр зуучлагч нь илгээгчийн хувьд зуучийн үйл ажиллагааны хүрээнд хариуцлага хүлээнэ.³⁷

³⁵ Freight Forwarder. Hatada Koumei et al., Lecture on commercial trade law, 161 (Chuuoukeizaisha., 2018).

³⁶ Id., at 161.

³⁷ Id., at 215.

1.3.2. Комиссын гэрээний зохицуулалт

Комисс (герман: *Kommissionär*) гэж нь өөрийн нэрийн өмнөөс бусдын зардлаар бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, эрх хэрэгжүүлэх зуучийн үйл ажиллагаа явуулдаг этгээдийг хэлнэ. ИХ-ийн 415.2-т зааснаар “*Өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг комисс гэнэ*”.

Комиссын үүслийг арилжаа эрхлэгчид нэг газраас нөгөө газарт худалдаа арилжаа хийх болсон үетэй холбон авч үздэг. Тухайлбал, дундад зууны үед арилжаа эрхлэгч нь хол газар арилжаа хийхээр явж буй өөр арилжаа эрхлэгчид бараа бүтээгдэхүүн худалдуулахаар дайх, эсвэл бараа бүтээгдэхүүн худалдан авах зорилгоор бэлэн мөнгө өгч, тодорхой шимтгэлийг олгох бизнесийн практик түгээмэл байв.³⁸

Монгол Улсын хувьд бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах зуучийн үйл ажиллагаа эрхэлдэг комисс төдийлөн нийтлэг биш боловч томоохон хэмжээний импортлогч эсвэл үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг орон нутагт монопол эрхтэй борлуулах эрх бүхий комисс оршиж байна.

Сүүлийн үед тодорхой арилжааны үйл ажиллагаанд мэргэшсэн комисс олноор үйл ажиллагаа явуулах болжээ. Үүнд дараах арилжаа эрлэгчдийг хамааруулан ойлгож болно:

- Зохиогчдын номыг өөрийн нэрийн өмнөөс худалдан борлуулж, шимтгэл авах замаар үйл ажиллагаа явуулдаг номын дэлгүүрүүд. Жишээ: “Интерном” ХХК;
- Кино продакшны бүтээсэн киног тусгай зориулалтын танхимд үзүүлж, шимтгэл авах замаар үйл ажиллагаа явуулдаг кино театрууд. Жишээ: Өргөө кино театр;

³⁸ Hatada Koumei et al., Lecture on commercial trade law, 140 (Chuuoukeizaishya., 2018).

- Үзвэр үйлчилгээний тасалбарыг өөрийн нэрийн өмнөөс борлуулж, шимтгэл авах замаар үйл ажиллагаа явуулдаг тасалбар түгээх газрууд. Жишээ: ticket.mn;
- Бусдын өмчлөлийн такси үйлчилгээг өөрийн нэрийн өмнөөс бусдад санал болгож, шимтгэл авдаг такси компаниуд. Жишээ: ubcab.mn;
- Бусдын өмчлөлийн бараа бүтээгдэхүүнийг өөрийн сүлжээгээр борлуулж, шимтгэл авдаг худалдааны сайтууд. Жишээ: shopru.mn.

Эдгээр нь комиссын гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаас гадна өөрөө бие даасан арилжааны үйл ажиллагааг давхар явуулдаг.

Комиссын хэлбэр нь төлөөлүүлэгч, комиссын төдийгүй гэрээний нөгөө талын хувьд ч эдийн засгийн үр ашгийг бий болгодог чухал ач холбогдол бүхий тогтолцоо юм.

Комиссын эдийн засгийн ач холбогдлыг дараах байдлаар авч үзэж болно.³⁹ Үүнд:

- Төлөөлүүлэгчид орон зайн хувьд алслагдмал арилжаа хийх үед салбар, төлөөлөгчийн газар байгуулах, төлөөлөгч илгээхэд гарах зардлыг хэмнэх боломжийг олгох;
- Төлөөлүүлэгчид арилжааны үйл ажиллагаанд хамаарах комиссын мэдлэг, итгэл, туршлагыг ашиглах замаар түүний нэрээр арилжаа хийх боломжийг олгох;
- Төлөөлүүлэгч нь төлөөлөгч түүнд олгосон төлөөлөх бүрэн эрхийг хэтрүүлэх талаар санаа зовох шаардлагагүй болох;
- Комиссын гэрээний нөгөө талын хувьд гэрээний тал нь комисс байгаа тохиолдолд тухайн комиссын талаар судлахад хангалттай бөгөөд төлөөлүүлэгчийн төлбөрийн чадвар, арилжааны итгэл, төлөөлөх бүрэн эрх олгосон

³⁹ Id.

эсэх талаар судлах шаардлагагүй болох тул арилжааны харилцаа түргэн шуурхай явагдах боломжийг олгох;

- Комиссын хувьд өөрийн зардлаар бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, бусдад худалдахад эрсдэл өндөр байх тул хялбар байдлаар арилжааны үйл ажиллагааг явуулах боломжийг олгох.

Ийнхүү комисс нь төлөөлүүлэгч төдийгүй комиссын үйл ажиллагаа эрхлэгч, гэрээний нөгөө талын хувьд ч тодорхой давуу талыг бий болгодог ач холбогдол бүхий харилцаа юм.

Комиссын гэрээний хувьд төлөөлүүлэгч нь заавал арилжаа эрхлэгч байх шаардлага тавигдахгүй ч практикт арилжаа эрхлэгч байх нь нийтлэг байна. Харин комиссын хувьд арилжаа эрхлэгч байх бөгөөд арилжаа эрхлэгчийн шаардлагыг хангаагүй тохиолдолд комиссын гэрээний зохицуулалт үйлчлэхгүй.

Комиссын гэрээний шинж

Эх газрын эрх зүйд далд хэлбэрээр арилжааны үйл ажиллагаанд оролцож буй этгээдэд холбогдох тусгайлсан зохицуулалт бөгөөд тухайн этгээдэд туслах замаар арилжааны харилцаанд оролцож буй этгээд комисс хэмээн нэрлэнэ.

Төлөөлүүлэгч болон төлөөлөгч (комисс)-ийн хооронд байгуулах комиссын гэрээ нь комиссын нэрийн өмнөөс төлөөлүүлэгчийн зардлаар худалдах, худалдан авах гэрээ байгуулахад чиглэсэн даалгаврын харилцаа байдаг тул суурь гэрээний хувьд даалгаврын гэрээнд хамаарна.

Япон Улсын ХХ-ийн 552.2-т “комисс болон төлөөлүүлэгч хоорондын харилцаанд энэ бүлэгт зааснаас бусад тохиолдолд даалгавар болон төлөөлөлд хамаарах зохицуулалтыг хэрэглэнэ” хэмээн зохицуулжээ.

Комиссын эрх

Комисс нь арилжаа эрхлэгч болохын хувьд хөлс шаардах эрхийг суурь шинжтэйгээр эдлэхээс гадна саатуулан барих эрх, дуудлагаар худалдах эрх, үүргийн гүйцэтгэл хангах эрх, илгээсэн бараа бүтээгдэхүүнийг буцаан шаардах эрх зэрэг тусгай эрхүүдийг эдлэхээр зохицуулсан байдаг.

Эдгээр эрхийн төрлийг Герман, Япон улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзье.

Хөлс шаардах эрх

Комисс нь арилжаа эрхлэгч байдаг тул гэрээгээр тусгайлан тохиролцоогүй байсан ч хөлс шаардах эрхийг эдэлнэ. Комиссын зүгээс даалгаврыг гүйцэтгэснээр хөлс шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжтой болох боловч, үйлчлүүлэгчийн буруугаас шалтгаалан гэрээ хэлцлийг байгуулаагүй тохиолдолд хөлс шаардах эрхээ алдахгүй байх зарчим үйлчилнэ.

Энэ талаар Монгол Улсын ИХ-ийн 415.5-д “Үйлчлүүлэгч гэрээнд заасан нөхцөлийг биелүлээгүй, эсвэл зуучлалын үндсэн дээр зохих хэлцэл байгуулаагүй бол худалдааны төлөөлөгч, комисс нь хөлс, шагнал шаардах эрхтэй” хэмээн зохицуулсан байна.

Мөн комиссын зүгээс даалгаврыг гүйцэтгэхэд зарцуулсан зардлыг буцаан шаардах эрхийг эдэлнэ. Тухайлбал, Монгол Улсын ИХ-ийн 416.2-т “Хөлс, шагналыг төлбөр төлөх талын төлбөрийн дүнгээс тооцох бөгөөд ингэхдээ төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэсний хөнгөлөлт, төлбөр тооцоо, савлалт, гаалийн хураамж, татвар төлөх зэрэгтэй холбогдон үүссэн нэмэлт зардлыг хасаж” бодохоор зохицуулжээ.

Саатуулан барих эрх

Комисс нь өөрийн нэрийн өмнөөс төлөөлүүлэгчийн зардлаар

бусадтай гэрээний харилцаанд орох тул түүний эрх ашгийг төлөөлүүлэгчийн дур зорго бүхий үйлдлээс хамгаалах шаардлага үүсдэг. Энэ хүрээнд комиссын саатуулан барих эрх болон дуудлагаар худалдах эрх яригдана.

Төлөөлүүлэгчийн даалгаврын үндсэн дээр бараа бүтээгдэхүүнийг худалдсан, эсвэл худалдан авсан комисс нь төлөөлүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хангах хүртэл түүний төлөө эзэмшиж буй бараа бүтээгдэхүүнийг саатуулан барих эрхийг эдлэх боломжтой байдаг.

Дуудлагаар худалдах эрх

Комисс нь төлөөлүүлэгчээс бараа бүтээгдэхүүн худалдан авах даалгавар авсан боловч тухайн бараа бүтээгдэхүүнийг хүлээж авахаас төлөөлүүлэгч татгалзсан тохиолдолд худалдан худалдах авах гэрээний худалдагчийн хувиар төлөөлүүлэгчид мэдэгдсэний үндсэн дээр дуудлагаар худалдах эрхийг онолын хувьд эдэлнэ. Тухайлбал, Япон Улсын ХХ-ийн 556 болон 524-д комиссын дуудлагаар худалдах эрхийг хүлээн зөвшөөрсөн байна.

Гэвч Монгол Улсын ИХ-д төлөөлүүлэгчийн төлөө эзэмшиж комиссын бараа бүтээгдэхүүнийг саатуулан барих эрх болон дуудлагаа худалдан авах эрхийг зохицуулаагүй байна.

Үүрэг гүйцэтгэгч болох эрх

Комисс нь төлөөлүүлэгчийн төлөө өөрийн нэрийн өмнөөс бусадтай гэрээ хэлцэл байгуулах үйл ажиллагааг явуулдаг арилжаа эрхлэгч байдаг. Улмаар төлөөлүүлэгчийн төлөө өөртөйгөө гэрээ байгуулах боломжтой эсэх асуудал чухлаар тавигдана.

Төлөөлүүлэгчийн хувьд бараа бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа нь шударгаар явагдаж, түүний эрх ашиг зөрчигдөөгүй тохиолдолд гэрээний нөгөө тал хэн байх нь төдийлөн ач холбогдолгүй. Гэвч бодит байдал дээр комисс

нь өөртөө ашигтай үнийг тогтоох замаар төлөөлүүлэгчийн эрх ашгийг зөрчих эрсдэл үүсэх тохиолдолд гарах боломжтой.

Улмаар Герман болон Япон улсын ХХ нь бараа бүтээгдэхүүний үнийг тодорхойлох объектив зах зээл байгаа тохиолдолд комиссын зүгээс өөрөө үүрэг гүйцэтгэгч болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

Гэвч Монгол Улсын хувьд комиссын үүрэг гүйцэтгэгч болох эрхийн хүлээн зөвшөөрөөгүй тул энэ төрлийн харилцаанд худалдах, худалдан авах гэрээний ерөнхий зохицуулалт үйлчлэх эрх зүйн үр дагавар бий болохоор байна.

Хүснэгт 7. Комиссын эрхийн харьцуулсан судалгаа

№	Эрхийн төрөл	Монгол	Герман	Япон
1	Хөлс шаардах эрх	ИХ 415.5	ХХ 396.1	ХХ 512
	Зардал шаардах эрх	ИХ 416.2	ХХ 396.2	ИХ 649, 650
2	Саатуулан барих эрх	-	ХХ 397.1	ХХ 557, 31
3	Дуудлагаар худалдах эрх	-	ХХ 389.1	ХХ 556, 524
4	Үүрэг гүйцэтгэгч болох эрх	-	ХХ 400.1	ХХ 555.1

Комиссын үүрэг

Комисс нь мэргэшсэн арилжаа эрхлэгч болохын хувьд тухайн үйл ажиллагааны хүрээнд бусдын өмнө тодорхой үүрэг хүлээж байдаг.

Хянамгай байх үүрэг

Комисс нь комиссын үйл ажиллагаа явуулахдаа төлөөлүү-

лэгчийн өмнө даалгавар гүйцэтгэгчийн хувьд хянамгүй байх үүрэг хүлээнэ. Улмаар комисс нь төлөөлүүлэгчийн ашиг сонирхлын үүднээс ажиллаж, түүнээс өгсөн зааврыг баримтална.

Мөн шаардлагатай тохиолдолд бараа бүтээгдэхүүнийг хадгалах, худалдах, худалдан авах гэрээний талын эсрэг гэрээнээс татгалзах, хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах үүргийн хүлээнэ.

Мэдэгдэх үүрэг

Комисс нь төлөөлүүлэгчийн төлөө гэрээ байгуулсан тохиолдолд төлөөлүүлэгчид мэдэгдэх үүргийг хүлээнэ. Энэ нь даалгавар өгөгчийн шаардлагыг хүлээхгүйгээр холбогдох мэдээллийг олгох бие даасан үүрэг юм.

Япон Улсын ХХ-ийн 557.1 болон 27.1-д комиссын мэдэгдэх үүргийн талаар зохицуулсан бол Герман Улсын ХХ-ийн 384.1-д комисст мэдэгдэх үүрэг дээр нэмээд, тухайн арилжааны талаар тайлбарлах үүргийг хүлээлгэсэн байна.

Монгол Улсын хувьд ИХ-ийн 415.3-д “Комисс нь үйлчилүүлэгчийн заавраар түүний эрх ашиг, ердийн шаардлагад нийцүүлэн үүргээ гүйцэтгэж, үйлчилүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол улирал бүрийн сүүлчийн арав хоногт өөрийн үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний хөлс, шагналын тооцоо, комиссын төлбөрийн дүн зэргийг агуулсан тайланг үйлчилүүлэгчид гаргаж өгнө” хэмээн зохицуулжээ.

Тогтоосон үнээр худалдах, худалдан авах үүрэг

Төлөөлүүлэгч бараа бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах үнийг тогтоосон тохиолдолд түүнийг баримтлах үүргийг комисс хүлээнэ. Улмаар комиссын зүгээс тогтоосон үнээс хямд эсвэл өндрөөр худалдан авсан тохиолдолд төлөөлүүлэгч даалгаврыг зөрчсөн хэмээн үзэж болно. Энэ тохиолдолд төлөөлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх хариуцлага комисст үүсэж болно.

Харин комиссын зүгээс тогтоосон үнээс өндрөөр эсвэл хямдаар худалдан авсан тохиолдолд олсон ашиг нь төлөөлүүлэгчид хамаарна (ИХ-ийн 415.9). Энэхүү зарчим нь Герман болон Япон улсын хувьд ч адил байдлаар үйлчилнэ.

Монгол Улсын хувьд арилжааны түргэн шуурхай байдлыг хангах үүднээс комисс нь барааг үйлчлүүлэгчийн тогтоосон үнээс өөр үнээр худалдах тохиолдолд түүнд энэ тухай нэн даруй мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд үйлчлүүлэгч хариу өгөөгүй бол түүнийг зөвшөөрсөнд тооцно (ИХ-ийн 415.8) хэмээн зохицуулсан байна.

Үүргийн гүйцэтгэлийн хангах үүрэг

Комисс нь төлөөлүүлэгчийн төлөө хийсэн худалдах, худалдан авах үйл ажиллагааны үүргийг гэрээний нөгөө тал гүйцэтгээгүй тохиолдолд өөрөө үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээнэ. Герман Улсын ХХ-ийн 394-д комиссын үүргийн гүйцэтгэлийг хангах үүргийг хүлээн зөвшөөрснөөс гадна нэмэлт хөлс шаардаж болохоор зохицуулсан байна. Японы Улсын хувьд ХХ-ийн 553-д “талуудын хооронд өөрөөр тохиролцсон эсвэл өөр заншил байгаа тохиолдолд” комисс үүргийн гүйцэтгэлийг хангахгүй байж болохоор зохицуулжээ.

Харин Монгол Улсын хувьд комиссын үүргийн гүйцэтгэлийн хангах үүргийн талаар нарийвчлан зохицуулаагүй байна.

Хүснэгт 8. Комиссын үүрэг

№	Эрхийн төрөл	Монгол	Герман	Япон
1	Хянамгай байх үүрэг	ИХ 400.1	ХХ 384.1	ИХ 656, 644
2	Мэдэгдэх үүрэг	ИХ 415.3	ХХ 384.2	ХХ 557.1, 27.1

3	Тогтоосон үнээр худалдах үүрэг	ИХ 415.8	ХХ 386	ХХ 554.1
	Доголдлыг нөхөн төлөх үүрэг	-	ХХ 388.1	
4	Үүргийн гүйцэтгэлийн хангах үүрэг	-	ХХ 394.1, 394.2	ХХ 553.1

Комисс болон гэрээний талын харилцаа

Комисс нь өөрийн нэрийн өмнөөс бусадтай бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ байгуулах тул худалдах, худалдан авах гэрээний талын хувиар нөгөө талын өмнө эрх олж, үүрэг хүлээнэ. Улмаар худалдах, худалдан авах гэрээ байгуулагдах, түүний үйлчлэлийн хүрээнд яригдах хэлцэл хүчин төгөлдөр бус байх, хүчин төгөлдөр бусад тооцох асуудлууд нь төлөөлүүлэгч бус комиссын түвшинд үүснэ.

Энэхүү иргэний эрх зүйн зарчим нь Монгол, Герман, Японы улсын комиссын гэрээний хүрээнд нийтлэг байдлаар хэрэгжинэ.

Комисс болон төлөөлүүлэгчийн харилцаа

Комисс нь төлөөлүүлэгчийн даалгаварт үндэслэн өөрийн нэрийн өмнөөс бусадтай худалдах, худалдан авах гэрээ байгуулах тул худалдах, худалдан авах гэрээнээс үүдэх бүхий л эрх комисст үүснэ.

Төлөөлүүлэгч болон гэрээний талын харилцаа

Худалдааны комиссын үйл ажиллагаанд өөрийн нэрээр бусдын өмнөөс бараа бүтээгдэхүүнийг борлуулах, худалдан авах хэлцлийг хамааруулах бөгөөд Монгол Улсын ИХ-ийн 415-д зохицуулсан байна. Харин зарим оронд Худалдааны комиссын талаар Худалдааны хуулийн зохицуулалтаас гадна даалгавар

болон төлөөллийн зохицуулалт үйлчилдэг.⁴⁰

Эндээс үзэхэд Монгол Улсын ИХ-ийн худалдааны комиссын гэрээний зохицуулалтын хүрээнд комисс үүргийн гүйцэтгэлийг батлан даах, барьцааны эрхтэй байх, барааны доголдлын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

1.3.3. Комиссын гэрээний төр

Комиссын гэрээний түгээмэл хэлбэр нь үнэт цаасны брокерын гэрээ болон илгээмжийн гэрээ байдаг.

Үнэт цаасны брокерын гэрээ

Үнэт цаасны брокер нь өөрийн нэрийн өмнөөс бусдын зардлаар үнэт цаасыг худалдах, худалдан авах үйл ажиллагааг эрхэлдэг арилжаа эрхлэгч юм. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны брокер нь ИХ-д заасан комиссын сонгодог хэлбэр хэмээн хэлж болно.

Гэвч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.1-д “Харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавраар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэхийг үнэт цаасны брокерын үйл ажиллагаа /цаашид “брокерын үйл ажиллагаа” гэх/ гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Үүнээс үзвэл үнэт цаасны брокерын үйл ажиллагаанд хамаарах гэрээний төрлийг тодорхойлох боломжгүй байдлаар хуульчилсан байна. Бодит байдал дээр үнэт цаасны брокер нь төлөөлүүлэгчийн үнэт цаас худалдах, худалдан авах захиалгыг түүний зардлаар өөрийн нэрийн өмнөөс гүйцэтгэдэг.

⁴⁰ Япон Улсын Худалдааны хуулийн 552.2.

Цаашид үнэт цаасны брокерын харилцаа болон түүний гэрээний төрлийг онол болон практикийн үүднээс гүнзгийрүүлэн судалж, ИХ дахь нэрлэсэн гэрээний нийтлэг ангилалд нийцүүлэн тайлбарлах шаардлагатай юм.

Илгээмжийн гэрээ

Илгээмжийн гэрээ нь комиссын гэрээний тусгай төрөл юм. Өөрөөр хэлбэл, өөрийн нэрийн өмнөөс бусдын зардлаар ачаа, илгээмжийг тээвэрлэх зуучийн үйл ажиллагаа эрхлэгчийг илгээгч гэх бөгөөд зуучийн үйл ажиллагааг эрхэлдэг комисс хэмээн хэлж болно. Тухайлбал, Улаанбаатар хот дотор болон орон нутаг хоорондын бүх төрлийн хүргэлтийн үйлчилгээ нь гэрээний агуулгаас шалтгаан илгээмжийн гэрээнд хамаарах боломжтой. Мөн түргэн хоолны газар “Б” нь иргэн “А”-ийн хоол хүргүүлэх захиалгын дагуу хоолыг гэрт нь тээвэрлэгч “С”-ээр хүргүүлэх харилцаа нь илгээмжийн гэрээний сонгодог хэлбэр юм.

Тээвэр зуучийн компанийн зарим үйлчилгээ нь илгээмжийн гэрээнд хамаарах боломжтой. Тухайлбал, *www.shuukh.mn* сайтад бүртгэлтэй тээвэр зуучид холбогдох маргааны төлөөлөл болох тээвэрлүүлэгч “Х” ХХК болон тээвэр зуучлагч “Т” ХХК-тай байгуулсан “Тээвэр зуучийн үйлчилгээний гэрээ”⁴¹-г дурдаж болно.

“Тээвэр зуучлагч” гэдгийг Монгол Улсын MNS 5346:2003 стандартын 4.6-д *“тээвэрлүүлэгч, тээвэрлэгчдийн хооронд зуучлан үйлчилж байгаа этгээд”*⁴² хэмээн тодорхойлсон

⁴¹ Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №102/ШШ2016/01726 тоот шийдвэр.

⁴² Монгол Улсын стандарт “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ” MNS 5346:2017 стандарт, 2017.12.22-ны тоот тогтоол [<https://estandard.gov.mn/standard/reader/5560>]

байна. Энэхүү тээвэр зуучлагч нь ИХ-д зааснаар илгээгч гэх ойлголтыг илэрхийлнэ. Тээвэр зуучлагч нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Ачааг үйлчлүүлэгчээс хүлээн авах, тээврийн баримт бичгийг бүрдүүлэх, тээвэрлэлтэд бэлтгэх, тээвэрлүүлэхээр тээвэрлэгчид хүлээлгэн өгөх, хүлээн авагчид олгох;
- Ачааны хаяг солих;
- Ачаа илгээгч, хүлээн авагчид ачааны тээвэрлэлтийн явцын талаарх мэдээллийн үйлчилгээ;
- Ачааны гаалийн мэдүүлэг болон дагалдах баримт бичгийг бүрдүүлэх, гаальд мэдүүлэх, үүнтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх;
- Ачааны даатгалын зуучлалын үйлчилгээ;
- Ачааг агуулах болон гаалийн баталгаат агуулахад хадгалах үйлчилгээ;
- Бусад нэмэлт үйлчилгээ.

Улмаар тээвэр зуучийн харилцаа нь гэрээний агуулгаас шалтгаалан ИХ-ийн 407-409-д заасан илгээмжийн гэрээнд хамаарах боломжтой. Гэхдээ дийлэнх тохиолдолд тээвэрлэлтийн гэрээний шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, тээвэр зуучийн компани нь өөрийн гэсэн тээврийн хэрэгсэлгүй боловч бусадтай тээвэрлэлтийн гэрээ байгуулах замаар үйл ажиллагаа явуулдаг тээвэрлэгчид байж болно.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тус бүлэгт худалдааны зуучлагчийн гэрээний зохицуулалтыг хэрэглэж буй шүүхийн шийдвэр; худалдааны төлөөлөгчийн гэрээний зохицуулалтыг хэрэглэж буй шүүхийн шийдвэр; комиссын гэрээний зохицуулалтыг хэрэглэж буй шүүхийн шийдвэрийг ялган дүн шинжилгээ хийлээ.

2.1. ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧИЙН ГЭРЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Худалдааны зуучлагчийн гэрээний зохицуулалтыг хэрэглэж буй шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээг а). шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, б). дүгнэлт хэсэгт хуваан авч үзье.

2.1.1 Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

ИХ-ийн 413 дугаар зүйлд заасан худалдааны зуучлагчийн гэрээтэй холбоотой УДШ-ээр эцэслэн хянан шийдвэрлэгдсэн хэргийн шийдвэр (тогтоол)-ийг судалж, тэдгээрийн үндэслэлд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

www.new.shuukh.mn вэбсайтаас 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр “Иргэний хуулийн 413 дугаар зүйл” түлхүүр үгээр хайлт хийхэд нийт 10 шийдвэр гарч ирсэн. Үүнээс холбогдолгүй болон давхардсан 4 шийдвэрийг хасаж⁴³ үлдсэн дараах 6 шийдвэрт дүн шинжилгээ хийв. Үүнд:

	Дугаар	Шүүх	Нэхэмжлэгч	Хариуцагч
2019.05.31	001/ ХТ2019/00834	УДШ	“Х” ХХК	“Т” ХХК
2018.03.06	№001/ ХТ2018/00374	УДШ	“Т” ХХК	“Н” ХХК, “Т” ХХК
2017.03.28	001/ ХТ2017/00351	УДШ	“Пролог солюшн” ХХК	“АТА трейд” ХХК
2017.03.28	001/ ХТ2017/00353	УДШ	“Альфа транс” ХХК	“Цайны зам трейд” ХХК
2017.01.31	001/ ХТ2017/00101	УДШ	“Сео Жүүн Ложистикс” ХХК	“Киа моторс Монгол” ХХК
2016.06.28	001/ ХТ2016/00841	УДШ	“Сео Жүүн Ложистикс” ХК	“Хьюндай Моторс Монгол” ХХК

Эх сурвалж: New.shuukh.mn

⁴³ 2018.03.06-ны өдрийн №001/ХТ2018/00374, 2019.02.14-ний өдрийн №001/ХТ2019/00209 шийдвэрүүд нь давхардсан тул хасав. 2019.06.14-ний өдрийн №001/ХТ2019/00933 тоот шийдвэр нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нэхэмжилсэн, 2016.09.24-ний өдрийн №001/ХТ2016/00966 тоот шийдвэр нь зээлийн төлбөртэй холбогдох маргаан байх тул энэ судалгааны ажлын хүрээнд хамааралгүй гэж үзэж хасав.

**А. “Х”-д холбогдох залилангийн хэргийн тухай УДШ,
2019.05.31 №001 тоот тогтоол (ХТ2019/00834)**

Хэргийн товч агуулга:

“Х” ХХК нь улс хоорондын тээврийн зуучийн үйл ажиллагаа эрхэлдэг “Т” ХХК-тай тээвэр зуучийн гэрээ байгуулж, Австрали улсын Черч энд Двайт (Church & Dwight) компаниас 29 нэр төрлийн нийт австрали долларын үнэ бүхий барааг “Т” ХХК-аар тээвэрлүүлэхээр тохиролцсон байна. Гэвч бараа нь хугацаандаа ирээгүй тул “Х” ХХК нь хохирлоо нэхэмжилсэн байна.

Үйл баримтын хүрээнд талуудын хооронд байгуулсан 2014 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн ТЗ/6/14/45 тоот тээвэр зуучийн үйлчилгээний гэрээ, бараа, сав баглаа боодол, үнийн жагсаалт, мөнгө шилжүүлсэн баримтууд, талууд хоорондоо харилцаж байсан цахим шуудан буюу түүнд үзлэг хийсэн тэмдэглэл, цахим шуудангийн орчуулга зэрэг баримт хэрэгт авагдсан байна.

Шийдвэрийн агуулга:

Уг маргаан нь анхан шатны шүүхээр 2 удаа, давж заалдах шатны шүүхээр 2 удаа орж, хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Уг маргаанд холбогдох 5 шийдвэр⁴⁴-ийг дараах байдлаар сийрүүлэв. Үүнд:

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн №1471 тоот шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бөгөөд талуудын хооронд үүссэн харилцааг ИХ-ийн 413.1-д заасан худалдааны зуучлагчийн гэрээний харилцаа гэж үзжээ.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн

⁴⁴ Шийдвэр, магадлал, тогтоолыг нэгтгэн “шийдвэр” гэж дурдав.

2018 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн №210/МА2018/01905 тоот магадлалаар анхан шатны шүүх нотлох баримтыг бүрдүүлэх ажиллагааг дутуу хийсэн гэж үзэн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцааны төрлийг тодорхойлж дүгнэлт хийгээгүй.

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №181/ШШ2018/02447 тоот шийдвэрээр барааны үнэ болох австрали доллар буюутөгрөгийг “Т” ХХК-аас гаргуулж, “Х” ХХК-д олгох, олох байсан орлогыг бодит хохирол гэж үзэх боломжгүй, нотолсон баримтгүй тул хэрэгсэхгүй болгожээ. Ийнхүү шийдвэрлэхдээ талуудын хоорондох гэрээ нь нэг талаас “Т” ХХК нь захиалгын дагуу заасан тээврийн замналаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж гарах импорт, экспорт, дамжин өнгөрөх усан, хуурай болон агаарын замаар ачаа тээврийн зуучийн үйлчилгээ үзүүлэхээр, нөгөө талаас “Х” ХХК нь тохирсон хөлс төлөхөөр тохиролцсон байх тул ИХ-ийн 380.1-д нийцсэн, хүчин төгөлдөр тээвэрлэлтийн гэрээ байна гэж үзсэн.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн №218 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Ийнхүү шийдвэрлэхдээ талуудын хооронд ИХ-ийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн талаар анхан шатны шүүх зөв дүгнэсэн гэж үзжээ.

Харин хяналтын шатны шүүх хоёр шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бодитой харьцуулан үзсэний үндсэн дээр, тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлж, маргааны үйл баримтын талаар үндэслэлтэй дүгнэсэн боловч зохигчдын хоорондох эрх зүйн харилцааны төрлийг зөв тодорхойлоогүй байна. Зохигч нь 2014 оны 10 дугаар сарын 8-ны өдөр тээвэр

зуучийн үйлчилгээний гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээнд нэхэмжлэгч “Х” ХХК нь үйлчлүүлэгч, хариуцагч “Т” ХХК нь зуучаар оролцжээ.

“Т” ХХК нь нэхэмжлэгчийн захиалгын дагуу түүний ачааг тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, тээвэрлэгчтэй зохих гэрээг байгуулах, шаардлагатай төлбөр тооцоо, тохиролцоог хийх үүрэг хүлээсэн, харин өөрөө тээвэрлэлтийг хийх үүргийг хүлээгээгүй байхад хоёр шатны шүүх зохигчийн хооронд үүссэн эрх зүйн харилцааг тээвэрлэлтийн гэрээнийх гэж дүгнэсэн нь алдаатай болжээ.

ИХ-ийн 380.1-д зааснаар тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь зорчигч буюу ачаа, тээшийг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээдэг бол хуулийн 410.1-д заасан зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөх үүргийг тус тус хүлээдэг.

ИХ-ийн 413.1-д зааснаар аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдах-худалдан авах, даатгал, тээвэр, эд хөрөнгө хөлслөх, эсвэл худалдааны бусад үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээдэг.

Хариуцагч “Т” ХХК нь аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд тээвэр зуучлал явуулдаг байх тул түүнийг худалдааны зуучлагч гэж үзэхээр байна.

Шүүх хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн зохигчийн хооронд ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын дагуу тээвэр зуучийн захиалга өгсөн, худалдах-худалдан авах гэрээний худалдагч тал тээвэр зуучийн зөвлөсөн байгууллага, хаягаар ачааг илгээсэн гэж үзжээ. Улмаар тээвэр зууч

ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй гэж үзэж, барааны үнэ австрали доллар буюутөгрөгийг хариуцагчаас гаргуулж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн нь ИХ-ийн 413.1 болон 219.1-д заасан шаардлагад нийцжээ хэмээн дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Энэ төрлийн гэрээний маргааныг шийдвэрлэхэд гэрээний төрлийг буюу талууд хооронд үүссэн харилцааг зөв тодорхойлох нь чухал ач холбогдолтой байдаг. Гэвч уг маргаанд холбогдох шүүхийн 5 шийдвэрийг авч үзвэл маргааны үйл баримтыг бүрэн тогтоогүйгээс шалтгаалан шүүхийн шийдвэрийн агуулга өөр хоорондоо зөрүүтэй байна. Тухайлбал,

- Анхан шатны шүүхээс ИХ-ийн 413.1-д заасан худалдааны зуучлагчийн гэрээний харилцаа үүссэн;
- Давж заалдах шатны шүүхээс талуудын хооронд үүссэн гэрээний харилцааг тодорхойлоогүй;
- Анхан шатны шүүхээс ИХ-ийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн;
- Давж заалдах шатны шүүхээс ИХ-ийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн;
- Хяналтын шатны шүүхээс ИХ-ийн 413.1-д заасан худалдааны зуучлагчийн гэрээний харилцаа үүссэн хэмээн үзжээ.

Улмаар хяналтын шатны шүүхээс энэ маргааныг эцэслэн хянан шийдвэрлэхдээ ИХ-ийн 413.1-д заасан хоёр этгээдийн хооронд гэрээ байгуулахад нь холбож өгсөн буюу худалдааны зуучлагчийн зохицуулалтыг үндэслэн шийдвэрлэжээ.

Маргаан бүхий харилцааг авч үзвэл, нэг талаас “Х” ХХК нь тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдтэй холбуулах бус,

харин өөрийн худалдан авсан барааг Австрали Улсаас Монгол Улсад дамжин өнгөрөх усан, хуурай болон агаарын замаар тээвэрлүүлэн авчрах, тус улсын нутаг дэвсгэрт оруулж ирэх импортын харилцааг бүхэлд нь “Т” ХХК-аар зохион байгуулж гүйцэтгүүлэх, нөгөө талаас “Т” ХХК нь уг үйл ажиллагааг Австрали дахь тээврийн компанитай өөрийн нэрээр гэрээ байгуулж, гүйцэтгэхээр тохиролцсон байна.

Үүнээс үзвэл, “Х” ХХК болон тээвэр зуучлагч “Т” ХХК нарын хооронд ИХ-ийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээ, эсвэл “өөрийн нэрийн өмнөөс, бусдын зардлаар” гэрээ байгуулсан буюу талуудын хооронд ИХ-ийн 407.1-д заасан илгээмжийн гэрээний харилцаа үүссэн байх боломжтой байна. Тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч ачаа тээшийг тогтоосон газарт хүргэх үүргийг хүлээх боловч заавал өөрөө гүйцэтгэх шаардлагагүй буюу бусдаар гүйцэтгүүлэх боломжтой байдаг. Ялангуяа тээвэр зуучийн үйл ажиллагааны онцлог нь бусдын тээврийн хэрэгслийн тусламжтайгаар тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдагт оршино. Гэвч шүүхээс үйл баримтыг хангалттай тогтоолгүйгээр тээвэрлүүлэгч “Х” ХХК болон тээвэрлэгч хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулахад зуучлахад чиглэсэн худалдааны зуучлалын гэрээ гэж дүгнэсэн нь үндэслэлтэй муутай байна.

Тээвэрлэлтийн гэрээ болон илгээмжийн гэрээ нь хоёр этгээдийн хооронд гэрээ байгуулахад нь холбож өгөх агуулга бүхий худалдааны зуучлагчийн гэрээнээс ялгагддаг. Дээрхээс дүгнэвэл, шүүхүүд ямар талуудын хооронд ямар төрлийн гэрээ байгуулсан эсэх, ингэхдээ гэрээний аль тал зардал гаргасан эсэх талаарх үйл баримтыг хангалттай тодорхойлохгүй байгаагаас шалтгаалан гэрээний төрлийг зөвөөр тогтоож чадахгүй байна.

**Б. “Н” ХХК-д холбогдох УДШ, 2018.03.06, №001 тоот тогтоол
(ХТ2018/00374)⁴⁵**

Хэргийн товч агуулга:

“Н” ХХК нь “Т” ХХК-тай тээвэр зуучийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулж, уг гэрээний хүрээнд 2014 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс 2014 оны 7 дугаар сарын 29-ний хооронд 11 чингэлэг ачааг тээвэрлүүлэн хүлээн авчээ.

Мөн “Н” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн “Г” ХХК-ийн барааг түүний өмнөөс өөрийн нэрээр “Т” ХХК-аар гадаадаас тээвэрлүүлдэг байсан. 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдөр “Г” ХХК нь захиалсан бараагаа хүлээн авахад 1257 хайрцаг ачаа замдаа алдагдаж ирсэн тул алдагдсан бяслагийн үнэ болон учирсан хохирол нийт еврог “Т” ХХК-аас нэхэмжилж шаардсан. “Т” ХХК шаардлагыг биелүүлээгүй учраас “Н” ХХК нь 2014 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс “Т” ХХК-аар хийлгэсэн тээвэрлэлтийн хөлснөөс дээрх хохирлыг суутган авсан. Улмаар “Т” ХХК нь шүүхэд хандаж, “Н” ХХК-аас 2014 оны 7 дугаар сарын 3-29-ны өдрийн хооронд тээвэрлүүлэн хүлээн авсан 11 чингэлэг ачаа, түүнчлэн “Г” ХХК-аас “Н” ХХК-ийн нэрээр тээвэрлүүлсэн 3 чингэлэг ачааны тээвэрлэлт, зуучлалын хөлс, алдангийг тус тус нэхэмжилжээ.

“Н” ХХК, “Г” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй. “Г” ХХК нь шаардах эрхээ “Н” ХХК-д шилжүүлсэн гэх үндэслэлээр “Н” ХХК нь алдагдсан бяслагийн үнэ, олох ёстой байсан ашиг, нийт төгрөгийг “Т” ХХК-аас шаардаж сөрөг нэхэмжлэл гаргасан байна.

⁴⁵ 2018.03.06-ны өдрийн №001/ХТ2018/00374 тоот тогтоолоор хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаажээ. Улмаар энэ хэргийг дахин хэлэлцэж, Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2019.04.09-ний өдрийн №001/ХТ2019/00498 тоот тогтоолоор эцэслэн хянан шийдвэрлэгдсэн. Иймд тус хэргийг дахин хэлэлцсэн 3 шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн болно.

Үйл баримтын хүрээнд, “Т” ХХК, “Н” ХХК-ийн хооронд 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан “Ачаа тээврийн зуучлалын гэрээ”, уг гэрээгээр “Н” ХХК нь “Т” ХХК-д тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх онцгой эрх олгох, тээврийн хөлсний төлбөр тооцоог зуучлагчийн нэхэмжлэхийн дагуу тухайн нэхэмжлэхэд заасан валютаар барагдуулна, уг гэрээний дагуу “Н” ХХК нь өөрийн бараанаас гадна хувьцаа эзэмшигч “Г” ХХК-ийн өмнөөс тус компанийн барааг гадаадаас тээвэрлүүлэх захиалгыг “Т” ХХК-д өгч, ачааг тээвэрлүүлж байсан зэрэг баримт хэрэгт авагдсан байна.

Шийдвэрийн агуулга:

Уг маргаан нь анхан шатны шүүхээр 2 удаа, давж заалдах шатны шүүхээр 2 удаа, хяналтын шатны шүүхээр 2 удаа хянан шийдвэрлэгджээ. Улмаар уг маргаантай холбоотой шүүхийн 6 шийдвэр⁴⁶ гарсан байна. Үүнд:

1. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 9 дугаар сарын 5-ны өдрийн №02363 тоот шийдвэрээр шүүх үндсэн нэхэмжлэлийн шаардлагаас зарим хэсгийг хангаж, үлдэх хэсэг болон сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Гэрээний дагуу “Т” ХХК нь “Н” ХХК-ийн захиалгын дагуу импортын ачааны тээвэрлэлтийг зохион байгуулах, тээвэр зуучлалын иж бүрэн үйлчилгээ үзүүлэх, түүний хүсэлтийн дагуу хамгийн тохиромжтой богино, хугацаа бага зарцуулах тээврийн замнал, үйлчилгээний үнэ тарифыг “Н” ХХК-д санал болгох, тээвэрлэлттэй холбоотой зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, “Н” ХХК нь тээврийн хөлсийг “Т” ХХК-ийн нэхэмжлэлийн дагуу гадаад валютуудад төлөх үүрэг тус тус үүссэн. Гэрээний зүйл, шинж, талуудын эрх үүрэг, төлбөр төлөх нөхцөл

⁴⁶ Шийдвэр, магадлал, тогтоолыг нэгтгэн “шийдвэр” гэж дурдав.

зэргээс үзвэл талуудын хооронд ИХ-ийн 413.1-д заасан тээвэр зуучлалын харилцаа үүссэн гэж үзэх үндэслэлтэй гэж дүгнэсэн. Мөн “Т” ХХК болон “Н” ХХК-ийн хооронд гэрээ байгуулсан боловч “Г” ХХК нь өөрийн нэрээр ачаа тээвэрлүүлсэн үйл баримтыг талууд үгүйсгээгүй байх тул “Т” ХХК болон “Г” ХХК-ийн хооронд мөн хуулийн 413.1-д заасан гэрээний харилцаа үүссэн гэж үзсэн.

2. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн №2307 тоот магадлалаар нэхэмжлэлийн шаардлагын холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөхөөр шийдвэрлэсэн. Ингэхдээ “Т” ХХК нь “Н” ХХК-аас ачаа тээвэрлүүлсэн тээврийн хөлсийг ИХ-ийн 380.1-д заасны дагуу, “Н” ХХК-ийн барааг дотоодод тээвэрлэж ирэх, гадаадын тээврийн компанитай холбож өгөхөд зуучилсан зуучлалын хөлсийг 410.1-д заасны дагуу тус тус шаардсаныг анхан шатны шүүх Иргэний хуулийн 413.1-д заасан худалдааны зуучлалын гэрээ байгуулсан хэмээн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзэн залруулж, шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулсан. Сөрөг нэхэмжлэлийн тухайд, “Г” ХХК нь “Н” ХХК-д гэрээний үндсэн дээр шаардах эрх шилжүүлсэн нь хууль зөрчөөгүй тул ачаа алдагдсантай холбоотой хохирлыг тээвэрлэгчээс шаардах эрх “Н” ХХК-д байна. ИХ-ийн 393.1-д заасны дагуу “Т” ХХК нь алдагдсан ачааны үнийг өөрт учирсан хохиролд тооцон “Т” ХХК-аас шаардах эрхтэй гэжээ.
3. Хяналтын шатны шүүхийн 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн №001/ХТ2018/00374 тоот тогтоолоор шийдвэр, магадлал нь хуульд заасан хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй гэж дүгнэжээ. Анхан шатны шүүх зохигчдын хооронд худалдааны зуучлалын

харилцаа үүссэн гэж үзсэн боловч хэрэгт авагдсан баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлж чадаагүй, уг алдааг давж заалдах шатны шүүх залруулж зөвтгөөгүй нь ИХШХШТХ-ийн 40.1, 40.2-т нийцээгүй. Иймд үндсэн ба сөрөг нэхэмжлэлийн шаардлагын талаар дүгнэлт хийж хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй байх тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах нь зүйтэй гэж үзсэн.

4. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн №102/ПШ2018/02700 тоот шийдвэрээр үндсэн болон сөрөг нэхэмжлэлийн шаардлагын холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. “Т” ХХК нь ХБНГУ-аас “Н” ХХК-ийн бараа бүтээгдэхүүнийг Монгол улс руу тээвэрлэхэд гадаадын тээврийн компанитай холбон зуучлах, ачаа барааг тээвэрлүүлэх, тээвэрлүүлсэн ачаа барааг тохиролцсон газар хүргэх үүрэг хүлээж, “Н” ХХК нь тээвэр зуучлалын хөлс төлөх үүрэг хүлээхээр харилцан тохиролцож хүсэл зоригоо илэрхийлсэн нь ИХ-ийн 410.1-д заасан зуучлалын гэрээ байна гэж үзсэн. Харин сөрөг нэхэмжлэлийн тухайд, “Т” ХХК нь “Т” ХХК-ийн захиалгын дагуу импортын ачааны тээвэрлэлтийг зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн талаар талууд маргахгүй бөгөөд “Т” ХХК-аас тээвэрлэлтийн хөлс гаргуулахаар шаардаж байгаа учир тэдний хооронд тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн гэж үзэх үндэслэлтэй. Иймд алдагдсан ачааны үнийг “Н” ХХК нь “Т” ХХК-аас шаардах эрхтэй гэж дүгнэжээ.
5. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн №2342 тоот магадлалаар үндсэн нэхэмжлэлийн шаардлагын холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны

шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. ИХ-ийн 198.1-д зааснаар гэрээний агуулгыг тайлбарлахдаа үгийн шууд утгыг анхаарах боловч уг гэрээнд гэрээний нэг тал нөгөө талын бараа бүтээгдэхүүнийг гадаад улсаас тээвэрлэн ирэх зохион байгуулалтыг хангах, нөгөө тал нь тээвэрлэлтийн хөлс төлөх үүрэг хүлээсэн байна. Анхан шатны шүүх үндсэн нэхэмжлэлийн талуудын хооронд тээвэрлэлтийн гэрээний үүргийн харилцаа үүссэн талаар зөв тодорхойлсон байна. Харин “Т” ХХК нь “Г” ХХК-ийн захиалгын дагуу импортын ачааны тээвэрлэлтийг зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн талаар талууд маргахгүй бөгөөд “Г” ХХК-аас тээвэрлэлтийн хөлс гаргуулахаар шаардаж байгаа учир тэдний хооронд тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн гэж үзэх үндэслэлтэй гэж үзжээ.

6. Хяналтын шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн №001/ХТ2019/00498 тоот тогтоолоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Гэсэн хэдий ч тогтоолын “хянавал” хэсэгт анхан шатны шүүхийн шийдвэрт тусгагдаагүй нэмэлт хууль зүйн үндэслэлийг тусгажээ. Тодруулбал, “Т” ХХК болон “Н” ХХК-ийн хооронд тээвэрлэлтийн болон зуучлалын гэрээ байгуулсан гэж үзсэн. Шүүх нэхэмжлэгчийг тээвэрлэгч гэж дүгнэн, алдагдсан барааны үнийг хариуцуулсан нь ИХ-ийн 380 дугаар зүйлийн 1, 393.1 дэх заалтад нийцсэн гэж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Уг маргаанд холбогдох шүүхийн 6 шийдвэрийг авч үзвэл шүүхээс “Т” ХХК болон “Н” ХХК-ийн хооронд үүссэн харилцаанд үндэслэн гэрээний төрлийг зөрүүтэй байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал,

- Анхан шатны шүүхээс ИХ-ийн 413.1-д заасан худалдааны зуучлагчийн гэрээний харилцаа үүссэн;
- Давж заалдах шатны шүүхээс ИХ-ийн 380.1, 410.1-д заасан тээвэрлэлтийн болон зуучлалын гэрээний харилцаа үүссэн;
- Хяналтын шатны шүүхээс талуудын хооронд үүссэн гэрээний харилцааг тодорхойлоогүй;
- Анхан шатны шүүхээс үндсэн нэхэмжлэлийн талуудын хооронд ИХ-ийн 410.1-д заасан зуучлалын гэрээний харилцаа, сөрөг нэхэмжлэлийн талуудын хооронд ИХ-ийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн;
- Давж заалдах шатны шүүхээс талуудын хооронд ИХ-ийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээ харилцаа үүссэн;
- Хяналтын шатны шүүхээс үндсэн нэхэмжлэлийн талуудын хооронд ИХ-ийн 410.1-д заасан зуучлалын гэрээний харилцаа, сөрөг нэхэмжлэлийн талуудын хооронд ИХ-ийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн хэмээн үзжээ.

Үүнээс үзвэл анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүд талуудын хооронд үүссэн гэрээний төрлийг ялгаатай байдлаар тодорхойлсон байна.

Маргаан бүхий харилцааны хүрээнд авагдсан үйл баримтуудыг судлан үзэхэд “Т” ХХК нь захиалгын дагуу импортын ачааны тээвэрлэлтийг зохион байгуулж гүйцэтгэх, тээвэр зуучлалын иж бүрэн үйлчилгээ үзүүлэх, хүсэлтийн дагуу хамгийн тохиромжтой богино, хугацаа бага зарцуулах тээврийн замнал, үйлчилгээний үнэ тарифыг санал болгох, тээвэрлэлттэй холбоотой зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, нөгөө тал нь зохих хөлсийг төлөхөд чиглэсэн харилцаа үүсжээ. Энэ харилцаа нь гэрээний агуулга, үйл баримтаас шалтгаалан

тээвэрлэлтийн гэрээ эсвэл илгээмжийн гэрээний төрөлд хамаарах боломжтой.

Тухайлбал, талуудын хооронд үүссэн харилцаа нь “Н” ХХК нь өөрийн нэрийн өмнөөс “Г” ХХК-тай бараа тээвэрлэлтийн гэрээ байгуулж, “Г” ХХК-ийн өмнө тээвэрлэгчийн хариуцлага хүлээхэд чиглэсэн байж болно. Энэ төрлийн гэрээний харилцааг тодорхойлоход өөрийн нэрийн өмнөөс гэрээ байгуулсан эсэх, хэний зардлаар гэрээ байгуулж буй эсэх нь онцгой ач холбогдолтой баримт байх боловч шүүхээс дүн шинжилгээ хийгээгүй байгаа нь маргааны хүрээнд гэрээний төрлийг тодорхойлоход хүндрэл учруулж байна.

В. “С” ХК-д холбогдох УДШ, 2017/01/31, №001 тоот тогтоол (ХТ2017/00101)

Хэргийн товч агуулга:

БНСУ-ын “С” ХК болон “К” ХХК нь 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр №13/17-13/36 тоот гэрээнүүдийг тус тус байгуулж, эдгээр 20 гэрээний дагуу “С” ХК нь “К” ХХК-ийн ачааг БНСУ-аас зуучлан тээвэрлэсэн. Талууд тээвэрлэлтийн төлбөрийг ачаа хүргэх газар (Монгол Улс)-т ирэхээс өмнө бүрэн төлсөн байхаар гэрээгээр харилцан тохиролцсон боловч “К” ХХК нь гэрээнд заасан энэхүү үүргээ биелүүлээгүй. Иймд “С” ХК нь “К” ХХК-ийн тус компаниар зуучлуулж тээвэрлүүлсэн хөлсам.доллар буюу төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжийн хамт “К” ХХК-аас гаргуулахаар нэхэмжилсэн. “К” ХХК нь “С” ХК-ийн нэхэмжилсэн ам долларын нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн боловч ам.долларыг төгрөгт хөрвүүлэхдээ тээвэрлэлт хийгдсэн тухайн үеийн ханшаар нь тооцох ёстой гэж маргасан.

Үйл баримтын хүрээнд “С” ХК болон “К” ХХК-ийн хооронд

2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан №13/17-13/36 дугаартай нийт 20 ширхэг “Тээвэр зуучийн гэрээ”, үлдэгдэл төлбөрийн хэмжээг талууд харилцан хүлээн зөвшөөрч баталгаажуулсан тухай 2015 оны 10-р сарын 21-ний өдрийн №15/6 дугаартай тооцоо нийлсэн акт зэрэг хэрэгт авагдсан байна.

Шийдвэрийн агуулга

Анхан шатны шүүхээс нэхэмжлэгч ИХШХШХ-ийн 63.2-т заасны дагуу нэхэмжлэлийн үнийг тогтоохдоо гадаад валютын ханшийг нэхэмжлэл гаргах үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцсон нь хуульд нийцэж байна гэж үзсэн. Хариуцагч “К” ХХК нь тээвэрлэлт хийгдсэн тухайн үеийн ханшаар тооцох ёстой гэж маргасан нь үндэслэлгүй гэжээ. Хариуцагч “К” ХХК нь нэхэмжлэгч “С” ХК-д ам.доллар буюутөгрөгийг төлөх үүрэгтэй болох нь хавтаст хэрэгт авагдсан 2013 оны 12-р сарын 30-ны өдөр байгуулагдсан 13/17-13/36 дугаартай Тээвэр зуучийн гэрээнүүд, 2015 оны 10-р сарын 21-ний өдрийн №15/6 дугаартай тооцоо нийлсэн акт болон бусад бичгийн баримтуудаар тогтоогдож байх тул нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэх үндэстэй гэж үзжээ.

Улмаар ИХ-ийн 413.1-т заасныг баримтлан “К” ХХК-аасам доллар буюутөгрөгийг гаргуулан “С” ХК-д улсын тэмдэгтийн хураамжийн хамт олгуулахаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.⁴⁷

Хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзсэн. Анхан болон давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх хуулиар тогтоосон журмыг

⁴⁷ “С” ХК-ийн нэхэмжлэлтэй “К” ХХК-д холбогдох Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.07.29-ний өдрийн №181/ШШ2016/00407 тоот шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.11.11-ний өдрийн №1855 тоот магадлалтай.

зөрчөөгүй, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн гэх хяналтын шатны шүүхэд гомдол гаргах хуульд заасан үндэслэлийн алиныг нь ч зөрчөөгүй байна гэж дүгнэжээ.

Дүн шинжилгээ

Шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ талуудын хооронд үүссэн эрх үүргийн харилцаа, үйл баримтыг зөв тодорхойлсноор талуудын хооронд байгуулагдсан гэрээний төрлийг тогтоох, улмаар нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэхийг шийдвэрлэх боломжтой. Гэтэл гурван шатны шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхдээ талуудын хооронд ямар төрлийн гэрээний харилцаа үүссэн болохыг тодорхойлж, дүгнэлт хийгээгүй.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт ИХ-ийн 413.1-ийг баримталсан талаар дурдагджээ. ИХ-ийн 198.1-т зааснаар, гэрээг тайлбарлахдаа түүний үгийн шууд утгыг агуулах боловч тухайн гэрээгээр зохицуулж буй харилцааны агуулгаар гэрээний төрлийг тодорхойлно.

Талуудын хооронд үүссэн гэрээний харилцааг үнэлбэл “С” ХК нь “К” ХХК-ийг зөвхөн БНСУ-аас ачаа тээвэрлэх тээврийн компанитай холбож өгөх бус, Монгол Улсад ачаа тээвэрлэгдэн ирэх хүртэлх тээвэрлэлтийг зохион байгуулж, өөрийн нэрээр тээвэрлэгчтэй гэрээ байгуулах үүргийг давхар хүлээсэн гэж үзэхээр байна.

Иймд тээвэр зуучлагч нь “өөрийн нэрийн өмнөөс, бусдын зардлаар” гэрээ байгуулсан буюу гэрээний талуудын хооронд ИХ-ийн 407.1-т заасан илгээмжийн гэрээ, эсхүл тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан байх боломжтой байна.

**Г. “А”-д холбогдох УДШ, 2017.03.28, №001 тоот тогтоол
(ХТ2017/00353)**

Хэргийн товч агуулга:

“Ц” ХХК нь “А” ХХК-тай тээвэр зуучийн гэрээ байгуулж, Гүрж Улсаас ногоон цай тээвэрлүүлэхээр тохиролцсон байна. Гэвч “Ц” нь төлбөрийг төлөөгүй тул төлбөр болон алдангиа гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. “Ц” ХХК нь үлдэгдэл төлбөрийг төлөхийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд алдангийн хувь хэмжээг багасгуулахаар хүсэлт гаргажээ.

Үйл баримтын хүрээнд “А” ХХК Гүрж Улсаас Монгол Улс хүртэлх ногоон цайны тээврийг амжилттай зохион байгуулж, гэрээний үүргийг тогтоосон газарт, хугацаанд нь, зохих ёсоор хангасан болох нь тогтоогдсон.

Шийдвэрийн агуулга:

Анхан шатны шүүхээс талуудын хооронд байгуулагдсан гэрээ нь ИХ-ийн 410.1-т заасан шаардлагыг хангасан зуучлалын гэрээ байх бөгөөд гэрээний хугацаанд “А” ХХК нь гэрээгээр тохирсон зуучлалын үүргийг гүйцэтгэсэн байна гэж үзсэн. Түүнчлэн талуудын байгуулсан гэрээний 3.4-т тохиролцсон байх тул нэхэмжлэгч алданги шаардах эрхтэй бөгөөд алдангийг багасгах үндэслэл тогтоогдохгүй байна гэжээ. Улмаар ИХ-ийн 410.1, 232.6-г баримтлан “Ц” ХХК-аастөгрөг гаргуулан “А” ХХК-д олгох, ханшийн зөрүүний улмаас илүү нэхэмжилсэн хэсгийг хэрэгсэхгүй болгуулахаар шийдвэрлэсэн.

Харин давж заалдах шатны шүүхээс талуудын хооронд байгуулагдсан гэрээний нэр томьёо, талуудын хүлээх эрх, үүрэг, гэрээний зорилго, агуулга зэргээс үзэхэд нэхэмжлэгч нь үйлчлүүлэгч буюу хариуцагчаас бичиг баримт мэдээллийг авч, түүний нэрийн өмнөөс тээвэрлэгч байгууллагатай холбож, гэрээ байгуулж, тээвэрлэлтийн бүх явцыг зохион байгуулан хянаж, шаардлагатай мэдээллээр хариуцагчийг хангаж,

терминал, гаалийн хяналтын талбайд буусан барааны бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийг гаргуулахгүй байх арга хэмжээ авч, хариуцагчийг байлцуулан гаалийн бүрдүүлэлт, шалгалтад ороход туслалцаа үзүүлсэн нь тээвэрлэлтийн гэхээс илүүгээр тээвэрлэлт хийх этгээдтэй холбож өгөх, хэлцлийг амжилттай хэрэгжихэд нэмэлт үйлчилгээ үзүүлэн, зохион байгуулах шинжтэй холимог маягийн гэрээ байна. Иймд талуудын хооронд ИХ-ийн 410.1-т заасан зуучлалын гэрээ байгуулагдсан гэж дүгнэсэн анхан шатны шүүхийн дүгнэлтийг буруутгах боломжгүй байна гэжээ. Улмаар алданги тооцох хоногийг багасгаж, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.⁴⁸

Харин хяналтын шатны шүүхээс дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

“Ц” ХХК-ийн захиалгаар экспорт, импортын тээвэр зуучийн үйлчилгээ үзүүлэх, “Ц” ХХК нь үйлчилгээний хөлс төлөх үүрэг хүлээсэн нь ИХ-ийн 410.1-д заасан зуучлалын гэрээний зохицуулалтад нийцжээ. ИХ-ийн 410.1-д зааснаар зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөх үүргийг тус тус хүлээдэг.

ИХ-ийн 413.1-д зааснаар аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдах худалдан авах, даатгал, тээвэр, эд хөрөнгө хөлслөх, эсхүл худалдааны бусад үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээдэг тул нэхэмжлэгч “А” ХХК-ийг худалдааны зуучлагч гэж үзэх үндэслэлтэй юм.

⁴⁸ “А” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Ц” ХХК-д холбогдох Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.10.10-ны өдрийн №00899 тоот шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.12.09-ний өдрийн №210/МА2016/2020 тоот магадлал.

Дээрх гэрээний 3.4-т үйлчлүүлэгч хугацаандаа хөлсөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувийн алданги төлөхөөр талууд тохиролцсон нь ИХ-ийн 232.6-д заасан зохицуулалтад нийцжээ. Нэхэмжлэгч “А” ХХК хариуцагчаас гэрээний үүргийн биелэлтэдам.доллар, алдангид ам.доллар гаргуулахаар шаардсаныг анхан шатны шүүх ИХ-ийн 410.1, 232.6-д зааснаар хангасан нь хууль зүйн үндэслэлтэй болжээ.

Дүн шинжилгээ:

Анхан шатны шүүх талуудын хооронд ИХ-ийн 410.1-т заасан зуучлалын гэрээний харилцаа үүссэн гэж үзсэн. Давж заалдах шатны шүүхээс талуудын хооронд үүссэн харилцаа нь зөвхөн хоёр этгээдийн хооронд гэрээ байгуулахад нь холбож өгөх төдий бус, үүнээс гадна хэд хэдэн агуулгыг хамарсан гэж үзсэн атлаа талуудын хооронд ИХ-ийн 410.1-т заасан зуучлалын гэрээ байгуулагдсан хэмээн дүгнэсэн.

Хяналтын шатны шүүхээс “А” ХХК-ийг ИХ-ийн 413.1-т заасан худалдааны зуучлагч хэмээн үзсэн боловч “А” ХХК-ийн байгуулсан гэрээг ИХ-ийн 410.1-т заасан зуучлалын гэрээ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, худалдааны зуучлагчийн хувьд ИХ-ийн 413-т заасан тусгай зохицуулалт үйлчлэх учиртай юм.

Энэ төрлийн харилцааг тодорхойлоход тээвэр зуучлагч болон тээвэрлэгчийн хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан уу? эсхүл зуучлуулагч болон тээвэрлэгч хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан уу? гэдэг нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, зуучлуулагч болон тээвэрлэгч хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан тохиолдолд зуучлуулагч болон зуучлагчийн хооронд худалдааны зуучлалын гэрээ байгуулагдсан хэмээн үзэх боломжтой болно.

Харин маргааны харилцааг үнэлбэл тээвэр зуучлагч нь ачаа тээвэрлэлтийг иж бүрэн зохион байгуулах, цаашид өөрийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах тээвэрлэгч этгээдийг сонгох,

гаалийн талбайд буусан барааны хадгалалт, хамгаалалтыг хариуцах, гаалийн бүрдүүлэлт хийлгэхэд туслалцаа үзүүлэх гэх зэрэг нэмэлт үйлчилгээ үзүүлэхээр харилцан тохиролцсон нь гэрээний талуудын хооронд илгээмжийн гэрээ эсхүл тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүссэн гэж үзэж болохоор байна.

Д. “П” ХХК-д холбогдох УДШ, 2017/03/28, №001 тоот тогтоол (ХТ2017/00351)

Хэргийн товч агуулга:

“П” ХХК нь “А” ХХК-тай 2014 оны 7 дугаар сарын 21-ний өдөр “Тээвэр зуучийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан. Уг гэрээний дагуу “П” ХХК нь “А” ХХК-ийн 10 чингэлэг ачааг АНУ-аас тээвэрлэн Улаанбаатар хотод авчрах, “А” ХХК нь ачааг хүлээн авч, тээврийн хөлс болон нэмэлт зардлыг төлөхөөр харилцан тохиролцсон. Улмаар “А” ХХК нь эхний 5 чингэлэг ачааг хүлээн авч, хөлсийг төлсөн боловч дараагийн 5 чингэлэг ачааны тээврийн хөлс, нэмэлт зардлыг төлөөгүй, үүний 2 чингэлэг ачааг огт хүлээн аваагүй. Иймд “П” ХХК нь тээврийн хөлсний үлдэгдэлам.доллар буюу нэхэмжлэл гаргах үеийн ханшаартөгрөг, нэмэлт зардал болох гаалийн хадгаламжийн төлбөртөгрөг, алдангитөгрөг, нийттөгрөгийг гаргуулахаар “А” ХХК-аас нэхэмжилсэн. “А” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрсөн.

Үйл баримтын хүрээнд 1) талуудын хооронд 2014 оны 7-р сарын 21-ний өдөр тээвэр зуучлалын үйлчилгээний гэрээ байгуулагдсан, уг гэрээний дагуу “П” ХХК нь “А” ХХК-ийн АНУ-аас авах 10 чингэлэг ачааг тээвэрлэн Улаанбаатар хотод авчирч өгөх үүрэг хүлээж, “А” ХХК нь ачааг хүлээн авч, үнийг төлөх үүрэг хүлээсэн, 2) талууд 2016 оны 12-р сарын 31-ний өдөр тооцоо нийлж, хариуцагч ньтөгрөгийн өртэй байгааг баталгаажуулсан, 3) “А” ХХК ачаагаа бүрэн хүлээж

аваагүйн улмаас үлдэгдэл ачааны гаалийн хадгаламжийн төлбөр, чингэлэг түрээсийн төлбөрийг “П” ХХК төлсөн, 4) гэрээний 2.1.1-т: “захиалсан тээвэрлэлттэй холбоотой төлбөр тооцоо болон нэмэлт зардлын хураамжийг тээвэрлэгчид төлөх”, 2.2.4-т: “зуучийн гаргасан нэхэмжлэхийн дагуу тээврийн хөлс, нэмэгдэл зардлууд болон зуучлалын хөлсийг үнийн саналд заасан хугацаанд төлөх”, 2.2.6-д: “үйлчлүүлэгч ачааны гаалийн бүрдүцлэлтийг түргэн шуурхай хийж, гаалийн бүрдүцлэлт хийх хугацаанд гарсан хадгаламж, тээврийн хэрэгслийн түрээс болон бусад холбогдох зардлыг хариуцан төлөх”, 3.3-т: “үйлчлүүлэгч ачааг Улаанбаатар дахь гаалийн хяналтын талбайгаас хүлээн авахаас өмнө төлбөрийг бүрэн барагдуулсан байх” гэж талууд тус тус тохиролцсон байх боловч “А” ХХК нь эдгээр үүргээ биелүүлээгүй болох нь нотлогдсон байна.

Шийдвэрийн агуулга:

Анхан шатны шүүхээс талуудын хооронд байгуулагдсан гэрээ нь ИХ-ийн 413.1-т заасан зохицуулалтад нийцэж байна гэж үзсэн. Талуудын хооронд хийгдсэн гэрээний 3.4-т тохирсон байх тул нэхэмжлэгчийн шаардсан алдангийг хариуцагч төлөх үндэслэлтэй байна. Хариуцагч “А” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэх тайлбарыг шүүхэд өгсөн боловч энэхүү тайлбараа баримтаар нотлоогүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаанд тооцоо нийлэх хангалттай хугацаа байсан гэж үзэхээр байна. Нэхэмжлэгчийн тооцооны алдаанаас илүү нэхэмжилсэн ...төгрөгийг нэхэмжлэлийн шаардлагын дүнгээс хасаж, “А” ХХК-аастөгрөгийг гаргуулан “П” ХХК-д олгож шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журмын зөрчсөний улмаас шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх ИХШХШХ-ийн 116.2-т заасан шаардлагыг хангаагүй байна гэж үзсэн.

Тодруулбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд хэргийн оролцогчийн эдлэх эрх, үүргийг тайлбарласан баримтгүй, хэрэгт авагдсан нотлох баримтуудыг хариуцагчид танилцуулсан баримтгүй байгаа нь ИХШХШХ-ийн 67.1.1-т заасан ажиллагаа хангалттай хийгдсэн гэж үзэхгүй. Нэхэмжлэгчийн хүсэлтээр, хариуцагчийн эзгүйд шийдвэрлэсэн нь ИХШХШХ-ийн 100.3-д нийцэх боловч хэрэгт авагдсан нотлох баримтуудыг хариуцагчид танилцуулсан баримтгүй байна. Энэ нь шүүхийн өмнө талуудын эрх тэгш байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлэх талаар зохицуулсан ИХШХШХ-ийн 4.1, 6-д заасантай нийцэхгүй байна гэж дүгнэсэн.

Улмаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан.⁴⁹

Хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцсэн байх тул магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн.⁵⁰

Дүн шинжилгээ:

Анхан шатны шүүхээс талуудын хооронд ИХ-ийн 413.1-д заасан худалдааны зуучлагчийн гэрээний харилцаа үүссэн гэж үзсэн. Харин давж заалдах болон хяналтын шатны шүүхээс талуудын хооронд байгуулагдсан гэрээний төрлийг тодорхойлж дүгнэлт хийгээгүй.

Маргаан бүхий харилцааг авч үзвэл “П” ХХК нь “А” ХХК-

⁴⁹ “П” ХХК-ийн нэхэмжлэлтэй “А” ХХК-д холбогдох Баянгол дүүргийн иргэний хэргийн 2016.10.21-ний өдрийн №5489 тоот шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.01.16-ны өдрийн №199 тоот магадлал.

⁵⁰ Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2017.03.28-ны №001/ХТ2017/00351 тоот тогтоолоор хэргийг дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн боловч дахин хэлэлцсэн талаар шүүхийн шийдвэр www.new.shuukh.mn вэбсайтад байршаагүй байна.

ийг зөвхөн АНУ-аас ачааг Монгол улсад тээвэрлэгдэн ирэх хүртэлх тээвэрлэлтийг зохион байгуулах үүргийг хүлээсэн гэж үзэхээр байна.

Энэ төрлийн харилцааг тодорхойлоход тээвэр зуучлагч болон тээвэрлэгчийн хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан уу эсхүл зуучлуулагч болон тээвэрлэгч хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан уу гэдэг нь чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, зуучлуулагч болон тээвэрлэгч хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан тохиолдолд зуучлуулагч болон зуучлагчийн хооронд худалдааны зуучлалын гэрээ байгуулагдсан хэмээн үзэх боломжтой болно.

Гэвч шүүхийн шийдвэрт энэ талаар тодорхой дурдаагүй байх бөгөөд үйл баримтын хүрээнд авагдсаны дагуу “П” ХХК нь “А” ХХК-ийн АНУ-аас авах 10 чингэлэг ачааг тээвэрлэн Улаанбаатар хотод авчирч өгөх үүрэг хүлээж, “А” ХХК нь ачааг хүлээн авч, үнийг төлөх үүрэг хүлээснээс үзэхэд “П” ХХК болон “А” ХХК нарын хооронд тээвэрлэлтийн гэрээ хийсэн хэмээн дүгнэж болохоор байна.

Е. “С” ХК-д холбогдох УДШ, 2016/06/28, №001 тоот тогтоол (ХТ2016/00841)

Хэргийн товч агуулга:

“С” ХК болон “Х” ХХК-ийн хооронд 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр №13/29-13/42 дугаартай “Тээвэрлэлтийн гэрээ” байгуулагдсан. Уг гэрээний дагуу “С” ХК нь “Х” ХХК-ийн ачааг БНСУ-аас зуучлан тээвэрлэх, “Х” ХХК нь тээвэрлэлтийн төлбөрийг ачаа эцсийн хүргэх газарт ирэхээс өмнө бүрэн төлсөн байхаар харилцан тохиролцсон. Гэвч “Х” ХХК нь “С” ХК-аар 2013, 2014 онд зуучлуулан тээвэрлүүлсэн чингэлгийн тээвэрлэлтийн үлдэгдэл төлбөр болохам.долларыг төлөлгүй гэрээний үүргээ зөрчсөн. Иймд “Х” ХХК-аас гэрээний үүрэгт

.....ам.доллар буюу Монголбанкны албан ёсны ам.долларын төгрөгтэй тэнцэх ханшаар тооцожтөгрөг гаргуулахаар нэхэмжилсэн. “Х” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй. Улмаар 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №13/29-13/42 дугаартай “Тээвэрлэлтийн гэрээ”-үүдийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцуулах, гэрээгүй нийлүүлсэн ачааны төлбөртөгрөгийн үнийн дүнг хүчингүй болгуулахаар сөрөг нэхэмжлэл гаргасан.

Үйл баримтын хүрээнд талуудын хооронд 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №13/29-13/42 дугаартай “Тээвэрлэлтийн гэрээ”-үүд байгуулагдсан, тус гэрээгээр ачаа тээврийн зуучлагч нь үйлчлүүлэгчийн ачааг тээвэрлэхтэй холбогдон иж бүрэн зохион байгуулалтын болон хууль ёсны үйлчилгээг үйлчлүүлэгчид үзүүлэх, үйлчлүүлэгч нь ачаа тээвэр зуучлагчид хөлс төлөх үүргийг хүлээхээр заасан, хариуцагч “Х” ХХК ньам.долларын үлдэгдэлтэй болохыг баталгаажуулах тухай №15/6 дугаартай тооцоо нийлсэн акт хийсэн нь хэрэгт авагдсан байна.

Шийдвэрийн агуулга:

Анхан шатны шүүхээс ИХ-ийн 413.1-д заасныг баримтлан “Х” ХХК-аасам.долларыг гаргуулан “С” ХК-д олгохоор нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Мөн сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.⁵¹

Хяналтын шатны шүүхээс хэргийндугаар талд

⁵¹ “С” ХК-ийн нэхэмжлэлтэй “К” ХХК-д холбогдох Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.02.16-ны өдрийн №102/ШШ2016/01340 тоот шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.05.03-ны өдрийн 864 дүгээр магадлалтай. Шийдвэр, магадлал нь www.shuukh.mn сайтад байршаагүй.

авагдсан.....дугаартай гэрчилгээ нь нэхэмжлэгч компанийн гэрчилгээ гэж үзэх үндэслэлгүй байхад хүсэлтийг хангахаас татгалзсан нь ИХШХШХ-ийн 38.6-д заасан нотлох баримт бүрдүүлэх үүргээ шүүх биелүүлээгүй гэж үзнэ. Зохигчид өөрсдийн шаардлага, татгалзлын үндэслэлээ нотлох баримтыг өөрөө бүрдүүлэх үүрэгтэй ба энэ үүргээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасныг үндэслэлгүйгээр татгалзсан нь хэргийн оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн, мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэх боломж олгоогүй, шүүх нотлох баримтыг дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн гэж үзэхээр байна. Нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн этгээдийн нэрийг орчуулсан орчуулга хоорондоо зөрүүтэй байгаа нь нотлох баримт эргэлзээ бүхий байна гэж үзэх тул үнэлэх боломжгүй байна. Нэхэмжлэгч нь хувьцаат компани эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компанийн алин болох, тэрээр хэрэгт авагдсан тээвэрлэлтийн гэрээний нэг тал болсон, мөн гэрээнд дардсаа дарсан ХХК мөн эсэх нь тодорхойгүй байна гэж тус тус дүгнэсэн. Улмаар шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах нь зүйтэй гэж үзсэн.

Дүн шинжилгээ:

Анхан болон давж заалдах шатны шүүхээс талуудын хооронд ИХ-ийн 413.1-т заасан худалдааны зуучлагчийн гэрээний харилцаа үүссэн гэж үзжээ. Харин хяналтын шатны шүүхээс талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцааны талаар дүгнэлт хийгээгүй.

Хэрэгт авагдсан үйл баримт болох 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн гэрээний 1.1 дэх заалтаас үзвэл “С” ХК нь “Х” ХХК-ийн ачааг тээвэрлэхтэй холбогдон иж бүрэн зохион байгуулалтын болон хууль ёсны үйлчилгээг үзүүлэх, “Х” ХХК нь зохих хөлсийг төлөхөөр харилцан тохиролцсон байна.

Талуудын хооронд хийгдсэн гэрээний агуулгаас дүгнэвэл “С” ХК болон “Х” ХХК нарын хооронд тээвэрлэлтийн гэрээ, “С” ХК болон бусад тээвэрлэгч нарын хооронд бие даасан тээвэрлэлтийн гэрээ байгуулсан үзэх боломжтой байна. Мөн уг харилцаа нь илгээмжийн гэрээний төрөлд хамаарах эсэхэд хариулт өгөхийн тулд шүүхээс гэрээний тал болон зардлын талаарх үйл баримтыг үнэлэх шаардлагатай.

2.1.2 Дүгнэлт

Шүүхийн практикт ИХ-ийн 413.1-т заасан “Худалдааны зуучлагчийн гэрээ”-гээр зүйлчлэгдэж маргааны хүрээнд тээвэр зуучлагчийн харилцаа зонхилж байна (А-Е үзнэ үү).

Онолын үүднээс авч үзвэл тээвэр зуучлагчийн харилцаа нь худалдааны зуучлагчийн гэрээ, илгээмжийн гэрээ, эсхүл тээвэрлэлтийн гэрээнд хамаарах боломжтой юм. Хэрэв тээвэр зуучлагчийн зүгээс гэрээний харилцаанд тээвэрлүүлэгч болон тээвэрлэгчийн хооронд байгуулах тээвэрлэлтийн гэрээнд зуучлах чиг үүрэгтэйгээр оролцсон тохиолдолд худалдааны зуучлагчийн гэрээний харилцаа яригдаж болно (Тайлангийн нэгдүгээр бүлэг, нэгдүгээр хэсэг). Бусад тохиолдолд буюу тээвэр зууч нь өөрийн нэрийн өмнөөс тээвэрлэгчтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулсан бол тээвэрлэлтийн гэрээ эсхүл үйл баримтаас хамааран илгээмжийн гэрээний харилцаа яригдана.

Тээвэр зуучийн харилцаанд тээвэр зуучлагчийн зүгээс өөрийн нэрийн өмнөөс, бусдын зардлаар гэрээ байгуулах замаар оролцож байгаа тохиолдолд илгээмжийн гэрээний харилцаа үүсэх учиртай (Тайлангийн нэгдүгээр бүлэг, гуравдугаар хэсэг, 3). Харин Монгол Улсын бизнесийн практик буй тээвэр зуучийн харилцааны хүрээнд тээвэр зуучлагч нь тээвэрлүүлэгчтэй ачаа тээврийн гэрээ байгуулж, улмаар уг ач тээврийн гэрээний үүргийг биелүүлэх үүднээс бусад тээвэрлэг-

чидтэй ач тээврийн гэрээ байгуулж ажиллах харилцаа зонхилж байна.

Улмаар тээвэр зуучийн харилцааны хүрээнд илгээмжийн гэрээнээс гадна тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсан гэж үзэх боломж байна. Илгээмжийн гэрээ хэмээн дүгнэх үүднээс Б.Буянхишиг “Тээвэр зуучийн гэрээг зохицуулах хууль хэрэглээний асуудал”, “Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” судалгааг хийжээ⁵².

Гэвч тээвэрлэлтийн гэрээ нь өөрийн тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэхийг шаардахгүйгээс гадна тээвэр зуучийн компани болон тээвэрлэгч нарын хооронд бие даасан тээвэрлэлтийн гэрээ байгуулагдах тохиолдолд байдгийг анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, шүүхээс гэрээний төрлийг оновчтой тодорхойлохын тулд маргааны үйл баримтыг илүү тодорхой үнэлэх шаардлага үүсэж байна.

Иймд тээвэр зуучийн харилцаа нь гэрээний агуулга, шүүхэд авагдсан баримтаас шалтгаалан илгээмжийн гэрээнд хамаарах боломжтой боловч, тээвэрлэлтийн гэрээ ч байгуулагдсан байж болохыг анхаарах шаардлагатай юм.

2.2. КОМИССЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН МАРГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.2.1 Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

ИХ-ийн 415 дугаар зүйлд худалдааны комиссын гэрээний хүрээнд хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 2 маргаан байх бөгөөд эдгээрийг дараах арга зүйн үндсэн дээр сонгон

⁵² Б.Буянхишиг, “Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2021, 43, 43-63 дахь тал.

авлаа. www.new.shuukh.mn вэбсайтаас 2021 оны 6 дугаар 14-ний өдөр “Иргэний хуулийн 415 дугаар зүйл” түлхүүр үгээр хайлт хийхэд нийт 2 шийдвэр гарч ирсэн болно.

А. УДШ, №2019.02.14, №001/ХТ2019/00209 тогтоол

Хэргийн товч агуулга:

“Б” ХХК нь иргэн Б.Б-тай 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдөр №03/52 тоот Гэрээт борлуулагчийн гэрээ, 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр №03/04/35 тоот “Барьцааны гэрээ”-г тус тус байгуулсан. Гэрээт борлуулагчийн гэрээний дагуу иргэн Б.Б нь “Б” ХХК-ийн импортолсон бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, Б.Б нь борлуулалтын орлогоос хамааран тодорхой хувиар урамшуулал олгохоор харилцан тохиролцсон байна.

Гэвч Б.Б нь төгрөгийн бараа бүтээгдэхүүний үнийг төдийгүй буюу борлуулалтын орлогын зарим хэсгийг дутаасан. Иймд “Б” ХХК нь Б.Б-ээс бараа бүтээгдэхүүний үнэ болох төгрөгийг гаргуулж, барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд хандан нэхэмжлэл гаргасан. Хариуцагч Г.Б нь “Б” ХХК болон Б.Б нарын хооронд байгуулсан “Барьцааны гэрээ”-г хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцуулах, барьцааны зүйлийн өмчлөх эрхийн гэрчилгээг Г.Б-д хүлээлгэн өгөхийг даалгуулах тухай сөрөг нэхэмжлэлийг гаргасан.

Үйл баримтын хүрээнд 1). Б.Б нь “Б” ХХК-аас хүлээж авсан бараа бүтээгдэхүүний үнээстөгрөгийг буцаан төлөөгүй, 2). Б.Б нь итгэмжлэлээр барьцаанд тавих эрх олгосон үл хөдлөх эд хөрөнгийг бус өөр эд хөрөнгийг “Б” ХХК-д барьцаалсан зэрэг нь хэрэгт авагдсан байна. Гэвч гурван шатны шүүхийн шийдвэрээс үзэхэд Б.Б нь бараа бүтээгдэхүүнийг борлуулахад “Б” ХХК-ийн нэрийн өмнөөс борлуулж байсан эсвэл өөрийн нэрийн өмнөөс борлуулж байсан эсэх нь тодорхойгүй байна.

Шийдвэрийн агуулга:

Анхан шатны шүүх Б.Б-ээстөгрөгийг гаргуулж “Б” ХХК-д олгох тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэн, сөрөг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.⁵³ Улмаар “Б” ХХК нь импортолсон бараа бүтээгдэхүүнийг борлуулагч Б.Б-д шилжүүлэх, борлуулсан бүтээгдэхүүний үнийн дүнгээс урамшуулал олгохоор, борлуулагч Б.Б нь түүний нэрийн өмнөөс бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, үнийг буцаан төлөхөөр харилцан тохиролцож ИХ-ийн 415.1-д заасан худалдааны төлөөлөгчийн гэрээ байгуулсан байна гэж дүгнэсэн.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Ийнхүү шийдвэрлэхдээ сөрөг нэхэмжлэл нь үндсэн нэхэмжлэлтэй хамааралтай байхад шүүх сөрөг нэхэмжлэлийг үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нь ИХШХШХ-ийн 73.2-д заасантай нийцэхгүй байна. Энэ нь шүүхийн өмнө талуудын эрх тэгш байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлэх талаар зохицуулсан ИХШХШХ-ийн 3, 6-д заасан журмыг хэрэгжүүлсэн гэж үзэхгүй гэжээ. Харин талуудын хооронд үүссэн гэрээний харилцааны талаар дүгнэлт хийгээгүй.⁵⁴

Хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүх хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаахдаа “..сөрөг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь хуульд нийцээгүй” гэж үзсэн нь учир дутагдалтай болжээ. Сөрөг нэхэмжлэл гаргасныг шүүх хүлээн авахаас татгалзахдаа “..сөрөг нэхэмжлэлийг шүүх хуралдаанд гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй” гэжээ.

⁵³ “Б” ХХК-ийн нэхэмжлэлтэй Б.Б-д холбогдох Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.07.16-ны өдрийн №181/ШШ2018/01567 тоот шийдвэр.

⁵⁴ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.09.12-ны өдрийн №1994 тоот магадлал.

Мөн барьцааны зүйл болох уг үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалуулах зөвшөөрөл олгосон нь тодорхой бус, энэ талаарх баримт хэрэгт авагдаагүй байна. Итгэмжлэлд дурдсан орон сууц барьцааны гэрээнд заасан хаягтай тохирохгүй байна. Иймд барьцааны гэрээ нь ИХ-ийн 56.1.8-д заасан зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хүчин төгөлдөр бус хэлцэл бөгөөд эрх зүйн дүгнэлт хийх шаардлагатай болохыг давж заалдах шүүх анхаараагүй байна гэж үзжээ.

Түүнчлэн анхан шатны шүүх хариуцагч Б.Б-ээстөгрөг гаргуулж, нэхэмжлэгчид олгон, барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгосон нь зөв боловч зохигчийн хооронд үүссэн харилцааг үндэслэл бүхий тодорхойлж чадаагүй байна хэмээн дүгнэжээ.

ИХ-ийн 415.2-т “*өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг комисс гэнэ*” гэж тодорхойлсон ба гэрээний агуулга, талуудын тайлбараас үзвэл зохигчийн хооронд комиссын гэрээ байгуулагдсан гэж үзнэ.

Дээрх үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

Дүн шинжилгээ:

Анхан шатны шүүх зохигчийн хооронд ИХ-ийн 415.1-д заасан худалдааны төлөөлөгчийн гэрээний харилцаа үүссэн гэж үзсэн. Давж заалдах шатны шүүхээс талуудын хооронд байгуулсан гэрээний төрлийг тодорхойлж дүгнэлт хийгээгүй байна. Харин хяналтын шатны шүүхээс зохигчийн хооронд ИХ-ийн 415.2-т заасан комиссын гэрээний харилцаа хэмээн дүгнэсэн байна.

ИХ-ийн 415.1-д заасан худалдааны төлөөлөгчийн гэрээний дагуу худалдааны төлөөлөгч нь үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар гэрээ байгуулах буюу бараа, эрх, үйлчилгээг борлуулахад зуучлах үүрэг гүйцэтгэдэг. Харин мөн хуулийн 415.2-т заасан комиссын гэрээ нь өөрийн нэрийн өмнөөс түүний зардлаар бараа бүтээгдэхүүний борлуулахад чиглэсэн арилжааны гэрээ байдаг.

Хэрэгт авагдсан үйл баримтаас үзэхэд Б.Б нь бараа бүтээгдэхүүнийг борлуулахдаа “Б” ХХК-ийн нэрийн өмнөөс түүний зардлаар үйл ажиллагаа явуулж байсан эсвэл өөрийн нэрийн өмнөөс түүний зардлаар үйл ажиллагаа явуулж байсан эсэх нь тодорхойгүй байна.

Мөн Б.Б нь “*өөрийн нэрийн өмнөөс, бусдын зардлаар*” эсвэл “*бусдын нэрийн өмнөөс, бусдын зардлаар*” үйл ажиллагаа явуулж байсан эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгчийн шалгуурыг хангаагүй тохиолдолд арилжаа эрхлэгчид хамаарах худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний зохицуулалт бус даалгаврын гэрээний зохицуулалт үйлчлэх учиртай.

Дээрх тохиолдолд хэрэгт Б.Б-ийг тодорхойлох үйл баримт хангалттай авагдаагүй байх тул Б.Б-ийг арилжаа эрхлэгчийн шалгуурыг хангасан, тогтмол арилжааны үйл ажиллагаа явуулдаг этгээд эсэхийг дүгнэх боломжгүй байна. Иймд “Б” ХХК болон Б.Б-ийн хооронд байгуулсан “*жигжиглэнгийн борлуулагчийн гэрээ*”, Б.Б-ийн хувийн нөхцөл байдлаас шалтгаалан 1). Худалдааны төлөөлөгчийн гэрээ, 2). Комиссын гэрээ эсвэл 3). Даалгаврын гэрээний харилцаа үүссэн байх боломжтой байна.

Б. УДШ, №2019.02.21, №001/ХТ2019/00237 тогтоол

Хэргийн товч агуулга:

“Б.И” ХХК нь М.М-тай гэрээт борлуулагчийн гэрээг байгуулж, М.М нь “Б.И” ХХК-ийн импортолсон бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, борлуулалтын орлогоос хамааран тодорхой хуваарь урамшуулал олгохоор талууд харилцан тохиролцжээ. Гэвч М.М нь борлуулалтын орлогыг төлөөгүй тул “Б.И” ХХК шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Үйл баримтын хүрээнд 1). “Б.И” ХХК нь М.М-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн, 2). “Б.И” ХХК нь М.М-д сар бүр шатахууны мөнгө өгөх, шаардлагатай тохиолдолд бараа борлуулах байрны түрээсийн төлөх зэрэг нөхцөлөөр хангахаар талууд тохиролцсон зэрэг нь хэрэгт авагдсан байна.

Шийдвэрийн агуулга:

Анхан шатны шүүхээс нэхэмжлэгч “Б.И” ХХК нь иргэн М.М-ээс бараа бүтээгдэхүүний төлбөр болон алданги нийт төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.⁵⁵ Харин талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцааг тодорхойлоогүй байна.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй болсон гэж үзсэн. Шүүх талуудын хоорондын эрх зүйн харилцааны төрлийг тодорхойлоогүй байх боловч ИХ-ийн 189.1, 206.1, 232.3, 232.6-г зөрчөөгүй байх тул шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэжээ.⁵⁶

⁵⁵ “Б.И” ХХК-ийн нэхэмжлэлтэй М.М-д холбогдох Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.07.09-ний өдрийн №183/ШШ2018/01694 тоот шийдвэр.

⁵⁶ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.09.05-ны өдрийн №2001 тоот магадлал.

Талуудын хооронд байгуулсан “жигжиглэн борлуулагчийн гэрээ”-нд зааснаар нэхэмжлэгч “Б.И” ХХК-ийн бараа бүтээгдэхүүнийг хариуцагч М.М хариуцан борлуулж, барааны үнийг буцаан төлөхтэй холбоотой харилцаа үүссэн байх ба үүнээс үзэхэд тэдгээрийн хооронд ИХ-ийн 400 дугаар зүйлд заасан даалгаврын гэрээний харилцаа үүссэн гэх үндэслэлтэй. Учир нь нэхэмжлэгчийн бараа бүтээгдэхүүнийг хариуцагч гэрээнд заасан газруудад түгээж, борлуулсан бүтээгдэхүүний үнийг нэхэмжлэгчид хүлээлгэн өгч, зохих хөлс авахаар тохиролцжээ. Өөрөөр хэлбэл, хариуцагч бараа бүтээгдэхүүнийг өөрийн өмчлөл, эзэмшилд шилжүүлэн авч үнийг төлөхөөр тохиролцоогүй байна гэж дүгнэжээ.

Харин хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүх зохигчийн хооронд үүссэн гэрээний харилцааны төрлийг зөв тодорхойлоогүй, шүүх эрх зүйн хувьд алдаатай дүгнэсэн тул энэ үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан байна.

Зохигчийн хооронд 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан “Жигжиглэнгийн борлуулагчийн гэрээ”-гээр хариуцагч М.М нэхэмжлэгч “Б.И” ХХК-ийн импортолсон бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, борлуулалтын орлогоос хамааран тодорхой хувиар урамшуулал олгохоор талууд харилцан тохиролцжээ.

Өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг комисс гэдэг бөгөөд хэрэгт буй баримт, талуудын тайлбараас үзвэл зохигчийн хооронд ИХ-ийн 415.2-т заасан комиссын гэрээ байгуулсан байна.

Зохигчдын хооронд хөдөлмөрийн гэрээний харилцаа үүссэн гэх хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдолд заасан нь үндэслэлгүй байна. “Б.И” ХХК-аас бараа хүлээн авч, түүний

заасан газруудад хүргэх, сарын борлуулалтын хэмжээнээс хамаарч хөлс урамшуулал урьдчилан авч байсан болон хариуцагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг нэхэмжлэгч төлсөн нь зохигчийн хооронд хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүссэнийг нотлохгүй. “Б.И” ХХК нь хариуцагч М.М-т сар бүр шатахууны мөнгө өгөх, шаардлагатай тохиолдолд бараа борлуулах байрны түрээсийг төлөх зэрэг нөхцөлөөр хангахаар талууд тохиролцсон, урамшуулал, нийгмийн даатгал төлсөн нь ИХ-д заасан комиссын гэрээний талаарх зохицуулалтын агуулгатай зөрчилдөхгүй байна хэмээн дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Энэхүү харилцааны хүрээнд анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхээс гэрээний ялгаатай төрлөөр зүйлчилсэн. Эцсийн байдлаар хяналтын шатны шүүхээс комиссын гэрээ байгуулсан гэж үзжээ.

Гэвч хэрэгт авагдсан “Б.И” ХХК нь М.М-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн, сар бүр шатахууны мөнгө өгөх, шаардлагатай тохиолдолд бараа борлуулах байрны түрээсийг төлөх зэрэг нөхцөлийг харилцан тохиролцсон зэрэг үйл баримтаас үзэхэд М.М-ийг бие даасан арилжаа эрхлэгч⁵⁷ хэмээн үзэх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, М.М-ийг арилжаа эрхлэгчийн шалгуурыг хангасан, тогтмол арилжааны үйл ажиллагаа явуулдаг этгээд гэж үзэх боломжгүй тул талуудын хооронд ИХ-ийн 415 дугаар зүйлийн 2-т заасан комиссын гэрээ байгуулсан гэх дүгнэлт нь үндэслэл муутай болжээ.

Харин “Б.И” ХХК болон иргэн М.М нарын хооронд ИХ-ийн 399-д заасан даалгаврын гэрээний харилцаа үүссэн гэж үзэхээр байна. Учир нь давж заалдах шатны дүгнэсний дагуу “Б.И” ХХК-ийн бараа бүтээгдэхүүнийг М.М нь гэрээнд

⁵⁷ Ямар шалгуурыг хангасан этгээдийг “арилжаа эрхлэгч” гэж үзэх вэ гэдгийг хууль тогтоох эсхүл шүүхийн практикаар тодруулах шаардлагатай.

заасан газруудад түгээж, борлуулсан бүтээгдэхүүний үнийг нэхэмжлэгчид хүлээлгэн өгч, зохих хөлс авахаар тохиролцжээ.

Комиссын гэрээ нь арилжааны эрхлэгчийн шалгуурыг хангасан тогтмол арилжааны үйл ажиллагааны явуулдаг этгээдэд чиглэсэн даалгаврын гэрээний тусгай төрөл юм. Өөрөөр хэлбэл, “*өөрийн нэрээр, бусдын зардлаар*” буюу комиссын шинжтэй үйл ажиллагаа арилжаа эрхлэгч бус, иргэн эрхэлж буй тохиолдолд комиссын гэрээний зохицуулалт бус даалгаврын гэрээний зохицуулалт, тодорхой мэргэжлийн ур чадвар шаардаж буй тохиолдолд хөлсөөр ажиллах гэрээний зохицуулалт үйлчлэх учиртай.

2.2.2 Дүгнэлт

Монгол Улсын шүүхийн практикт ИХ-ийн 415.2-т заасан “*комиссын гэрээ*”-ний төрлөөр зүйлчлэгдэж буй маргааны хүрээнд бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн гэрээт борлуулагчийн харилцаа зонхилж байна.

Энэ хүрээнд *Нэгдүгээрт*, шүүхээс гэрээний төрлийг тогтооход борлуулагчийн зүгээс бараа бүтээгдэхүүнийг борлуулахад хэний нэрийн өмнөөс гэрээ байгуулж байгааг чухалчлан авч үзэх ёстой боловч хангалттай дүн шинжилгээг хийгээгүй нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, борлуулагчийн зүгээс бараа бүтээгдэхүүнийг борлуулахад “*өөрийн нэрийн өмнөөс, түүний зардлаар борлуулж байгаа*” эсвэл “*нийлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар борлуулж байгаа*” эсэхийг тодорхой үйл баримтад үндэслэн тодорхой байдлаар дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Хоёрдугаарт, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээ нь арилжаа эрхлэгчид тавигдах шаардлагыг хангасан мэргэшсэн этгээдэд хамаарах зохицуулалтыг агуулах тул борлуулагч

этгээдийн хувийн шинж чанар, тогтмол арилжааны үйл ажиллагаа явуулдаг эсэхэд үнэлэлт өгөх шаардлагатай байдаг.

Гэвч Монгол Улсын хувьд Герман болон Япон улсын ХХ-ийн адилаар арилжаа эрхлэгчийн шалгуурыг хуулиар тогтоогоогүй тул шүүхийн практикт арилжаа эрхлэгчийн аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хамаарах “Комиссын гэрээ”-ний харилцааг иргэний гүйлгээнд хамаарах “Даалгаврын гэрээ” зэрэг бусад ерөнхий нэрлэгдсэн гэрээний харилцаанаас ялган тодорхойлж чадахгүй байна.

Онолын үүднээс авч үзвэл, гэрээт борлуулагчийн харилцаа нь 1). Худалдааны төлөөлөгчийн гэрээ эсвэл комиссын гэрээ, 2) Даалгаврын гэрээний харилцаанд хамаарах боломжтой юм. Худалдааны төлөөлөгч эсвэл комисс гэж үзэх тохиолдолд гэрээт борлуулагчийн хувьд арилжаа эрхлэгчид тавигдах шалгуурыг хангасан байх ёстой.

Тухайлбал, Герман Улсын ХХ-д арилжааны үйл ажиллагааг явуулж буй этгээдийг арилжаа эрхлэгч (герман: *Istkaufmann*) гэж үздэг байна.⁵⁸ Улмаар арилжааны үйл ажиллагааг дараах шалгуурын үндсэн дээр тогтоодог. Үүнд:

⁵⁸ Philipp S. Fischinger, Handelsrecht, 15 (C.F. Müller, 2019).

№	Арилжааны үйл ажиллагаа	Тайлбар
1	Нээлттэй үйл ажиллагаа (Offene Tätigkeit)	Гадагш чиглэсэн буюу зах зээлд аж ахуйн үйл ажиллагаагаа санал болгох
2	Төлөвлөгөөтэй үйл ажиллагаа (Planmäßige Tätigkeit)	Үйл ажиллагаа нь төлөвлөгөөтэй үргэлжилсэн шинжтэй байх
3	Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа (Planmäßige Tätigkeit)	Үйл ажиллагаа нь хуулиар хориглосон, нийтийн зан суртахуунд харшлаагүй байх
4	Ашиг олоход чиглэсэн үйл ажиллагаа (Auf Gewinnerzielung gerichtet /h.M./)	Ашиг олох зорилготой байх нь чухал бөгөөд бодитоор ашиг олох эсэх нь хамааралгүй
5	Selbstständige Tätigkeit – Бие даасан үйл ажиллагаа	Үйл ажиллагаагаа хэзээ явуулах, хаана явуулах, ямар агуулгаар явуулахаа бие даан шийдэж байх ⁵⁹

Монгол Улсын ИХ-д “аж ахуйн үйл ажиллагаа” гэдгийг нарийвчлан тодорхойлоогүй боловч ИХ-ийн 413.1-д дахь хэсэгт “Аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдах-худалдан авах, даатгал, тээвэр, эд хөрөнгө хөлслөх, эсвэл худалдааны бусад үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн байдаг.

⁵⁹ Ханнс Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи, Арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, судалгааны тайлан, 2019, 5-6 дахь тал.
https://mongolia.hss.de/fileadmin/user_upload/Projects_HSS/Mongolia/Dokumente/2019/HGB_Studie.pdf

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын шүүхийн практикт худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээг өөр хооронд нь болон бусад төсөөтэй гэрээнээс ялгаж чадахгүй байгаа бөгөөд цаашид эдгээрийн хэрэглээг нэр мөр болгох асуудал тун чухал байна.

Нэгдүгээр бүлэгт, худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний үндсэн ойлголт, төсөөтэй гэрээний төрлөөс ялгах, гэрээний тусгай төрлийг авч үзэв. Энэхүү гурван төрлийн гэрээний гол ялгаа нь гэрээний тал хэн байгаа эсэх, бараа үйлчилгээний зардлыг хэн гаргаж байгаа эсэхэд оршиж байна. Өөрөөр хэлбэл, комиссын гэрээний хувьд комисс өөрийн нэр дээр гэрээ байгуулж, бусдын зардлаар бараа үйлчилгээ үзүүлдэг бол төлөөлөгч нь бусдын нэр дээр гэрээ байгуулж, бусдын зардлаар бараа үйлчилгээ үзүүлдэг байна. Харин худалдааны зуучлагч нь тодорхой бараа үйлчилгээг үндсэн арилжаа үйл ажиллагааг болгон тухайн чиглэлээр гэрээний хоёр талыг холбож, гэрээ байгуулахад зуучлах үйл ажиллагааг явуулна.

Хоёрдугаар бүлэгт, худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний маргаанд хамаарах шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Худалдааны төлөөлөгчийн гэрээний хувьд даатгалын төлөөлөгчийн гэрээнд хамаарах бизнесийн практик түгээмэл байгаа боловч уг судалгааны шүүхийн шийдвэрийг хайх арга зүйн хүрээнд худалдааны төлөөлөгчийн гэрээнд холбогдох шүүхийн шийдвэр олдоогүй болно.

Харин худалдааны зуучлагчийн гэрээний маргаанд хамаарах шүүхийн 6 шийдвэр, комиссын гэрээний маргаанд хамаарах шүүхийн 2 шийдвэрийг уг судалгааны дурдсан арга зүйн үндсэн дээр сонгон авч дүн шинжилгээ хийв. Тодруулбал, худалдааны зуучлагчийн гэрээний маргааны хүрээнд тээвэр зуучлагчийн харилцаа зонхилж байгаа бол комиссын гэрээний маргааны хүрээнд жижиглэнгийн гэрээт борлуулагчийн харилцаа зонхилж байна. Эдгээр маргааны дийлэнх нь гэрээний төрлийг тодорхойлоход чиглэж байна.

Хяналтын шатны шүүхээс худалдааны зуучлагчийн гэрээний төрлөөр зүйлчилсэн тээвэр зуучлагчийн харилцаа нь гэрээний агуулга, үйл баримтаас шалтгаалан илгээмжийн гэрээ эсвэл тээвэрлэлтийн гэрээний төрөлд хамаарахаар байна (2.2.). Тээвэр зуучлагчийн харилцааны хүрээнд худалдааны зуучлагчийн гэрээ болон илгээмж, тээвэрлэлтийн гэрээний ялгаа нь тээвэрлэлтийн улмаас учирсан хохирлыг тээвэрлүүлэгч хүлээх, илгээгч, тээвэр зууч хүлээх эсэхэд оршино. Өөрөөр хэлбэл, тээвэр зуучлагч нь тээвэрлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний ачаа барааг тээвэрлүүлэх тохиолдолд худалдааны зууч (тээвэр зууч)-ийн гэрээний харилцаа үүсэх бөгөөд тээвэрлэлтийн улмаас үүссэн хариуцлагыг тээвэрлэгч хүлээнэ. Харин тээвэр зуучлагч өөрийн нэрийн өмнөөс, түүний ачаа барааг тээвэрлүүлэх тохиолдолд илгээмж эсвэл тээвэрлэлтийн гэрээний харилцаа үүсэх боломжтой болно.

Мөн хяналтын шатны шүүхээс комиссын гэрээний төрлөөр зүйлчилсэн жижиглэнгийн гэрээт борлуулагчийн харилцааг эрх зүйн онолын үүднээс авч үзвэл, худалдааны төлөөлөгчийн гэрээ эсвэл даалгаврын гэрээний төрөлд хамаарах боломжтой байна (2.1.). Жижиглэнгийн гэрээт борлуулагчийн харилцааны хүрээнд худалдааны төлөөлөгч болон комиссын гэрээний ялгаа нь бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тал тодорхой эсэх, бараа бүтээгдэхүүний худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн үр

дагаврыг жижиглэн борлуулагч хүлээх эсэхэд оршино. Өөрөөр хэлбэл, тодорхой этгээдээс бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, түүний нэрийн өмнөөс борлуулах тохиолдолд худалдааны төлөөлөгчийн гэрээний харилцаа үүснэ. Харин тодорхой бус этгээдээс бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, өөрийн нэрийн өмнөөс борлуулах тохиолдолд комиссын гэрээний харилцаа үүсэх боломжтой болно.

Түүнчлэн жижиглэнгийн борлуулагчийн харилцааны хүрээнд худалдааны төлөөлөгч эсвэл комисс гэрээний шинжтэй харилцаа үүссэн эсэхээс үл хамааран тухайн борлуулагчийн хувьд арилжаа эрхлэгчид тавигдах наад захын шалгуурыг хангаагүй тохиолдолд даалгаврын гэрээний төрлөөр зүйлчлэх нь зүйд нийцэхээр байна. Учир нь худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний зохицуулалт нь мэргэшсэн арилжаа эрхлэгчид чиглэсэн бөгөөд иргэний эрх зүйн харилцааны оролцогчтой харьцуулахад арилжаа эрхлэгчийн хувиар тухайлсан эрхийг эдэлж, үүргийг хүлээсэн байдлаараа онцлог юм.

Ийнхүү шүүхээс худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний харилцааг өөр хоорондоо ялгаатай байдлаар зүйлчилж байгаа нь 1). иргэний хэргийн шүүхэд үйл баримтыг тодорхой болгох урьдчилсан хурлын үе байхгүй байгаатай холбоотойгоор гэрээний талууд нь хэн болох, хэний зардлаар үйл ажиллагаа явуулж буй эсэхийг тогтоож чадахгүй, 2). арилжаа эрхлэгчээр тогтоох шалгуур байхгүйгээс шалтгаалан хувь иргэний зарим төрлийн үйл ажиллагааг комиссын гэрээний хүрээнд авч үзэх боломж бүхий эрх зүйн орчны сулд байдалд байж болно.

Цаашид энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхдээ шүүхээс дараах зүйлсийн анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний тал тодорхой эсэх, гэрээний эрх зүйн үр

дагаврыг хэн хүлээж байгаа эсэхийг чухалчлан шалгах шаардлагатай (Хүснэгт 1);

- Худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээг өөр хооронд ялгахаас гадна худалдааны төлөөлөгчийг худалдааны төлөөллөөс ялгах, комисс (илгээмж)-ын гэрээг тээвэрлэлтийн гэрээнээс ялгах асуудлыг анхаарах хэрэгтэй. Тиймээс тээвэр зуучийн харилцааны хүрээнд илгээмж гэрээ болон тээвэрлэлтийн гэрээ тогтоохдоо гэрээний агуулга, үйл баримтыг сайтар тогтоосны үндсэн дээр ялгах нь чухал байна.
- Худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний шинжтэй харилцаа үүссэн эсэхээс үл хамааран тухайн этгээдийн хувьд арилжаа эрхлэгчид тавигдах шаардлагыг хангаж буй эсэхэд анхаарах шаардлагатай. Энэ хүрээнд өнөөгийн нөхцөл байдалд гарц хайвал Монгол Улсын ИХ дахь “*аж ахуйн үйл ажиллагаа*”-г тодорхойлсон шалгуурыг авч хэрэглэж болох юм;
- Даатгалын зуучлагч, үл хөдлөх хөрөнгө зуучлагчийн харилцаанд худалдааны зуучлагчийн зохицуулалтыг хэрэглэх (Нэгдүгээр бүлэг, нэгдүгээр хэсэг 3);
- Даатгалын төлөөлөгч, үл хөдлөх хөрөнгийн зуучлагчийн харилцаанд худалдааны төлөөлөгчийн гэрээний зохицуулалтыг хэрэглэх (Нэгдүгээр бүлэг, хоёрдугаар хэсэг 3);
- Үнэт цаасны брокер, илгээмж (практикт тээвэр зуучлагч гэх нь бий)-ийн харилцаанд комиссын гэрээний зохицуулалтыг хэрэглэх (Нэгдүгээр бүлэг, гуравдугаар хэсэг 3).

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Ном, өгүүлэл, бусад эх сурвалж

1. Б.Амарсанаа, Г.Давааням бусад, Арилжааны эрх зүй, УБ, 2022.
2. ШЕЗ, Ханс Зайдел, Иргэний хэргийн шүүхэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан, 2021
3. Philipp S. Fischinger, Handelsrecht (C.F Müller, 2019);
4. Hatada Koumei et al., Lecture on commercial trade law (Chuuoukeizaishya., 2018);
5. Julia Cesar Rivera, The Scope and structure of civil codes (2013);
6. Ootsuki Toshie, A Study on Agent Commercial, The Chuo-Gakuin University Rev., of Economic & Commerce (1993);
7. Mathias m. Siems, The Divergence of Austrian and German Commercial Law: What Kind of Commercial Law Do We Need in a Globalised Economy?, OPINION: I.C.C.L.R. 273 (2004) ;
8. Kitai et al, Minpou to tsunagaru Shouhou, Shoukouei (Shoujihoumu, 2013) ;
9. Randy E. Barnett, Squaring undisclosed agency law tih contract theory, 75 Calif. L. Rev. 1969 (1987)
10. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ, 2013 (Соёмбо, 3 дахь хэвлэл,) ;
11. Б.Амарсанаа нар, Арилжааны хуулийн хэрэгцээ, ШААРДЛА-ГЫГ урьдчилан тандан судлах, судалгааны тайлан, УБ, 2020;
12. Б.Хатантуул, Гэрээний загварын эмхэтгэл, МҮХАҮТ-ын

- дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр, УБ, 2020;
13. Европ бус нутгийн худалдааны төлөөлөгчийн байдал, чиг үүрэг-борлуулалтын сувгаа өргөжүүлэх арга болох уу [<http://www.ichgmbh.com/whats-new/2013/07/16/167>];
 14. 小町谷操三『商行為法論』（有斐閣 1943年）；
 15. 江頭憲治郎『商取引法』（成文堂 第8版 2018年）；
 16. 竹田省『商行為法』（弘文堂書房 1931年）；
 17. 落合誠一など『商法1』（有斐閣 第3版 2008年）；

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол улсын Даатгалын тухай хууль, 2004;
2. Монгол улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013;
3. ХБНГУ-ын Иргэний хууль 1896;
4. ХБНГУ-ын Худалдааны хууль 1897;
5. Япон Улсын Иргэний хууль 1986;
6. Япон Улсын Худалдааны хууль 1989;
7. Япон Улсын Орон сууц, газар, барилгын арилжааны хууль, 1952;
8. Монгол Улсын стандарт “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ” MNS 5346:2017 стандарт, 2017.12.22-ны тоот тогтоол [<https://estandard.gov.mn/standard/reader/5560>];
9. УДШ, 2016/06/28, №001/ХТ2016/00841 тогтоол;
10. УДШ, 2017.03.28, №001/ХТ2017/00353 тогтоол;
11. УДШ, 2017/01/31, №001/ХТ2017/00101 тогтоол
12. УДШ, 2017/03/28, №001/ХТ2017/00351 тогтоол
13. УДШ, 2018.03.06, №001/ХТ2018/00374 тогтоол
14. УДШ, 2019.05.31, №001/ХТ2019/00834 тогтоол
15. УДШ, №2019.02.14, №001/ХТ2019/00209 тогтоол
16. УДШ, №2019.02.21, №001/ХТ2019/00237 тогтоол

17. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.05.03-ны өдрийн №864 тоот магадлал
18. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.11.11-ний өдрийн №1855 тоот магадлал
19. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.12.09-ний өдрийн №210/МА2016/2020 тоот магадлал
20. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.01.16-ны өдрийн №199 тоот магадлал
21. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.09.05-ны өдрийн №2001 тоот магадлал
22. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.09.12-ны өдрийн №1994 тоот магадлал
23. Баянгол дүүргийн Иргэний хэргийн 2016.10.21-ний өдрийн №5489 тоот шийдвэр
24. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.02.16-ны өдрийн №102/ШШ2016/01340 тоот шийдвэр
25. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.07.29-ний өдрийн №181/ШШ2016/00407 тоот шийдвэр
26. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.11.27-ны өдрийн №102/ШШ2016/01726 шийдвэр
27. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.07.16-ны өдрийн №181/ШШ2018/01567 тоот шийдвэр
28. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.10.10-ны өдрийн №00899 тоот шийдвэр
29. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.07.09-ний өдрийн №183/ШШ2018/01694 тоот шийдвэр.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M, MBA)

Өмгөөллийн DB>S ХХН-ийн гишүүн хуульч



Өмгөөллийн DB>S ХХН-ийн Гүйцэтгэх захирал тэрээр Монголын санхүү, банк, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтний нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний хувийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа. Түүнээс өмнө Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажиллахын зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Билиг” дээд сургуульд хичээл зааж байсан түршлагатай. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавр, АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн. Chambers & Partners, Legal500, IFLR зэрэг олон улсын хуульчдын зэрэглэл тогтоодог байгууллагаас Д.Золжаргал, түүний удирдаж ирсэн хуулийн фирмийг олон жилийн турш өндрөөр үнэлсэн байдаг.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн Хууль зүйн сургуульд төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг дүүргэж, БНСУ-ын Күүкмений Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 23 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оны 11 дүгээр сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын чиглэлээр мэргэшин судалдаг ба практик болон судалгааны байгууллагад 20 жил ажилласан туршлагатай. Цагдаагийн академийг эрх зүйч, Хүмүүнлэгийн ухааны Их сургуулийг англи хэл-менежерийн бакалавр зэрэгтэй төгсөж, 2007 онд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Түүнчлэн академик болон бодлогын судалгааны чиглэлээр дангаар, бусадтай хамтран 40 орчим судалгааны ажил, 20 гаруй сурах бичиг, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон. Хуульч, хууль сахиулагчийг чадавхжуулах хүрээнд 10 орчим жил сургагч багшаар ажиллаж байна.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)



Тэрээр хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кьюсюгийн Их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан. Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

ISBN 978-9919-9926-7-5



9 789919 992675